



МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН 20 ЖИЛ



Улаанбаатар хот

2014

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ГХЯ-НЫ ДИПЛОМАТ АКАДЕМИ

**Монгол Улсын Гадаад бодлогын анхны
үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн
ойд зориулсан эрдэм шинжилгээний
бага хурлын материал**

Эмхэтгэж, хянан нягталсан Л.Удвал

**Конрад Аденауэр сангийн Улаабаатар дахь суурин төлөөлөгчийн газар,
Монгол-Германы Чуулган ТББ,
Монголын Элчин сайд нарын клубын дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.**

ISBN

Гарчиг

Өмнөх үг.....	5
Бага хурлын хөтөлбөр.....	6
Дипломат Академийн захирал, ТҮГЭС, ОББЭЭС, Др. Х.Бэхбат-Нээлтийн үг.....	9
Монгол Улсын ГХ-ны сайд Л Болд-Илгээлт.....	10
УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын хэлсэн үг.....	12
ГХЯ-ны БТСГ-ын зөвлөх доктор, дэд профессор Г.Төмөрчулуун- Үндсэн илтгэл: 1994 оны Гадаад бодлогын анхны Үзэл баримтлалд дүн шинжилгээ хийхүй: “Монголын орчин цагийн гадаад бодлогын дөрвөн “Де”-гийн чиг шугам”	15
Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Монгол Германы Чуулганы тэргүүн, академич П.Очирбат-Дурсамж.....	22
ГЯЯ-ны сайд асан, МУСГЗ, ОББЭЭС Ц.Гомбосүрэнгийн хэлсэн үг.....	25
УИХ-ын гишүүн, Др.М.Батчимэгийн хэлсэн үг.....	33
Нийтлэлч Б.Батбаяр/Баабар/-ын хэлсэн үг.....	38
Гадаад харилцааны сайдын зөвлөх О.Машбатын хэлсэн үг.....	42
ГХЯ-ны Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд, Др.Ж.Энхсайханы хэлсэн үг.....	44
ГХЯ-ны БТСГ-ын захирал, Др.Ц.Батбаярын хэлсэн үг.....	47
ГЯЯ-ны Тэргүүн дэд сайд асан, ОББЭЭС, Др.Ж.Чойнхорын хэлсэн үг.....	51
ОББЭЭ, Проф, Др.Д.Баярхүүгийн хэлсэн үг.....	55
БХЭШХ-ийн судлаач, дэслэгч генерал, Проф. Ц.Дашзэвэгийн хэлсэн үг.....	62
ГЯЯ-ны дэд сайд асан, ОББЭЭС. Ч.Баатарын хэлсэн үг.....	68
ОББЭЭ, Др. Ж.Гөлгөөгийн хэлсэн үг.....	72

ОУСХ-гийн зөвлөх, Др. Л.Хайсандайн хэлсэн үг.....	77
Ахмад дипломат, ОББЭЭС. И.Очирбалын хэлсэн үг.....	80
Элчин сайд асан, Др. В.Энхболдын хэлсэн үг.....	82
ГХЯ-ны БТСГ-ын зөвлөх. Д.Батжаргалын хэлсэн үг.....	84
Элчин сайд асан, ОББЭЭ. Я.Дашнямын хэлсэн үг.....	85
ССХ-гийн ЕХА-ийн судалгааны төвийн эрхлэгч, Др. Д.Мөнхтөрийн хэлсэн үг.....	87
МУИС-ийн ОУХНУС, Захирал, Др. С.Баттулгын хэлсэн үг.....	90
МУИС, ОУХНУС-ийн багш, Проф. С.Энхбаярын хэлсэн үг.....	94
Дипломат Академийн захирал, ТҮГЭС, ОББЭЭС, Др. Х.Бэхбат-Хаалтын үг.....	101
Хавсралт-1: Үндэсний тагнуулын академийн Тагнуул судлалын төвийн судалгаа.....	105
Хавсралт-2: 1994 оны МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	121
Хавсралт-3: 2011 оны МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	131

Өмнөх үг

Эдүгээгээс 20 жилийн тэртээ, 1994 оны 6-р сарын 30-нд ардчилсан Монгол Улсын гадаад харилцааны үндсэн хууль болсон баримт бичиг- Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдан гарсан билээ. Ийнхүү түүхэн ой тохиож байгаатай холбогдуулан ГХЯ-ны дэргэдэх Дипломатын академи Элчин сайд нарын клуб болон Конрад Адэнауэрын сантай хамтран “Гадаад бодлогын үзэл баримтлал-20 жил” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа.

Үндэсний эрх ашгаа дээдэлсэн, бие даасан гадаад бодлогын тулгуур зарчим, чиглэлүүдийг томъёолон тодорхойлсноороо Монголын хөгжлийн хувьд цоо шинэ үзэгдэл болсон уг баримт бичиг түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн нь нэн ойлгомжтой. Уг үзэл баримтлал шинэчлэн батлагдсан 2011 он саяхан мэт боловч өнгөрөгч хугацаанд дэлхий дахинд болоод дотоодод чамгүй өөрчлөлтүүд гарч, басхүү Монголчууд бидний хувьд гадаад бодлого, түүнд эерэгээр болоод сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг эргэж харах, дахин нягтлан цэгнэх, хэрэгжилтийг нь дүгнэх бодит нөхцөл байдал үүссэн гэж болно. Ийм л цаг үед гадаад харилцааны салбарт хүч хөдөлмөр, ухаан сэтгэлээ зориулсан ахмад дипломатууд, тэднийг түүчээлэн буй залуу үеийнхэний зэрэгцээ нэр бүхий улс төрчид, эрдэмтэн судлаач нар хуран цуглаж цэц булаалдсан нь Үзэл баримтлалын амьдрахуйг тэтгэж ач холбогдлыг нь улам өөдөө, өндөрт өргөсөн юм.

Монголын гадаад харилцааны салбарынхны нэг ёсны “их чуулган” хэмээн өргөмжлөхүйц энэхүү эрдэм шинжилгээний бага хурлын үеэр сонордсон илтгэл, айлтгалуудыг эмхэтгэн нэгтгээд, Гадаад бодлогын үндсэн хуулийнхаа хэрэгжилтийг эргүүлэн нэгэнтаа харж мянгантаа эргэцүүлэхэд тань нэмэр болтугай хэмээн Таны гэгээн мэлмийд өргөн барьж байна.

Др.Х.Бэхбат

ХӨТӨЛБӨР

2014 оны долдугаар сарын 3-ны өдөр.

ГХЯ-ны Зөвшилцөл Танхим

10.50-11.00 Оролцогсдыг бүртгэх

11.00-11.10 Нээлт:

Др.Х.Бэхбат -Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд,

ГХЯ-ны Дипломат Академийн захирал

Баяр хүргэж үг хэлэх:

11.10-11.20 **Д.Тэрбишдагва**-УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд

11.20-11.25 Гадаад харилцааны сайд Л.Болдын илгээлт

11.25-11.35 **Йоханнес Д. Рай**-КАС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч

Анхдугаар хуралдаан

11.35-11.55 **“Монгол Улсын Гадаад бодлогын 1994 оны үзэл баримтлал: Дөрвөн “Д”-гийн чиг шугам”**

Илтгэгч: **Др. Г.Төмөрчулуун**-ГХЯ-ны Бодлого төлөвлөлт, судалгааны газрын зөвлөх

11.55 Хуралд оролцогсод хамтдаа зураг авахуулах

Үдээс өмнөх хуралдааныг ГХЯ-ны Дипломат Академийн Ерөнхий зөвлөх, Монголын Элчин сайд нарын клубын Дэд Ерөнхийлөгч Л.Удвал удирдана.

12.00-13.45 Үдийн хоол

Хоёрдугаар хуралдаан

14.00-17.00 Хэлэлцүүлэг

Хэлэлцүүлэгт оролцож үг хэлсэн хүмүүс:

Ц.Гомбосүрэн	ГЯЯ-ны сайд асан
Др. М.Батчимэг	УИХ-ын гишүүн
Б.Баабар	Ерөнхийлөгчийн зөвлөх
О.Машбат	ГХ-ны сайдын зөвлөх
Др.Ж.Энхсайхан	Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд
Др. Ц..Батбаяр	ГХЯ-ны БТСГ-ын захирал
Др. Ж.Чойнхор	ГХЯ-ны Тэргүүн дэд сайд асан
Др. Д.Баярхүү	Элчин сайд асан
Проф. З.Дашзэвэг	Батлан хамгаалах хүрээлэнгийн судлаач
Др. Д.Мөнхтөр	ССХ-гийн Европ, Хойт америкийн судалгааны төвийн эрхлэгч
Др. Л.Хайсандай	ОУСХ-гийн зөвлөх
Др. Ж.Гөлгөө	Элчин сайд асан
Др. С.Баттулга	МУИС-ийн ОУХНУС-ийн захирал
С.Энхбаяр	МУИС-ийн ОУХНУС-ийн багш

Бусад оролцогч

17.00 Хаалт:

Др. Х.Бэхбат

Үдээс хойшхи хуралдааныг Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд, Гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтын судалгааны төвийн захирал Л.Галбадрах удирдана.

18.00-20.00 **Хүлээн авалт**



**ГХЯ-ны Дипломат Академийн захирал,
Др.Х.Бэхбат бага хурлыг нээж хэлсэн үг**

Дипломатч гэж эмэгтэй хүний төрсөн өдрийг санах хэрнээ хэдэн нас хүрч байгааг нь “умартах” хүнийг хэлнэ гэсэн хэлц үг байдаг юм байна. Тэгвэл төрсөн өдөр буюу ойг тэмдэглэх олон арга байдгийн нэг нь хурал хуй зохиох явдал гэдгийг та бид дэндүү сайн мэдэх билээ.

Ийм нэгэн ойн хуралд бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлж, Гадаад харилцааны яам, түүний дэргэдэх Дипломатын Академи болон Амбассадорс клубын нэрийн өмнөөс гүнээ талархаж байгаагаа юуны өмнө илэрхийлье. Энэ хурлын нээлтэнд оролцохоор УИХ-ын гишүүн, МУ-ын шадар сайд Тэрбишдагва, УИХ-ын зарим гишүүд, Гадаад яамны сайд асан эрхмүүд, олон тооны эрдэмтэн мэргэд, шинжээчид, ахмад дипломатууд зорин ирсэнийг харахад нэн таатай байна. Манай хурлыг зохион байгуулахад үнэтэй дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байгаад нь Улаанбаатар дахь КАС-ын суурин төлөөлөгч ноён Йоханнес Рай танаа бид чин сэтгэлээсээ талархаж байна.

Өнөөдрийн хурал бол баярын хурал бус эрдэм шинжилгээний шинж чанартай, онол-практикийн бага хурал юм. Энэ утгаараа Ардчилсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал анх 1994 онд батлагдан гарсан тэр түүхэн цаг үе, түүнээс хойш туулсан замнал, хувьсал, гүйцэтгэсэн үүрэг ролийг үнэлж дүгнэхээс авхуулаад манай гадаад харилцааны салбарынхны Үндсэн хууль гэгдэх энэ баримт бичгийн шинж чанар, хэлбэр, агуулгын бүрэн бүтэн байдал хүртэл өргөн хүрээтэй асуудлыг хамран хөндөх учиртай гэж бодож байна. Та бүгд үзэл бодол, үнэлэлт дүгнэлт, санаа оноогоо чөлөөтэй уралдуулж гадаад бодлогын үйл ажиллагаа, түүний эрх зүйн үндсийг цаашид боловсронгуй болгох, улмаар гадаад бодлогын сэтгэлгээг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулж чадна гэдэгт эргэлзэхгүй байна.

Ингээд өнөөдрийн бага хурлын үдээс өмнөх хуралдааныг хөтлөн явуулах Монголын Элчин сайд нарын клубын дэд Ерөнхийлөгч, ОББЭЭС Л.Удвалд микрофоноо шилжүүлье.

Л.Удвал / Хурлын хөтөч /

Баярлалаа. Одоо УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Л.Болдоос тус бага хуралд ирүүлсэн илгээлтийг та бүхэнд сайдын зөвлөх О.Машбат уншин сонордуулна.

О.Машбат / Гадаад харилцааны сайдын зөвлөх /

Л.Болд сайд Европт албан ёсны айлчлал хийж явааг Та бүхэн сайн мэдэж байгаа. Тэрээр өнөөдрийн бага хуралд хандан илгээлт ирүүлснийг би бүрэн эхээр нь сонордуулья.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Л.БОЛДЫН ИЛГЭЭЛТ

Гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд оролцогсдод.

Монгол Улсын гадаад харилцааны салбарын түүхэн хөгжилд мэдлэг боловсрол, хүч хөдөлмөрөө зориулсан үе үеийн ахмад дипломатууд, ажил үйлсийг нь залгамжлан хэрэгжүүлж байгаа гадаад харилцааны салбарын нийт дипломат ажилтнууд, эрдэмтэн судлаачид, хүндэт зочид Та бүхэнд Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье.

Гадаад бодлогын үзэл баримтлал бол манай гадаад бодлогын үндсэн хууль билээ. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, бүгд найрамдах улс мөн хэмээн үндсэн хуулиндаа тунхагласан бол, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна хэмээн гадаад бодлогын үзэл баримтлалдаа тунхаглажээ. Хууль хэрэгжүүлэхдээ бид үндсэн хуулиа үндэс болгодог бол гадаад бодлого хэрэгжүүлэхдээ гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгодог.

Монгол Улс ардчилалд шилжсэнээс хойш гадаад бодлогын үзэл баримтлалыг чиг болгон ажилласны дүнд гадаад харилцаа эрчимтэй хөгжиж буй нь хоёр хөрш, бүс нутаг, тив дэлхийн улсуудтай харилцааг өргөжүүлэн

бэхжүүлж, үлэмж цаашлан НҮБ-ын бүх гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоох зорилго тавин ажиллаж, зорилгодоо хүрэхэд тун ойрхон байгаагаас харагдаж байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын алдаа оноо, түүхэн замнал, ач холбогдол, шүүмжлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэлэлцэж, ярилцах нь өнөөгийн хурдацтай өөрчлөгдөж буй дэлхий нийтийн хөгжилтэй алхаагаа тохируулах, үйл явцад нь идэвхтэй оролцох, Монгол Улсдаа илүү их нэр хүнд олж, улс орны хөгжлийг эрчимтэй дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлагдаад 20 жил, шинэчлэгдээд 3 жилийн хугацааг ардаа орхижээ. Энэ чухал ойн эрдэм шинжилгээний бага хуралд оролцож буй Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэхийн хамт хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсье.

Л.Удвал

Монгол төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой чухал айлчлалаар гадаадад ажиллаж яваа ч гэсэн энэ өдөр сэтгэл санаагаараа бидний дунд байж, чин сэтгэлийн мэндчилгээ, илгээлт ирүүлсэн эрхэм сайдад эчнээ талархал илэрхийлж, зорьсон хэрэг, санасан үйлсээ амжилттай бүтээгээд сайн явж ирэхийн ерөөл дэвшүүлье.

Ингээд өнөөдрийн бага хурлын салхийг хагалж үг хэлэх нэгэн хүндтэй эрхмийг би микрофоны өмнө урих гэж байна. Энэ хүний алдрыг сонсмогцоо өргөн олон нийт гамшиг осол, гал усны аюултай тэмцэх, авран хамгаалах үйлстэй гол төлөв холбон үздэг шиг байгаа юм. Харин Монгол Улсын гадаад бодлогын хэрэгжилттэй шууд холбоотой үйл ажиллагаанд чухал үүрэгтэй оролцож ирсэн хийгээд оролцож байгааг нь тэр болгон сайн мэдэх хүн олонгүй ч байж мэднэ.

Тэгвэл манай хоёр их хөрш-ОХУ, БНХАУ болон Европ дахь тэргүүн түнш, манай гуравдахь хөршийн нэг ХБНГУ-тай хамтран ажиллах асуудлыг нэгтгэн зангидаж байдаг ЗГХК-уудыг тэрээр тэргүүлэн ажилладгаас гадна Герман улсад

Элчин сайдаар ажиллаж байсан, одоо УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын албыг хашиж байгаа Д.Тэрбишдагва сайдыг би тус бага хуралд хандан үг хэлнэ үү хэмээн урьж байна.

Д.Тэрбишдагва /УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд/

Эрхэм хүндэт УИХ-ын гишүүд ээ,

Хатагтай ноёд оо,

Юуны өмнө Та бүхний амар амгаланг айлтгахын ялдамд энэхүү эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Одоогоос 20 жилийн өмнө Монгол Улсын Их хурал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон Цэргийн номлолыг батлан гаргасан билээ. Ялангуяа хурдтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд бусад улс оронтой шинэ үеийн, найрсаг, эрх тэгш харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэх бодлогын үндсийг тодорхойлж, хэтийн зорилго чиглэлийг нь зааж өгснөөрөө Гадаад бодлогын үзэл баримтлалд онцгой ач холбогдолтой гэж үзэж байна.

Социалист системийн тогтолцоо задран унаж, дэлхий ертөнцийг хоёр хуваан талцуулж байсан хүйтэн дайны үе шувтарснаар Монгол Улсын улс төр, эдийн засаг, үзэл суртлын гадаад орчин бүрэн өөрчлөгдсөн юм. Ардчилсан өөрчлөлтүүд эрчимтэй явагдаж гадаад бодлогын салбарт ч цоо шинэ нөхцөл байдал үүссэнээр хөрш, түнш хэмээх томьёоллуудыг шинээр харах шаардлага тулгарсан. Чухам энэ үед гадаад бодлогын үзэл баримтлалаа тодорхойлох үйлсийн манлайд зүтгэж, гар бие оролцож явсан хүндтэй эрхмүүд, үе үеийн нэртэй дипломатууд, эрдэмтэн судлаачид, дипломат албаны залгамж халаа болсон өнөөгийн залуусын төлөөлөл өнөөдөр энэхүү танхимд хүрэлцэн ирснийг харахад таатай байна.

Хатагтай ноёд оо,

Хориннэгдүгээр зуунд түншлэлийн харилцааны ач холбогдол улам бүр өссөөр байна. Ганц нэг орны аюулгүй байдал бүс нутгийн, магадгүй дэлхий дахины нөхцөл байдал, улс орнуудын гадаад бодлогын чиг хандлагатай холбоотой болж байгааг бид өнөөгийн олон улсын харилцааны зарим үйл явдлуудаас бэлхэнээ харж байна. Бүхий л салбарт улс гүрнүүдийн хоорондын хамаарал хийгээд бодлого, чиглэлийн уялдаа холбоо улам бүр өсөн нэмэгдэж байгаа учраас аливаа чухал асуудлыг, түүний дотор энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж, бататган бэхжүүлэхээс авахуулаад хүн төрөлхтөний сэтгэл санааг чилээж байгаа глобаль асуудлууд, түүнчлэн хөгжлийн асуудлыг ч өргөн хүрээнд харж, хариуцлагатай, ухаалаг засаглалыг тогтоон хөгжүүлэх явдал чухал болжээ.

Монгол Улс эдүгээ дэлхийн хамтын нийгэмлэгийн тэгш эрхт гишүүн төдийгүй улс түмний энх тайван, аюулгүй байдал, ардчиллын үнэт зүйлсэд тулгуурласан идэвхтэй гадаад бодлого явуулдаг, улс гүрнүүдийн хүлээн зөвшөөрөгдсөн түнш боллоо. Энэхүү нэр хүнд, жин нөлөөгөө улам бататгаж, бүс нутаг, тив дэлхийн хэмжээний идэвхтэй тоглогч байх асуудал бидний өнөөдөр ярих гэж байгаа сэдэвтэй салшгүй холбоотой буй заа. Манай орны хөгжлийн боломж, үүнтэй холбоотой сорилтыг ухаалаг, зөв ашиглах чадамж маань ямар байгаа хийгээд эдгээрээс үүдээд үзэл баримтлалаа цаашид чамбайруулан шинээр дэвшигдэж байгаа эрэлт, шаардлагын талаар ч Та бүхэн өнөөдөр ярилцах байх.

Боломж, хэтийн төлөв гэх мэт ойлголтууд ирээдүйгээ зөв харахтай ямагт холбоотой байдаг. Иймээс туулж өнгөрүүлсэн хорин жилийнхээ амжилт ололт, алдаа оноог эргэцүүлэн бодож, алс хэтээ саруулхан харахад өнөөдрийн Та бүхний энэ бага хурал чухал хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Л.Удвал / Хурлын хөтөч/

Баярлалаа. Таны цаашдын ажил үйлст шинэ их амжилт хүсье.

Энэ бага хуралд Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Монгол–Германы Чуулганы тэргүүн, академич П.Очирбат гуай оролцохоо мэдэгдээд байсан боловч яг энэ өдрүүдэд Баян Өлгий аймагт болж буй Алтай Таван Богд хайрханыг тайх ёслолд оролцоно уу хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж түүнийг

урьсан тул тэр арга хэмжээнд орохоор явсан байгаа. Тэгэхдээ Гадаад бодлогын үзэл баримтлалыг анх боловсруулж, батлаж байх үеийн дурсамжаа бичиж ирүүлсэн тул түүнийг нь энэ бага хурлын дараа гарах товхимолд бид оруулах болно.

Манай бага хурлыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ХБНГУ-ын Конрад Аденауэр сангийн Монгол дахь суурин төлөөлөгч ноён Йоханнес Рай өнөөдрийн арга хэмжээнд биечлэн оролцож байгааг та бүхэнд сонордуулахад таатай байна. КАС бол 1990-ээд оноос Монголд төлөөлөгчийн газраа нээж, монголын шинэ залуу ардчиллыг тууштай дэмжиж ирсэн байгууллага. Энэ байгууллага Монгол-Германы Чуулган ТББ-тай 15 жилийн турш амжилттай хамтран ажиллаж ирсэн бөгөөд саяханаас манай Дипломат Академитай хамтын ажиллагаагаа эхлүүлээд байгаа юм. Энэ завшааныг ашиглан КАС-гийн СТГ-ын хамт олонд болон ноён Йоханнес Райд талархал илэрхийлж цаашдын ажилд нь шинэ их амжилт хүсэн ерөөе.

Одоо бага хурлын маань үндсэн хэсэг эхлэх гэж байна. Өнөөдрийн бага хурлын үндсэн илтгэлийг Судалгааны тэргүүлэх Профессор, улс төрийн шинжлэх ухааны Др. Г. Төмөрчулуун тавина.

Др. Төмөрчулуун бол анх Куба улсад суралцан испани хэлний мэргэжил эзэмшиж ирсний хувьд Латин Америкийн орнууд, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний асуудлаар ажиллаж эхэлсэн боловч яваандаа англи, орос хэлийг сайтар эзэмшихийн зэрэгцээгээр олон улсын өргөн цар хүрээтэй асуудлаар мэргэшиж, дипломат үйл ажиллагаа, гадаад бодлогын онолын асуудлыг гүнзгий судлан шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан манай яамны тэргүүлэх мэргэжилтэн, эрдэм чадал нь тэгширсэн судлаач, дипломат хүн юм. Өнөөдөр бид түүний бэлтгэсэн нэгэн өвөрмөц томьёолол бүхий илтгэлийг хамтдаа сонсч, санаа бодлоо солилцох завшаан тохиож байна. Ингээд Др. Төмөрчулууныг урья.

1994 оны Гадаад бодлогын анхны Үзэл баримтлалд дүн шинжилгээ хийхүй: Монголын орчин цагийн гадаад бодлогын дөрвөн “Де”-гийн чиг шугам

Нэг.Түүхээс товчхон

Ардчилсан Монгол Улс өөрийн гэсэн гадаад бодлоготой болох, түүнийг хуульчилсан үзэл баримтлалтай болох асуудал үнэндээ аль 1990 оноос яригдаж эхэлсэн юм. Би 1990 оны зун ЗХУ-ын ГХЯ-ны дэргэдэх Дипломатын Академийг дүүргээд 6 дугаар сард Монголд ирэхэд Гадаад харилцааны яамны удирдлага намайг Засгийн газарт оч гэсэн юм. Тэр дагуу 1990 оны 7 дугаар сараас ЗГХЭГ-ын ажилтан болов.

Тэр үед Ш.Гунгаадорж гуай ерөнхий сайд байсан. Орлогч нь болох Б.Шаравсамбуу дарга Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын комиссыг даргалж байв. Сангийн сайд байсан Э.Бямбажав гуай түүний орлогч байсан. Э.Бямбажав даргын удирдлага дор ажиллаж байсан Д.Баажийхүү дарга миний өдөр тутмын ажлыг чиглүүлж байв.

Засгийн газарт очоод миний авсан үүрэг бол гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулж, тэр үеийн Ардын Их Хурлаар батлуулах явдал байв. Тэр үед л хамгийн анхны төсөл гарсан юм.

Тэгж байтал Ш.Гунгаадоржийн Засгийн газар татан буугдаад Д. Бямбасүрэнгийн засгийн газар байгуулагдаж төрөлх яамандаа буцаж ирэх боломж гарав.

Тэр үед Гадаад яаманд Нэгдсэн бодлогын газар гэх том нэртэй газрыг эдийн засгийн ШУ-ны доктор, академич Т.Намжимаар даргалуулан байгуулсан юм. Нэгдсэн бодлогын газарт миний хариуцаж хийх ёстой гол ажил бол дахиад л Үзэл баримтлалыг боловсруулж батлуулах асуудал болов.

Үүнээс 4 жилийн дараа буюу 1994 оны 7 дугаар сард , одооноос яг 20 жилийн өмнө, УИХ –аас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Цэргийн номлолыг нэг зэрэг баталж билээ. Манай үзэл баримтлал 76 хувийн саналаар батлагдав. Тэр үеийн бичлэг УИХ-ын архивт байдаг. Сонирхосон хүн очиж үзэж болдог юм билээ.

Дөрвөн жилийн хугацаанд үзэл баримтлалыг боловсруулах асуудлаар олон ажлын хэсэг гарч байлаа. Олон ч удаа хуралдсан. Манай яамны сайдын зөвлөл зөвхөн энэ асуудлаар 5 удаа хуралдсан байдаг. Үзэл баримтлалыг боловсруулахад олон ч хүн оролцсон. Тэдгээрийн дотроос хэдэн хүний нэрийг зориуд цохон тэмдэглэмээр байна. Тэд тухайн үеийн Монголын нэрт сэхээтнүүд, улс төрийн нэрт зүтгэлтнүүд байсан юм. Тэдгээрийн дотор С.Зориг, гавъяат хуульч Б.Чимид, Ерөнхий сайд асан М.Энхсайхан, С.Баяр, генерал Ш.Жадамбаа, Үндэсний хөгжлийн сайд асан доктор Батсуурь, өдгөө ШУА-ийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа академич Б.Энхтүвшин нар байлаа. Мэдээж анхны Ерөнхийлөгч П.Очирбат гуайг зориуд хэлэх ёстой. Дээр нь манайхнаас оролцсон Ц.Гомбосүрэн сайд, Ж.Чойнхор сайд, тэр үед Аюулгүйн Зөвлөлийн нарийн бичгийн дарга байсан, өдгөө ТҮГЭС Ж.Энхсайхан нарыг дурдах нь зүйтэй.

Олон ч улсын энэ талын туршлагыг судлав. Манай ДТГ-ууд ч эрвийх дэрвийхээрээ ажиллаж, олон ч мэдээ, материал ирүүлж байсан. Олон улсын эрдэм шинжилгээний олон ч хүрээлэнгийн судалгааны бүтээл, ном зохиолтой танилцсан даа. Олон ч хүний дэмжлэг хүлээж бас олон хүнд ад үзэгдсэн дээ. Энэ нүсэр ажлын үр дүнд анхны Үзэл баримтлал төрсөн түүхтэй.

Өдгөө Монгол Улсын гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсанаас хойш даруй 20 жил улиран оджээ. Энэхүү түүхэн үйл явдалд эхнээс нь эцсийг нь хүртэл явсандаа миний бие нэн баяртай байдаг бөгөөд энэ бол эрдэмтэн бас дипломат хүний хувьд нэр төрийн хэрэг байсан гэдгийг зориуд хэлье.

Хоёр. Дөрвөн “Де”-гийн чиг шугам

Энэхүү илтгэлд орсон санаанууд зөвхөн зохиогч миний, өөрөөр хэлбэл эрдэмтэн хүний хувийн үзэл бодол гэдгийг зориуд тэмдэглэж байна.

1994 оны Үзэл баримтлалыг өргөн утгаар нь, ертөнцийг үзэх үзэл, философи талаас нь тайлбарлах гэж оролдон санаа бодлоо хуваалцахыг зорьсон болно. Үзэл баримтлал бол хамтын бүтээл. 1994 оны үзэл баримтлал бол Монголын гадаад бодлогын нэг үеийн түүхийг төгсгөж, нөгөө үеийн түүхийг эхлүүлсэн юм.

Өмнөх үеийн түүхийн төгсгөл:

Дагуул улсын түүх /О.Латтиморын тодорхойлолт/

БНМАУ тухайн үедээ ЗХУ-ын дагуул, өөрийн гэсэн гадаад бодлогогүй явж ирснийг Америкийн Монгол судлаач О.Латтимор гуай онож хэлсэн байдгийг эргэн санахад илүүдэхгүй. Энэ тухай миний бие БНМАУ-ын Гадаад хэргийн сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан П.Шагдарсүрэн гуайн 90 жилийн ойд зориулж зохион байгуулсан /2008 он/ эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлдээ анх гаргаж тавьсан юм. Үүнийг би дахин сануулахад илүүдэхгүй гэж үзэв. Юмыг дахин дахин сануулж байхгүй бол мартагддаг гэмтэй. Дагуул улс /satellite state/-ын 6 шинжийг Латтимор агсны хэлснээр бол:

- ▶ Дагуул улсын удирдлага тойрог замын гол улсынхаа тусламж дэмжлэгтэйгээр төрийн эрхэнд гарсан байдаг.
- ▶ Дагуул улсын удирдлага дагуулагч улстай ийм харилцаатай байхыг өөрсдөө хүсдэг.
- ▶ Ийм харилцаагүйгээр дагуул улс оршин тогтнох чадваргүй.
- ▶ Дагуул улсын удирдлага саталайт улстай бүх талаар ижилсэхийг хүсдэг ч тухайн улсын бүх иргэн ингэж боддоггүй.
- ▶ Ийм нөхцөлд дагуул улсын болон дагуулагч улсын эсрэг сөрөг хүчин заавал байдаг.
- ▶ Дагуул улсын дэглэм уствал дагуул улсад дахиад өөр улсын дагуул улс болдог.

ШИНЭ ТҮҮХИЙН ЭХЛЭЛ: 1992 ОНЫ ҮНДСЭН ХУУЛЬ

Монгол Улсын шинэ гадаад бодлого 1992 оны анхны ардчилсан үндсэн хуулиас эхлэлтэй юм. Тэнд Монгол Улсын гадаад бодлого “Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээг баримтлана” гэж заасан.

Өөрөөр хэлбэл дээр дурьдсан дагуул улсын гадаад бодлогоос татгалзах хэрэгтэй болсон. 1991 онд ЗХУ гэдэг улс байхаа болив. Тэгэхлээр зөвлөлт маягийн гадаад бодлого гэж юу байх юм бэ? Монголын гадаад бодлогод зарчмын чанартай өөрчлөлт хийх нь нийгмийн шаардлага болсон юм. Монгол гэдэг улс чинь өөрийн гэсэн гадаад бодлоготой байх ёстой болов.

1994 оны Үзэл баримтлалаар ардчилсан Монголын гадаад бодлого “дөрвөн де”- гийн чиг шугам гаргаж тавьсан гэж хувьдаа боддог. Аливаа гадаад бодлого үндэсний эрх ашгийг дээдлэх ёстой гэсэн үзэл санааг баримтлах ёстой. 1994 оны Үзэл баримтлал бол ийм сэтгэлгээнээс үүсэн гарсан юм.

1994 ОНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: ШИНЭ ТҮҮХИЙН ЭХЛЭЛ

Дараах 4 өөрчлөлт Монголын шинэ гадаад бодлогыг эхлүүлсэн юм. Нэр томъёог хүнд ойлгуулах гэдэг утгаар англи, оросоор бичив. Түүнийгээ монголоор тайлбарлахыг оролдъё. Үүнд:

- ▶ **Desovietization-Десоветизация/Дебольшевизация/**
- ▶ **Deideologisation /Деидеологизация/**
- ▶ **Democratization-Демокроатизация**
- ▶ **Decentralization or Diversification/Децентрализация/**

DESOVIETIZATION & DEBOLSHEVIZATION

Улс орны “зөвлөлтжсөн” улс төр, эдийн засаг, үзэл суртлын тогтолцоог өөрчлөх, энэгүйгээр Монголын нийгэм цаашид хөгжих дэвших боломжгүй юм.

Ардчилсан тогтолцоонд шилжихэд гадаад талын оюун санааны болон материаллаг бүхий л дэмжлэг тусалцааг хайж олох, өөрөөр хэлбэл, Монгол дахь зөвлөлт маягийн тогтолцоог ардчилсан тогтолцоогоор солиход гадаад бодлогыг чиглүүлэх хэрэгтэй байлаа. Манай бизнесменүүд хоол, унд, будаа тариа гаднаас оруулж ирдэг. Гэхдээ санаа оруулж ирэх бол хамгийн чухал. Гадаад бодлогыг яаж боловсруулж, хийдэг вэ? гэдэг бол их чухал. Миний бие 1993 оноос хойг МУИС-д хичээл заасан. Миний сэдэв бол Гадаад бодлогын шийдвэрийн онол байлаа. Киссенжер, Бзежинский нар яаж Америкийн бодлогыг хийж байсан тухай би хичээл заадаг юм. Энэ сэдэв бол Английн, Америкийн гадаад бодлогын үндсэн асуудал байсан юм шүү дээ. Төрийн департамент намайг 1993 онд урьж, лекц сургууль хийлгэсэн. 2006 онд миний бие гадаад бодлогын шийдвэрийн онол сэдвээр улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалахад энэ их тус болсон гэдгийг нуулгүй хэлье.

DEIDEOLIGISATION

/Гадаад бодлогыг үзэл суртлын хүлээснээс ангижруулахын төлөө тэмцэл/

Гадаад бодлогыг “дэлхийн хувьсгал”, “капиталист бус хөгжлийн зам” мэтийн гажиг зорилгоос нь салгаж, Монголын үндэсний эрх ашгийг хамгаалахад чиглүүлэх, дэлхийн улс орнуудыг “социалист”, “капиталист” гэж хуваадаг үзэл бодлоос татгалзах явдал үнэхээр чухал байсан. “Дэлхийн хувьсгалын онол” гэдэг нь тэр

үеийн социалист ертөнцийн гадаад бодлогын тулгын чулуу байлаа шүү дээ. Гол санаа нь коммунист тогтолцоог дэлхий дахинд тараах явдал байлаа.

DEMOCRATIZATION

/Гадаад харилцааг ардчилах замд оруулахын төлөө тэмцэл/

Гадаад бодлогыг хийх, хэрэгжүүлэхэд дан ганц төрийн байгууллагууд бус, төрийн бус байгууллагууд, бизнес, соёл урлаг гэх мэт нийгмийн бүхий л давхарга оролцох ёстой. Энэ бол төр барьж буй дан ганц намын хэрэг биш гэдэгт асуудлын гол нь оршино.

DECENTRALIZATION & DIVERSIFICATION

Төрийн гадаад бодлого дахь нэг намын монополь эрхийг халж, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, бодлогын шийдвэр гаргах бүрэн эрхийг 1992 оны Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын бүрэн эрхэд шилжүүлсэн билээ.

“ЗХУ”, “Социалист хамтын нөхөрлөл”, ЭЗХТЗ мэтийн ойлголт алга болсон тул гадаад бодлогын үндсэн чиглэлүүдийг шинээр томъёолох, чингэхдээ гадаад харилцааг олон тулгууртай болгох, Ази, Номхон далай руу чиглэсэн бодлогод түлхүү анхаарах \ АПЕК, АСЕАН, EAST ASIA SUMMIT, SCO, CICA гэх мэт\ ёстой болсон юм. Энэ тухай гшинэ үзэл баримтлалд их тодорхой орсон юм.

4 “Д” –гийн чиг шугамыг хэрэгжүүлэх явцад Монголын гадаад бодлогод 4 томоохон өөрчлөлт орсон юм. Энэ бол:

- ▶ Гадаад бодлогын шинэ зорилтууд
- ▶ Гадаад бодлогын шинэ зарчмууд
- ▶ Гадаад бодлогын шинэ чиглэлүүд
- ▶ Гадаад бодлогын шийдвэр гаргах шинэ арга механизм

Эдгээр өөрчлөлтүүдийг дэлгэрүүлэн ярьж болох авч цаг бага тул ингэсхийгээд өндөрлөө. Зарчмын чанартай хэдэн өөрчлөлтийг хэлэхэд дараах байдал харагдаж байгаа юм.

ОХУ, БНХАУ-тай шинэ маягийн харилцааг бүрэлдүүлэхийн төлөө шинэ Монгол Улс тэмцэхдээ ОХУ-тай 1993 оны найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ, 2009 оноос Стратегийн түншлэлийн харилцаа байгуулав. Түүнд урьдын дагуул улс биш, эрх тэгш харилцаатай байна гэж дурьдсныг тэмдэглэх ёстой юм.

БНХАУ-тай 1994 оны “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”, 2011 оноос “Стратегийн түншлэлийн харилцаа” байгуулав.

Өрнөдийн орнуудтай ойртох бодлогын хүрээнд “Гуравдагч хөрш”-ийн бодлого , “Түншлэлийн харилцаа” явуулав. Монгол Улс хөгжиж буй орнуудын тухайд ЭҮНХ –нд элсэв. Чингэхдээ Хөдөлгөөндөө бус үл нэгдэх гэдэг зарчимыг гол болгов.

Цаашлаад шинэ гадаад бодлогын эрх зүйн үндсийг олон улсын эрх зүй талаас бэхжүүлэхийн төлөө тэмцсэн юм. Үүнд олон улсын гэрээ конвенцүүдэд шинээр нэгдэх бодлого баримталж, хуучин нэгдсэн гэрээ конвенцүүдэд хийсэн социалист маягийн тайлбаруудаас татгалзав.

Гэсэн хэдий ч 1994 оны Үзэл баримтлалын тухай шүүмжлэл гарч байсныг хэлэх ёстой. Жишээ нь Монгол Улс нээлттэй, Эвсэлд үл нэгдэх бодлого явуулна гэж байдгийг бид мэднэ. /Нийтлэг үндэслэлийн 3-т/ . Тэнд Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн гэдэг байгууллагыг хэлээгүй шүү. Философийг нь хэлж байгаа юм. Монгол бол Варшавын Гэрээний хавсарга улс байсан шүү дээ. Үүүнийг л би хэлээд байгаа юм. Эвсэлд үл нэгдэнэ гэдэг бол аливаа цэрэг, улс төрийн эвслээс ангид байна гэсэн үг. Аливаа эвсэл холбоонд бид орох ёсгүй гэж байгаа хэрэг. Монгол бол хэрэг дээрээ төвийг сахьсан улс. Бид цөмийн зэвсэггүй бүс гэж өөрийгөө тунхагласан.

Гурав.Төгсгөлийн оронд :

Гадаад бодлогын 1994 оны үзэл баримтлалыг өнөөдрийн өндөрлөгөөс харахад ихээхэн суурь сайтай баримт бичиг болсон гэдэг нь өнөөг хүртэл хэрэгжсээр байгаагаас харагдаж байна.

Гэсэн хэдий ч түүний зарим заалтууд өнөөг хүртэл хэрэгжээгүй ирснийг тэмдэглэж хэлэх нь зүйтэй. Тухайлбал, “ОХУ, БНХАУ-тай бүхэлдээ тэнцвэртэй харилцана. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана” гэсэн байдаг. Энэ заалт эсрэгээрээ хэрэгжжээ.

Тодорхой улс орнуудын нэр заасан явдал улс орнуудыг алагчлан үзсэнтэй адил хэмээн шүүмжлэл гардаг.

Азийн бодлогын хэсэгт АПЕК-т элсэхийг зорино гэсэн нь өнөөг хүртэл биелэгдээгүй байна.

Үүнээс гадна манайхыг хүний эрхийг зөрчдөг, гадаадын хөрөнгө оруулах орчин тогтвортой бус, авилга хээл хахуульд автагдсан улс хэмээх шүүмжлэл тасрахгүй байгааг та бид мэднэ.

Үзэл баримтлалын эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёл хүмүүнлэгийн зэрэг бусад салбарт тавьсан зорилтуудын зарим нь амьдралаас тасархай, хэт ерөнхий, биелүүлэхэд хэцүү байжээ гэж одоо бодогдож байна.

Магадгүй баримт бичгийн хамгийн том дутагдал нь түүний хэрэгжилтэд хяналт тавих механизмыг зааж өгөөгүй явдал байж мэднэ.

Харамсалтай нь эдгээр дутагдлыг 2011 онд шинэчилсэн Үзэл баримтлалыг тойрч гарсангүй. Иймд Үзэл баримтлалын сүүлчийн хувилбарыг эргэж харах хэрэгтэй болжээ гэж санана.

Л.Удвал / Хурлын хөтөч/

Др.Төмөрчулуунд баярлалаа. ЗД гэсэн нэр томъёог миний бие “стерео техникийн” хэмжээнд л төсөөлдөг байсан бол өнөөдрөөс улс төр, дипломатын хүрээнд 4Д хэмээх чиг бодлого байж болох тухайд нэлээд зүйлийг сонсож авлаа. Шинэлэг юм болгон ярьж дагсалдах боломж олгож, түүнийг дагаж болон сөрж сэтгэх нөхцөл бүрдүүлж байдаг. Тиймээс өнөөдөр үдээс хойш болох яриа мэтгэлцээн, санал солилцох хуралдаан нэн сонирхолтой болно гэдэгт би эргэлзэхгүй байна. Ингээд үдээс хойш, бага хурлын хөтөлбөрт дурдсан цагтаа энэ танхимдаа эргээд уулзацгаая. Баярлалаа.



Л.Галбадрах / Үдээс хойшхи хуралдааны хөтөч, ТҮГЭС/

Үдээс хойшхи хуралдааныг удирдах хариуцлагатай үүрэг надад ноогдож байна. Хариуцлагатай гэхийн учир хэмээвээс Др. Г.Төмөрчулууны тавьсан сонирхолтой илтгэлийн дараа Та бүхэн санаа бодлоо уралдуулж, байр сууриа илэрхийлэх гээд хурлын хөтөчийн зүгээс хэлэх элдэв тайлбар сэлтийг бараг тээршаах биз. Тиймээс би хуралд үг хэлэхээр нэрээ өгсөн дарааллын дагуу нэр дуудаад явчих нь зүйтэй юм байна гэж бодлоо. Нэр дуудсан даруйд өөрийгөө танилцуулаад хэлэх зүйлээ айлдана уу хэмээн эрхмүүдээс хүсч байна.

Академич П.Очирбат /Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Монгол Германы Чуулганы тэргүүн/

1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулах, батлах үеийн нөхцөл байдал их өвөрмөц байлаа. 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж заасан юм.

Гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулах, батлах тэр үед хүйтэн дайн дуусч, олон улсын харилцааны шинэ тогтолцоо бүрэлдэж байсан цаг үе давхацсан. Социалист систем, ЗХУ задарч, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл тарсан. Зөвлөлтийн цэрэг Монголоос гарсан. Энэ бүхний холбоотон байсан Монгол Улсын гадаад нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн.

“Дайснаа” нөхөр болгох их бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй болов. Эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалах, баталгаажуулах арга механизмыг олох шаардлага гарсан. Империализм, милитаризм гэгчтэй эвлэрэх хэрэгтэй, тэдэнтэй энх тайвнаар зэрэгцэн оршиж, хань хамсаатнаа болгон ардчилал, зах зээлийн замаар замнахад хамтран ажиллах шаардлагатай байлаа. Энэ бүхний төлөө АНУ, Япон, Англи, Герман, Франц, Солонгос улсуудад Монгол Улсын төрийн бодлогыг танилцуулах үүднээс төрийн айлчлал хийх хэрэгтэй болсон юм.

Хоёр том хөрш ОХУ, БНХАУ-тай харилцаагаа шинэ нөхцөл байдалд нийцүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааныхаа Гэрээг үүнд зохицуулах талаар бодлогоо тодорхойлох хэрэгтэй болсон.

Энэ бүхнийг хэрхэн зохицуулахаа тодорхойлж, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг батлан, улс төрийн хувьд баримтлах нэгдсэн бодлоготой байж Монголын төрийн бүх түвшинд нэг үзэл баримтлал, нэгдмэл чиглэл барьж гадаадын улс орнуудад түүнийгээ танилцуулах хэрэгтэй гэж үзсэн билээ. Эдгээр шаардлагыг үндэслэн:

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал,
- Гадаад бодлогын үзэл баримтлал,
- Цэргийн номлолын үзэл баримтлал зэрэг суурь баримт бичгүүдийг 1994 онд Улсын Их Хурлаар батлуулж мөрдсөн юм.

Эдгээрийг 20-иод жил мөрдөж, сүүлийн жилүүдэд цаг үеийн шаардлагаар зарим нэмэлт өөрчлөлт оруулж сайжруулсан байна. Хамгийн гол нь хүн болгон Монголын гадаад бодлогыг өөрийн дураар “бурж” байж таарахгүй, нэгдсэн, албан ёсоор томъёологдсон үзэл баримтлалтай байх ёстой гэдгийг иш үндэс болгосон хэрэг.

Олон намын системд шилжиж, олон ургалч үзлийг дээдлэж эхэлсэн үед хамгийн эмзэг байж мэдэх гадаад бодлого маш цэгцтэй байх ёстой юм. Энэ үүднээс улс төрийн гадаад харилцаанд олон тулгуурт гадаад бодлоготой байх, эдийн засгийн гадаад бодлогод нээлттэй байх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зэргийг гол болгосон юм.

Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүтэн бүрэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлаа улс төр, дипломатын аргаар баталгаажуулахад цөмийн зэвсэгтэй орнуудын дэмжлэгийг авах үүднээс “Монгол Улсын нутаг дэвсгэрийг цөмийн зэвсгээс ангид бүс болгох тухай Монгол Улсын Ерөнхийлөгч миний бие НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47-р чуулганд (1992 онд) зарлан мэдэгдсэн. Энэ санаачлагыг ЕА-н 53 дугаар чуулганы тогтоолоор дэмжиж, Цөмийн зэвсэгтэй таван гүрний мэдэгдэл гарч, улмаар Тунхаглал болон гүнзгийрсэн юм.

Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сангийн болон Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсноор Монгол Улсын эдийн засгийн уналтыг зогсоож тогтворжуулах, өсөлтийг эхлүүлэх суурийг тавьсан. Одоо Монгол Улсын эдийн засгийн өсөлт 17-12% хүрч байна.

АНУ, Япон Улсуудын шууд оролцоо, дэмжлэгийг авч, Хандивлагч орнууд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд Монголын эдийн засаг хүнд байдлаас харьцангуй богино хугацаанд гарч тогтворжин улмаар өсөлт эхэлсэн юм.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулахад Гадаад хэргийн яамныхан, ялангуяа тус яамны сайд Ц.Гомбосүрэн болон Ерөнхийлөгчийн зөвлөх Р.Батаа, Ж.Энхсайхан нар чухал үүрэг гүйцэтгэснийг зориуд тэмдэглэе.

“Монгол Улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ баримтлах чиглэлийн **нэгдүгээрт** “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны эн тэргүүний зорилт мөн....” гээд “Монгол Улсын гадаад бодлогын **хоёр дахь** чиглэл бол өрнө, дорнын өндөр хөгжилтэй, хүчирхэг гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Энэ зорилтын хүрээнд АНУ-тай улс төрийн утгаар чухал түншийн хэмжээнд харилцана. Японтой Ази дахь нэг

гол түнш байхаар харилцана, Европт Европын холбоо бүхэлдээ, түүний дотор ХБНГУ-тай харилцахад түлхүү анхаарна” гэж анх бичсэнийг нь арай өөрөөр найруулаад нийтэлж байлаа.

Монгол Улс бие даасан гадаад бодлого явуулах үзэл баримтлалын үндэс нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дурдсанчлан “*Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна*” гэж тодорхойлсон заалт юм. Энэ санааг бичиж батлуулах гэж бид дотроо, өөр хоорондоо ихээхэн маргалдаж, мэтгэлцэж байж оруулж билээ.

Бид чинь тэр үед пролетарийн интернационализм, социалист интернационализм гэсээр байж өөрийн эрх ашгийг хоёрдугаарт үздэг, бусдыг дагадаг үзэл бодлоо бүрэн орхиж чадаагүй, “үндэсний үзэл”, “үндсэрхэг үзэл” хоёроо хольж хутгаж явсан үе байлаа. Тэрнээсээ айж эмээдэг байлаа. Ийм байдлаа 1994 оноос өөрчилж дээрх гурван үзэл баримтлалыг батлан төрийн нэг бодлого, зарчимд нэгтгэсэн юм. Ингэж байж өнөөдрийн сайн сайханд хүрч Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойтой золгож байна.

Ц.Гомбосүрэн / ГЯЯ-ны сайд асан, Соёлын гавьяат зүтгэлтэн, ОББЭЭС /

Өнөөдрийн хуралд морилон ирсэн эрхмүүдийг харахад бараг ихэнх нь 1994 оны үзэл баримтлалыг зохиолцож гэх үү, бичилцэж байсан, тэр үйл ажилд ямар нэг хэмжээгээр холбоотой буюу оролцож байсан нөхөд маань байна л даа. Тэгэхээр чинь одоо би юу ярих билээ гээд бодож үзлээ. Хавсралт илтгэл гэдэг нэр томъёоны хувьд бол одоо магтах, маргалдах юм надад алга.

Дээхэн үед ГЯЯ-нд Чимид гуай гэж нэг хүн байсан юм. Тэр Чимид гуай бол намын хуралд орж ирэхдээ л хэний тухай юу юу ярихаа хуралд оролцогсдыг ганцхан тойруулж хараад л шийддэг хүн байсан. Тэр тойруулж харах үед л нүдэнд нь өртсөн хүн бол тэр хурал дээр Чимид гуайн ярих сэдэв болдог байсан хэрэг. Ярих юм ч цээжинд нь бэлэн байдаг юмсан уу даа. Тэрэн шиг л цээжний пангаар хоёр гуравхан юм хэлье. Хэлэхдээ тулаад ирсэн чинь системтэй юм алга. Тэгэхээр уучлаарай.

Энэ үзэл баримтлал эдүгээ 20 насалж. Уржнан жил ч билүү дээ, эргэн харж, зарим нэг тодотгол, шинэтгэл хийсэн ийм л баримт бичиг. Миний бодож байгаагаар бол одоо элдэв төрлийн иймэрхүү баримт бичиг, тэр байтугай хууль хүртэл заримдаа олигтой ажиллахгүй ч гэх юмуу, ер нь амьдрахгүй, амин гол нь тасарчихаад байгаа гэхээр шахуу юмнууд байдаг л даа. Тэгж бодох юм бол МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал бол үнэхээр амьд баримт бичиг болж чадсан гэдгээ өнгөрсөн хугацаанд нотлосон гэж хэлж болно.

Амьд гэхийн учир нь гэвэл өнгөрсөн хугацаанд үнэхээр гадаад бодлого явуулах чиг баримжаа гэдэг ч юм уу, луужин гэх мэтээр тодорхойлдог тиймэрхүү зиндааны ач холбогдолтой баримт бичиг болж чадсан байна. Тийм баримт бичиг болохын чухам үндэс нь мэдээжийн хэрэг энэ баримт бичгийг бичиж, боловсруулж гаргасан хүмүүс, төрийн байгууллагууд энд орсон агуулгын гол гол санаанд анхнаасаа нэгдмэл санал бодолтой байсан учраас үнэхээр амьдрах чадвартай баримт бичиг болж гарсан хэрэг.

Тэрний өмнөхөн 1990 онд анхны үзэл баримтлал нэртэй нэг баримт бичигтэй болсон л доо. Тэр үед хялбарчлаад ч гэх үү, АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар батлуулчихсан. Тэр баримт бичигт эхнийхээ гол гол санаануудыг оруулсан байсан юм. Гэхдээ яг 1994 оных шиг тийм цэгцэрсэн хэлбэртэй биш байсан боловч ямар ч гэсэн шинэчлэлийн эхэн үеийн гадаад бодлогын удирдамж болохуйц баримт бичиг байсан.

Нөгөө талаас, одоо бидний амьдрах чадвартай гэж үзэж байгаа баримт бичгийн ард 70 жилийн ч гэдэг юм уу, бүр 80 жилийнхээ түүхийн сургамжийг дотроо сайтар бясалгаж, бас ойлгоод, тэр хэмжээгээрээ Монгол гэж улс цаашид байгаад, улмаар хуучин шигээ нэг системийн юм уу, эсвэл тэр системийг толгойлж байгаа том гүрний өвөр түрийд биш, харьцангуй биеэ даасан байдалтай явах юм гэвэл ямаршуухан байр суурьтай байх ёстой юм бэ? гэх бодол эргэцүүлээс зарим санаанууд гарч ирсэн. Тэгэхдээ хорвоод байхгүй санаанууд гарч ирсэн гэсэн үг биш л дээ. Харин Монгол улсын хувьд зайлшгүй бөгөөд цоо шинэхэн хэдэн чухал зарчим, санаанууд байдаг юм. Тэдгээрийг бид өнөөдөр дагаж хэрэгжүүлж байгаа гэж баттай хэлж болно.

1.Эвсэлд үл нэгдэх зарчим

Эвсэлд үл нэгдэх гэдэг ойлголтыг бид одоо бол нэлээн бүдгэрсэн гэж хэлж болохоор “эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн”–тэй заримдаа хутгаж ухаарах нь бий.Гэтэл уг ойлголт маань тэр хөдөлгөөнөөс арай өөр. Тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм.

Бид нэгэн үе “Варшавын гэрээ”-ний байгууллагын гишүүн гэсэн үнэмлэх бичиг байхгүй ч гэсэн үнэн хэрэг дээрээ тэр байгууллагын хавсралт гишүүн байсан. Үүний тов тодорхой илэрхийлэл нь Зөвлөлтийн цэрэг Монголын нутаг дээр байсан явдал. Тэгэхээр эвсэлд нэгдэхгүй гэсний цаад утга нь бол “дахиж аль нэгэн их гүрний цэргийн бааз болохгүй” гэсэн санааг зориуд тунхагласан. Үндсэн хуулинд бол гадны цэргийг зөөх тухайд зарчмын тодорхой суурь шийдлүүдийг бид хийж байсан.

Энэ мэтийг ярихын учир бол үзэл баримтлал маань амьд бичиг баримт гэдгийг нотолж буй хэдэн санааг л дахин давтан нуршиж байгаа ухаантай.

2. Хоёр хөрштөйгөө эн тэнцүү харилцах зарчим

Хоёр хөрштэйгээ эн тэнцүү, эрх тэгш харилцана гэсэн ойлголт одоо бидэнд байгаа. Энэ бол өмнөх үе буюу 1960-аад оноос хойш, 80-аад оны шувтарга хүртэлх үеийн үйл явдал, сургамжтай холбоотой. Бид тэр үед өмнөд хөрштэйгээ лав л 25 жил муудалцаж, толхилцож, үзэл суртлаар бие биеэ муулж, үгийн муухайгаар занаж зүхэж явсан.

Нөгөө талд нь хойд ах нарынхаа өвөрт улам бүр л шигдээд байсан хэрэг. Сүүлдээ “Брежневийн номлол” гэж яг тийм үг үсгээр зөвлөлтийн албан ёсны бодлого, баримт бичигт гардаггүй ч гэсэн бодитойгоор байсан “Брежневийн номлол” гэх зүйлийн нэгэн гол золиос нь үнэн хэрэг дээрээ монголчууд бид нар болсон л доо. 1976 онд “ЗХУ-тай бүх талаар ойртон нягтрах үндсэн чиглэл” гэсэн баримт бичгийг гаргаж, 2 талаасаа гарын үсэг зурж, тэрийгээ хэрэгжүүлэх чиглэлээр ихээхэн хүчтэй ажлууд хийж байсныг та нар мэднэ.

Сая Төмөрчулууны илтгэлд 4Д-гийн нэг буюу Desovietization (Десоветизация) гэсэн чиг шугамын тухай дурдагдлаа. Энэ бол бидний шинэчлэгдэхийн нэгээхэн чухал үзүүлэлт, том зорилт, зорилго болох ёстой байсан хэрэг.

Ингэж ирсэн зам мөртэй учраас л хэрвээ бид чиг бодлогоо шинэчлэн тунхаглаж байгаа бол мэдээжийн хэрэг хоёулантай нь их сайн байна аа гэж л тунхагласан хэрэг. Өөрөөр хэлбэл, хоёр хөршийнхөө аль алинтай нь харилцах харилцааг маань хооронд нь жишихэд тэнцвэртэй, эн тэнцүүхэн маягийн харилцаа байна гэж тунхагласан юм.

Эргээд харахад, “Хоёр хөрштэйгээ харилцах тухайд”, “Гуравдахь хөршийн тухайд” энэ тэр гээд л бидний тунхагласан тэр чиг шугам үнэхээр “маш сайхан гарчигнууд” л даа.

Харин энэ маань хэр зэрэг бодит амьдрал болж чадав аа? Нөгөө бодож санаад байсан хэмжээнд чинь хүрсэн үү? Хаанаа явна? гээд ярих юм бол шүүмжлэлтэй хандахаар зүйл бишгүй байна. Хэрэг дээрээ бид нар хоёр хөрштэйгээ харилцах асуудлыг тэргүүлэх түвшинд тавина гэхихээд Оростой харилцах бодлогын үзэл баримтлал, Хятадтай харилцах бодлогын үзэл баримтлал гээчээ боловсруулж байсан. Гэтэл сүүлдээ бараг л үзэл баримтлалын жагсаалт гаргах шахуу юм болсон. Бид нар лав л 30-40-ийг бичиж боловсруулсан байх.

1990 онд билүү дээ, Улсын Бага хурлаас намайг Зааны Ясан эрэгтэй харилцах үзэл баримтлал гаргаад ир гэж байсан санагдана. Тэр нь хэрэгтэй юу, хэрэггүй юу гэдэг нь нэг хэрэг л дээ. Яахав, асуудалд тодорхой хандах гэсэн, юм хийж гэсэн сурах гэсэн тийм л үйл ажиллагааны нэг хэсэг байсан байх.

Одоо бол Хятадтай харилцана, Оростой харилцана гэхээр “Стратегийн түншлэл” гээд явж байх шиг байна. Үүний улс төрийн харилцааны талыг нь харвал бараг л эцсийнхээ нэр цолыг өгчихөөд байгаа юм уу даа гэмээр. Тэгэхээр яваандаа цаашаа ахих газаргүй болох нь л дээ. Хамгийн сайхан л гэгцгээж байгаа юм байна. Тийм болох нь уу гэтэл Оростой жишээ нь тийм байна уу ?

Хоёр хөрштөйгөө харилцаагаа жигнээд, цэгнээд үзэхэд чухамдаа эн тэнцүү байна уу гэхээр бас л янз бүрийн юм яримаар. Улс төрийн хувьд яахав юм шиг. Нөгөө эдийн засгийн харилцаа гэдгээ, тэх тусмаа хөрөнгө оруулалт талаас нь ярих юм бол эн тэнцэх битгий хэл огт өөр, ерөөсөө хоёр шал ондоо тоо, үзүүлэлт харагдахаар шахуу тийм байдалтай байна л даа. Энэ юу хэлээд байна гэхээр бид нар сайхан эрх ашгийг жинхэнэ ажил амьдрал болгохдоо цаг цагийн тусгалыг шингээсэн нарийн бодлого явуулж чадахгүй, янз бүрийн салхинд хөөгдөөд яваад байсан юм биш биз гэж бодохоор.

Одоо энэ Крымын асуудал гараагүй бол хойд ах нар чинь бидэн рүү ингэж шуурах байсан юм уу? Крым гэдэг чинь чухамдаа зүй тогтолтой асуудал юм уу? Санаатай юу? Санаандгүй юу? гэх мэт. Тэгэхээр юу харагдаж байна вэ гэхээр бид нар үндэснийхээ эрх ашгийг дээдлээд тэрэнтэй ийм ийм хэмжээнд бол хэл амаа ололцоно гээд нарийн ширийн юман дээрээ жинхэнэ ухаан сийлсэн бодлогыг хэрэгжүүлэх учиртайг сануулах мэт.

Та бүхэн сайн мэдэж байгаа. Ноднин, уржнан хүртэл оросууд чинь 10 бил үү, 8 бил үү асуудал жагсаачихаад “цаадуулыгаа шийдэхгүй бол битгий харьц” гэж Медведев ерөнхийлөгч байхдаа хэлсэн юм гэнэ гэсэншүү л байдалтай байсан шүү дээ. Ингээд бодохоор өнөөх амин чухал бодлого маань амьдрал дээр яг нөгөө “гарчигийнхаа” хэмжээнд явж байна уу? үгүй юу? гэдэгт тээнэгэлзэх сэтгэгдэл төрөхөөр үе гардаг л юм.

3. “Гуравдахь хөрш”-ийн асуудал

Онцолж ярих ёстой нэг зүйл бол гуравдахь хөршийн асуудал. Ер нь 1990-ээд оны эхнээс 2000 он гартал шилжилтийн гэгдэх 10-12 жилийн хоорондох үнэнхүү хүнд нөхцөл байдлыг даван туулах үед “гуравдахь хөрш” гэж бөөнд нь нэрлэсэн тэр улсууд, тэр улсуудын идэвхитэй оролцож байдаг олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагууд бидний хувьд гачаал зовлонгоос аврах хүчин зүйл болсон. Тэр үүднээсээ 3 юмыг байтугай, 2 юмыг ч зэрэг, давхарлуулаад биччихэж болдоггүйн адил нэгдүгээрт хоёр хөрш, дараачийн дугаарт гуравдахь хөрш гэж бичихээс өөр аргагүй байсан. Гуравдахь хөршийн бодлого маань шилжилтийн

үеийг туулах гадаад бодлогын хувьд хоёр хөрштэйгээ харилцах харилцаатай дүйх хэмжээний чиг баримтлал байсан юм.

Энэ бүхнийг эргээд харахад бид энэ замаар боломжийн хэмжээнд урагшилсан байх гэж би хувьдаа боддог. Ямар ч байсан Монгол улс энэ XXI зууны эхээр төвхнөж байгаа олон улсын харилцааны шинэ системд, олон улсын нөхцөл байдлын дунд, хуучнаасаа нилээд өөр байр суурьтай, өөрийн гэсэн нэр хүндтэй ийм нэгэн улс болсон. Нилээд өөр байр суурь, нилээд өөр нэр хүнд гэдгийг би эерэг утгаар нь хэлж байна л даа. Энэ маань бидний баримталж ирсэн үзэл баримтлалтай холбоотой буюу тэр үзэл баримтлалыг хэрэгжүүлсний үр дагавар гэж үзэх ёстой байх.

Гуравдахь хөршийн бодлого гээд яривал тэр маань бидний анх бодож байсан шиг явж байна уу гээд асууж болохоор. Бид нарын тэр үед тавьж байсан зорилго ч гэдэг юм уу, ярьж байсан зүйл бол “гуравдахь хөршийн материаллаг сонирхолыг Монголд бий болгох нь нэн тэргүүний зорилт байна” гэж лоозондож байсан. Гэтэл өнөөдөр нөгөөдүүлийн маань материаллаг сонирхол Монголд хэр зэрэг бүрдэв ээ? гэхээр бас л “шилээ маажихаар” тиймэрхүү зураг харагдаад байгаа юм. Нөгөө дээр өгүүлсэн бодлогоо яг баримтлаад явах юм бол биднийг зовж байхад тусласан Япон, Америк, Герман эд нарыгаа ямар нэгэн утгаар илүү юм уу, давуу байдлаар авч үзэх олон улсын нэг хийсвэр зарчим байдаг. Манай одооны байдлыг харваас, олон улсын тендер зарлалаа гэхэд түүнийг нь мэдээж Солонгос юмуу, Хятадын нэг хувийн компани сайхан санал өгөөд л авчихдаг. Гэтэл бид нарын алсханаас дохиогоор харж хандаж байх ёстой, үлгэрлэж яривал гар хөлийг нь оруулах юмсан гэсэн тэр улсуудынхаа материаллаг сонирхлыг дэмжих бодлогоо өөрснөө элдэв хийсвэр чөдрөөр чөдөрлөөд байна уу гэхээр харагдах шинжтэй.

4. Гадаад харилцааны яамаа сонсдог болох хэрэгтэй

Сайхан тунхагласан, сайхан “гарчиг” бүхий бодлогынхоо задаргааг маш нарийн хийж, тэрийгээ орчин цагийн амьсгал, дэлхийн янз бүрийн хямрал буюу эс хямралтай холбож авч үзэж, бодлогоо ихээхэн уян хатан, шуурхай явуулж

байгууштай байна. Тэгж явуулахын тулд жишээ нь мэргэжлийн байгууллагынх нь хувьд ГХЯ-ныхаа үгийг Монгол дотроо сонсдог болгох хэрэгтэй байна. Манай гадаад яамныхан бодоод л, бясалгаад л, бичээд л байдаг, тэр нь дарга нарт хүрэх үү, үгүй юу тас гээд л доошоо хараад ойчоод байх шиг байгаа юм. Тийм учраас энэ мэргэжлийн байгууллагууд, тэр дотроо ГХЯ-ны үүрэг ролийг гэж хэлмээр ч юмуу даа, эрсхэн дээшлүүлмээр байна гэж бодогддог.

5. ГХЯ ба боловсон хүчин

ГХЯ маань ч цэгцтэй, жинхэнэ утгаар нь гадаад бодлогоо барьж чаддаг, дур зоргын ч гэх үү, эсвэл дэндүү хийсвэр маягийн алхам хийдэггүй, мэргэжлийн чадвар сайтай, шигшмэл боловсон хүчинтэй, үнэхээр үгийг нь сонсох учиртай, жинтэй яам байх ёстой. Гэтэл үзэл баримтлалын хэмжээнд авч үзэж баймаар зарим асуудлыг гэнэтхэн нэг хүн гаргаж ирээд, биелүүлээд байгаа юм шиг санагддаг. Жишээлбэл, дэлхийн бүх оронтой ч гэх юм уу, НҮБ-ийн гишүүн бүх оронтой дипломат харилцаа тогтооно гэдэг чинь үнэхээр нухацтай бодохоор асуудал шүү дээ. Үзэл баримтлалын хэмжээнд яривал манай одоогийн үзэл баримтлалд л лав тийм зүйл огт байхгүй. Энэ бол хуучин цагийнх шиг ердөө тоо хөөцөлдөж байгаа ч юм шиг, эсвэл дипломат харилцааг үлгэр домгийн, бүр эвгүйхэн хэлбэл, бантангийн юм шиг болгож байгаа хэрэг биш биз? НҮБ-ийн гишүүн бүх оронтой үгүйдээ ёс төдий харилцаатай байлаа ч гэсэн бид нар пянгий нь даахгүй. Юу өгч байгаа юм бэ? Юу олж авч байгаа юм бэ? Хожмын өдөр ийм зүйл түүхийн номонд орж мандаж мэдэх юм даа. Иймэрхүү юмыг эрхбиш буурь суурьтай, наад цаадахыг нь алсхан харж байж хийх ёстой л доо.

Бас аль нэг улсад Элчин сайдын яамаа байгуулна гэдэг биеэ даасан зарчмын асуудал. Бид нар хаа хамаагүй ЭСЯ-аа нээгээд байдаг. Гэтэл манайд ирдэг амьтан бараг байдаггүй. Дэлхийн том ч гэдэг юм уу, хандивлагч улсууд, Итали ч гэх юм уу, тиймэрхүү орнуудад бол байж болох юм. Элчин сайдын яам юу олох гэж явж байна? гэж давхар харах учиртай. Бразилд бид нар жишээ нь юу алдчихаад элчин сайдын яам байгуулах гэж байгаа юм бэ? Алдах биш олох гэж явах ёстой. Саяхан тийшээгээ туршлага судлах гэж хэдэн хүн явсан гэсэн. Тэр утгаар нь элчин сайдын яамаа нээж байгаа юм уу. Судлах гээд явсан юм нь юу

гэлээ дээ, боловсон хүчинтэй ажиллах гэв үү? Энэ мэтийн юмыг ул үндэстэй бодууштай асуудал. Тэр жил манай улс овоо хэдэн цаас олсон. Тэрнийхээ халуунаар нэг иймэрхүү юм шийдчихдэг. Эцсийн бүлэгт бид нар элчин сайдын яамаа яг ёсоор нь байгуулаад ажиллуулах гэтэл зардал нь алга байна гээд хөгийн юм болох байх даа.

ГХЯ-ны Боловсон хүчин гэсэн асуудлыг тойруулаад бодъё доо. Хуучин бол үнэхээр нарийн тогтолцоотой байсан, түүнийг тодорхой утгаар нь зөвтгөх ёстой. Зөвлөлтөд гол нурууг нь бэлтгэж байсан, “ах дүү социалист орнууд” гэгдэж байсан улсуудад бас заримыг нь сургаж байсан. Хожим нь өөртөө Олон Улсын харилцааны сургуультай болсон. Тэрнийг төгсөж байгаа залуучууд өнөөдөр Гадаад харилцааны яамны гол ажиллах хүчин болсон байх. Бид нар өөрснийхөө жишээн дээр мэднэ, сургууль төгсөөд хавтас авснаараа юм мэддэг хүн болдоггүй л юм байна лээ шүү дээ. Сүүлд нь практикийн тогоонд чануулж байж, үглүүлж дуулуулж байж л сая нэг юм зүгширдэг. Бичсэн юмаа улаан эрээн болгуулж байж л сурдаг. Тэр ажил энд одоо ямаршуухан байдаг юм бол?

6. Дипломат Академийг бодлогын хэмжээнд дэмжих хэрэгтэй

ГХЯ-ны Дипломат Академи гэдэг байгууллагын суурийг нилээд юм болж байж тавьлаа. Энэ бол ахиц. Тэгэхдээ хийх ажлыг нь энэ засаг үнэхээр бодлогын хэмжээнд дэмжиж, үйл ажиллагааг нь түргэн жигдрүүлэх хэрэгтэй. Ухаандаа Бразилд Элчин сайдын яам байгуулсан нэр зүүснээс, тэр төсвөөрөө Дипломат Академаа санхүүжүүлж, тэгээд энэ байгууллагыг хүчтэйхэн босгож ирэх хэрэгтэй. Энэ бол Бразилд ЭСЯ байгуулаад, тэр элчин сайдын яам нь хоёр орны харилцааг яралзтал хөгжүүлсэнээс хамаагүй илүү ашигтай зүйл болох учиртай юм.

Нэгэнт Дипломат Академитай болсных энэ байгууллагыг сайн дэмжиж, ёсоор нь ажиллуулж гэмээн ГХЯ дипломатуудынхаа мэргэжлийн чадавхийг сайжруулж, мэргэшсэн шинжээчид болгох нэг шинэ боломж гарч ирж байна. Үүний өгөөжийг гаргаж чадвал том ажил.

Би бол нэг бус газар гадаад харилцаа, гадаад бодлогын асуудлаар бодсон санаснаа ярьж явдаг хүн. Баабар даргатай бас олон нийтийн байгууллагад хамт

байдаг. Тэр шугамаараа бид нар цуглаад бодлогын тодорхой асуудлаар бишгүй л “юм” ярьгаадаг. Тэгж ярихад оролцож байгаа хүмүүс хоорондоо нилээд сайн ойлголцоод, нээрэн тийм юм гэж үзсэн санал ч юм уу, дүгнэлт ч юм уу зүйлээ “тэнгэр” лүү явуулж байгаа юм л даа. Тэгтэл нөгөө зүйл чинь тэнгэр дээр очсон хойно ч буцаад л бахь байдгаараа, нөгөө “юм” ч өөрчлөгдөхгүй байх нь хяслантай.

Хэнд ч хэрэггүй юм хийж, тэрнээсээ өөрөө ид бахаа хангаж, их юм хийчихсэн юм шиг бодож явахгүй байхыг дипломатууддаа хүсье. Мань мэт нь ч яах вэ, та нар минь л битгий тийм болчихоорой доо. Иймэрхүү жаахан гутранги өнгөөр энэ яриаг дуусгах болох нь байна. Баярлалаа

Др.М.Батчимэг / УИХ-ын гишүүн /

Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойн энэхүү хуралд урьсан ГХЯ-ны удирдлага, хамт олонд талархал илэрхийлье. Төрийн тулгуур баримт бичгийн нэг болох Гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулахад гар бие оролцсон ахмад дипломатууд та бүхний санаа бодлыг сонсох, санал бодлоо хуваалцах завшаан тохиолдсонд баяртай байна.

Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдсан 1994 онд бидний үеийнхэн дөнгөж сургууль төгсөөд ирж байлаа. Энэ баримт бичиг чухам яагаад батлагдах болсон, түүний ач холбогдол зэргийг хэсэг хугацааны дараа ухааж ойлгож байсан хүмүүсийн нэг. Эргээд харахад 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, тэр үед манай ахмадуудын Монгол Улсаа олон улсад хүлээн зөвшөөрүүлэхийн тулд явуулж байсан дипломат үйл ажиллагаа, хүчин чармайлт, улмаар 1990-ээд онд Монгол Улс Зөвлөлтийн шууд хараат байдлаас гарсны дараах гадаад орчинд бий болсон өөрчлөлтийн дагуу шинэ бодлого, үзэл баримтлалыг боловсруулсан зэрэг бүгд алсын хараатай, мундаг үйл ажиллагаа байсан нь харагддаг.

Тухайн үед өнөөгийнхтэй адил тодорхой хэмжээнд бэхэжсэн судалгааны төв, тинк танк, чөлөөт мэдээллийн урсгал байсангүй. Гэвч дээрх хүчин чармайлтууд бол манай ахмадууд гадаад харилцаагаар дамжуулан эх орныхоо тусгаар тогтнолыг бэхжүүлэхийн тулд их ухаан, хөдөлмөр зарж байсны хангалттай

нотолгоо гэж ойлгодог. Энэ ч утгаараа 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлал нь түүхэн ач холбогдолтой юм.

Шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдсаны дараа Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улс үндэсний аюулгүй байдлын бодлого, гадаад харилцаагаа үндэсний язгуур эрх ашигт нийцүүлнэ гэж зарласан нь их том алхам байсан. Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах, гуравдагч хөршийн бодлогыг тууштай баримтлах зэрэг өнөөг хүртэл үргэлжилж буй бодлогын маш чухал чиг баримжааг энэ баримт бичигт тусгасан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал 2010, 2011 онд тус тус шинэчлэгдсэн. Гэхдээ өмнө нь байсан суурь зарчмууд, чиг хандлага хэвээр хадгалагдсан, цаашид ч хадгалагдаж явах ёстой гэж боддог.

Харин үзэл баримтлалын хэрэгжилт ямар түвшинд байна вэ гэдэг нь нухацтай хандаж, дүгнэлт хийх ёстой асуудал мөн. Монгол Улс аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангана гэсэн том бодлого зарласан. Үүнийгээ бид өөрсдөө юу гэж ойлгодог вэ гэдэг хүртэл бидний өмнө тавигдаж байгаа чухал асуулт мөн.

Өнөөдөр Монгол Улс дэлхийн олон оронтой дипломат харилцаа тогтоосон, мөн олон улсын нилээд байгууллагын хүрээнд идэвхтэй ажиллаж байна. Тухайлбал, манай энхийг сахиулагчид улс төр, дипломатын аргаар аюулгүй байдлаа хангахад том хувь нэмэр оруулж байгаа гэж би хувьдаа боддог. Энхийг сахиулах ажиллагаанд цэргээ оролцуулах болсон нь 1990-ээд оноос хойш гарсан гадаад бодлогын том алхам, том шийдвэрийн нэг байсан.

Миний санахад 2008 оны намар ГХЯ, ССХ хамтарч “Улаанбаатар – Шинэ Хельсинк” сэдэвт олон улсын хурлыг зохион байгуулсан. Манай эдийн засгийн хүчин чадал, улс орны хөгжил, чадавх зузаараад ирвэл Улаанбаатар Зүүн хойд Азид Хельсинкийн үүргийг гүйцэтгэх боломжтой гэсэн эрмэлзэл бидэнд байдаг. Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Улаанбаатарын диалогийн санаачилгыг гаргасан. Энэ бол амаргүй ажил. Тийм ч учир холбогдох байгууллагууд дор бүрнээ үүнийг урагшлуулах тодорхой санаачилга, хүчин чармайлт гаргаад явж байна.

Өнгөрсөн оны 11 дүгээр сард УИХ-ын эмэгтэй гишүүдийн санаачилгаар Зүүн Хойд Азийн эмэгтэй парламентчидын хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Таван хэл дээр зэрэг орчуулга явуулах, хурал хийх хэдэн сайхан танхимтай болох гээд хүчин чадал, чадвар, туршлагатай холбоотой олон зүйл учир дутагдалтай байгаа юм билээ. Бид том бодлого зарлаж болно. Түүнийгээ дагаад зохион байгуулалт, эдийн засаг, хувь хүний чадавхтай холбоотой олон асуудлыг шийдэх хэрэгтэй гэдэг нь харагдаж байсан.

Өнөөдөр зохицуулалт нь хаягдсан, ойлгомжгүй байгаа бас нэг асуудал бол эдийн засгийн гадаад харилцаа. Хэн, хэрхэн авч явах вэ? гэдгээс эхлэн тодорхой болгох зүйлс бий гэж бодож байна. Гуравдагч хөршийн бодлогыг амьдруулахын тулд гуравдагч орнуудтай эдийн засгаар харилцах, тэдний хөрөнгө оруулалтыг бий болгох нь нэн чухал. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэг орноос оруулах гадаадын хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын гучин хувиас хэтрэхгүй байх бодлого баримтална гэж заасан байдаг. Энэ заалтыг амьдрал дээр хэрэгжүүлэх амар биш. Гэвч үүнийг хэрэгжүүлэх улс төрийн хүчин чармайлт, хүсэл эрмэлзэлтэй байх, тооцоо судалгаатай ажиллах чухал байна. Өнгөн дээрээ эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой мэт боловч гуравдагч хөршийн бодлогыг баталгаажуулах нэг чухал заалт гэж боддог.

УИХ-ын АБГББХ-ны гишүүний хувьд хэлэхэд, тус байнгын хороо өнгөрсөн оноос эхлэн тодорхой санаачлагууд гарган ажиллаж байгаа. Тухайлбал, ГХ-ны сайд Л.Болдод хүсэлт тавьж ГХЯ-ны залуу судлаачид, ахмад элчин сайд нар оролцсон судалгааны баг байгуулан гадаад бодлогын шийдвэр гаргах механизм өнөөдөр хэр зэрэг үр дүнтэй ажиллаж байгаа талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах ажлыг эхлүүлсэн. Судалгааны баг идэвхтэй ажиллан анхны дүгнэлтүүдийг гаргасан байгаа.

Мөн АБГББХ-ны дэргэд УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл болон миний бие ахалсан хоёр ажлын хэсэг байгуулсан. УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэлийн ахалж буй ажлын хэсэг нь гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд үнэлгээ өгөх үүрэгтэй бол манай ажлын хэсэг гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох санал боловсруулах үүрэгтэй. Бид ГХЯ-ыг түшиглэж хийгдсэн

энэ судалгааны багийн дүгнэлтийг бодлого болгож буулгах, байнгын хорооны тогтоол гаргуулах гол зорилготой ажилласан.

Ажлын хэсгээс гаргасан дүнэлтэд гадаад харилцааны дүн шинжилгээ хийх чадавх сул, гадаад бодлогыг нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах асуудлууд үндсэндээ орхигдсон байна гэж үзсэн. Гадаад бодлогоо зарлаж, тунхаглах нэг хэрэг. Тэр нь бодитоор хэрэгжихгүй бол баримт бичгийн ач тус бага. Яагаад хэрэгжихгүй байна гэдэг дээр Зөвлөлтийн үеийн гадаад харилцааны тогтолцооноос нэг их дээрдүүлж чадаагүй байна гэсэн дүгнэлтийг хийсэн. Жишээлбэл, хоёр хөрштэй харилцаж байгаа харилцаа өнөөдөр ГХЯ-аар гэхээсээ илүү Засгийн газар хоорондын комисс гэдэг 4 жил тутам өөрчлөгддөг, институцийн санамж байхгүй, улс төрчдөөс бүрддэг, зарим тохиолдолд сэтгэл хөдлөлөөр шийдвэр гарч болох бүтэц дээр тулгуурлан явж байна. Би өөрөө судлаач хүний хувьд ЗГХК гэдэг бол хуучин тогтолцооны үед ГХЯ-ыг тойрч гарахын тулд улс төрийн удирдлагаар гадаад харилцааг авч явж байсан бүтэц гэж ойлгодог. Дээрээс нь ГХЯ-ны Хөрш орнуудын газар гэхэд боловсон хүчний нөөц болоцоо ямар билээ гэдгийг бид мэдэж байгаа.

Бид гадаад бодлогоо нэгдмэл цонхоор харна гэж ярьсаар ирсэн боловч үүнийхээ хэрэгжилтийг зохицуулах бүтэцгүй явж иржээ. Энэ талаар гарсан эрх зүйн баримт бичиг гэвэл өнгөрсөн оны 1 дүгээр сард ҮАБЗ-өөс гаргасан гадаад бодлогыг нэгдмэл цонхоор явуулахтай холбоотой зөвлөмж, үүнийг дагалдсан Засгийн газрын 169-р тогтоол төдий л байна. Энэ тогтоолоор гадаад томилолт, айлчлал, гадаадын зочидтой хийх яриа хэлэлцээг уялдуулах зорилго тавьсан боловч хэрэгжилт нь учир дутагдалтай байгаа. Өөрийн туршлагаас хуваалцахад, гадаадын зочидтой хийсэн уулзалтын тэмдэглэлийг УИХ-ын гадаад харилцааны хэлтсээр дамжуулан зөвлөмжийн дагуу ГХЯ-нд өгөх гэсэн боловч ГХЯ-ны бүтцэд үүнийг авах, хариуцах албан тушаалтан байхгүй байсан. Ийм олон зүйл яагаад нуршаад байна вэ гэхээр бидэнд гадаад харилцаагаа нэгдмэл цонхоор уялдуулах хууль эрх зүйн зохицуулалт ч, бүтэц ч алга байгаа юм.

Олон улсад гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх хоёр хэлбэр байдаг юм байна. Үүний нэг нь улс төр, эдийн засгийн гадаад харилцааг

гадаад яам нь дагнан хариуцдаг практик. Үүнийг манайхан өнгөрсөн хугацаанд хийх гэж үзсэн хэдий ч үр дүнг нь үнэлэлгүй энэ 4 жилд буцаагаад задалчихсан. Нөгөө хувилбар нь эрх зүйн зохицуулалтыг нь хуульд сайн суулгаж өгөөд, процессоор нь хэрэгжүүлдэг туршлага. Дипломат албаны тухай хууль бол байгууллагын статус, эрх зүйн байдал гээд ерөнхий суурь асуудлуудыг зохицуулсан материаллаг хууль. Гэтэл гадаад бодлогын шийдвэр ямар байгууллагуудыг дамжиж, хэрхэн гарах вэ гэсэн процессын зохицуулалт бидэнд өнөөг хүртэл алга.

Өөр нэг асуудал гэвэл өнөөдөр ГХЯ маань дүн шинжилгээ хийх, нэгдсэн бодлогоор уях, төлөвлөлт хийх чадавх маш сул болсон байна. Яам дотроо ярьж байгаа учир гашуун үнэнийг хэлэхэд ГХЯ үндсэндээ ёслолын ажил хийж байна. УИХ-ын АБГББХ дээр хийж буй дүгнэлт бол бид ГХЯ-ыг шүүмжлэх гэхээсээ илүү дэмжих цаг нь болсон гэж үзэж байна. Яагаад гэвэл ГХЯ-ны хүн хүчний нөөц 1970-аад оны түвшинд хэвээр байна. Тэр үед бид 16 оронтой дипломат харилцаатай байсан бол өнөөдөр 160-170 оронтой дипломат харилцаатай, хэдэн арван олон улсын байгууллагын гишүүн болсон. Яамны ажилтнууд үндсэндээ зочин хүлээж авч, бичиг цаас орчуулсаар таардаг учир дүн шинжилгээ, төлөвлөлтийн ажил орхигддог. Нэгэнт бодлогын чадавх байхгүй учраас нэгдсэн зохицуулалтаар хангах боломжгүй болоод байна.

Ажлын хэсэг зарим тухайлсан зарим кейсийг авч үзсэн. Жишээ нь, Тавантолгой, Оюутолгой, төмөр зам гэсэн чухал асуудлууд дээр ГХЯ-ны оролцоо ямар байсан бэ гэхээр ГХЯ “тусгайлан өгөх саналгүй” гэдэг хариу өгсөн байсан. Нэгэнт тийм хариу авдаг учраас ГХЯ-наас асуухаа ч больсон зүйл анзаарагдсан. Тиймээс нэгдсэн зохицуулалтаар хангахын тулд яамны бүтцэд бодлогын дүн шинжилгээний нэгжийг дэмжиж ажиллах шаардлагатай байна.

Ажлын хэсгээс гаргасан гуравдахь дүгнэлт бол Монгол Улсын гадаад орчинд хурдацтай өөрчлөлтүүд гарч байгаа учир түүнийг дагалдаж олон сорилт тулгарч байна. Ерөнхийдөө ГХЯ болон УИХ-ын АБГББХ-ны ажлын хэсэг хамтран ажиллаж, дээр дурдсан дүгнэлтүүдийг хийсэн. Нэг сайн мэдээ гэвэл энэ ажлын үр дүнд төрийн гадаад харилцааны процессыг зохицуулсан сайн хуультай болох, ГХЯ-ны

дэргэд өндөр чадавх бүхий Дипломатын академийг байгуулж, үе шаттайгаар бэхжүүлэх талаар байнгын хорооны тогтоол саяхан гаргасан. Эдийн засаг, төсвийн байдал хүндрэлтэй байгаа учир өнөө маргаашдаа шууд төсөв нэмэх, том бүтэц байгуулах бололцоогүй байгаа ч, үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны ач холбогдол, тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэж, шат дараатай хэрэгжүүлэхээр заасан байгаа.

Үүний зэрэгцээ, яамны орон тоо бол онцлох чухал асуудлын нэг мөн. Нэгэнт бид аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангахыг, гадаад эдийн засгийн харилцаа хөгжүүлэхийг чухалчилж байгаа бол ГХЯ-ны албан хаагчдын тоог нэмэхээс өөр аргагүй. Төрийн данхайсан бүтэц гээд байгааг олон нийтэд аль болох зөв ойлгуулж, нэмэх ёстой газраа нэмэх шаардлагатай. УИХ, ҮАБЗ, Засгийн газар, ГХЯ болон бусад яамд, орон нутгийн удирдлага гэсэн субъектуудын харилцааг уялдуулах нэгдсэн зохицуулалтын нэгж ГХЯ-нд зайлшгүй байх ёстой юм билээ. Ийм нэгжийг бий болгох ёстойг тогтоолд мөн тусгасан байгаа.

Эцэст нь хэлэхэд хууль, тогтоол гаргах нэг хэрэг, түүнийг хэрэгжүүлэх бас нэг хэрэг. АБГББХ-ны зүгээс ГХЯ-тай хамтарч ажиллая гэсэн эрмэлзэлтэй байгаа. Ер нь АБГББХ-нд голдуу улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудал яригддаг учраас хэт улс төржөөд байдаггүй ганц байнгын хороо гэхэд болно. Өмнө яригдсан асуудлууд, мөн байнгын хорооноос гаргасан тогтоолыг аль аль нам, улстөрийн хүчний зүгээс их дэмжиж байгаа. УИХ, АБГББХ-ны зүгээс ГХЯ-тай хамтарч ажиллая гэсэн эрмэлзэл дүүрэн байгаа гэдгийг дахин хэлээд хурлын ажилд амжилт хүсье.

Б. Батбаяр/ Баабар, Нэрт нийтлэлч/

ЗХУ, БНХАУ-ын хооронд олон жил үргэлжилсэн газар нутгийн маргааныг нэг тийш шийдвэрлэх тохиролцоо 1980-аад оны эцсээр эхэлсэн билээ. Асуудлыг шийдэж амжаагүй байтал ЗХУ задран маргаантай улс орнууд хүрээгээ тэллээ. Үүнд юун түрүүн Киргизстан, Казахстан, Тажикстаныг нэрлэх хэрэгтэй. Чухам ийм үндсэн дээр хамтарч асуудлаа шийдэхийн тулд 1996 онд “Шанхайн тав” хэмээх байгууллага буй болсон юм. Тэр үед уг байгууллагын гол зорилгыг цэргийн салбар

дахь харилцан итгэлцэл, хил орчим дахь цэрэг зэвсгийн тоо хэмжээг харилцан бууруулах гэж томъёолж байв.

2001 онд Шанхайн тавыг зургаан орны гишүүнчлэлтэйгээр Шанхайн хамтын нийгэмлэг (ШХН) болгон өргөжүүлсэн юм. 2004 оноос уг байгууллагыг өөрийн төсөв, ажиллагааны механизмтай болгон албажуулжээ. Байгууллагын зорилгыг: хамтын итгэлцэл, найрамдал, сайн хөршийн холбоо, энх тайван аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлын төлөөх хамтын ажиллагаа, терроризм, салан тусгаарлал, хэт давралын эсрэг хамтран тэмцэх, улс төр худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа гэх мэтээр тодорхойлжээ.

ШХН 2004 оноос ажиглагчийн статус буй болгосонд хамгийн түрүүн Монгол улс нэгдэв. Гишүүнээр элсүүлэх урилгыг юун түрүүн Монгол, Туркменистан хоёр оронд тавьсан боловч түркменчүүд татгалзсан ба одоо болтол ямар ч холбоо тогтоогоогүй явсаар. Харин Монгол улс хоёр хөршийн байнгын урилга заллага, хатуу нэхлийн үр дүнд ажиглагчаар орсон юм. Дараа нь энэ нийгэмлэгт Энэтхэг, Афганистан, Пакистан, Иран улсууд ажиглагчийн статустай болсон ба Түрэг, Шри Ланка, Беларусь улсууд ажиглагчаар нэгдэх хүсэлтээ гаргачихаад байна.

Өнгөрсөн арав гаруй жилийн түүхийг эргэн харахад ШХН-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа төдийлөн тод харагдсангүй. Нийгэмлэгийн хүрээнд бүтээсэн томоохон ямар ч төсөл байхгүй байсаар. Бүхий л эдийн засгийн хамтын ажиллагаанууд хоёр талын, их сайндаа гурвалсан төслийн хэмжээнд явагдаж ирлээ. Мэдээж энэ тал дээр маш амжилттай хөгжиж байгаа. Орос-Хятадын худалдааны баланс 2000 онд гурван тэрбум доллар байсан бол өдгөө 80 тэрбумд хүрчээ. Хятадын байгалийн хийн импортын 20 хувийг Тажикстан ганцаараа хангаж байна.

ШХН-ийн анхаарлын төвд байдаг нэг хэрэг бол бүс нутгийн тогтвортой байдалд саад болж болохуйц газар нутгийн маргаантай асуудал юм. Эдгээр гишүүн орнуудын нийтлэг хилийн шугамын алинд нь ч талууд бүрнээ хүлээн зөвшөөрсөн димаркаци байхгүй. Үүнээс болж өнөөдөртөө маргаан шүүмжлэл өрнөөгүй боловч хэдийд ч хэрүүл шуугиан үүсэх магадлалтай.

Өөр нэг анхаарлаа хандуулж байгаа асуудал нь терроризм, сепаратизм, экстермизм болой. Энэ асуудал бүх гишүүн орнуудын хамгийн том зовлон болчихоод байгаа юм. Гэвч одоо болтол үр дүнтэй хамтын ажиллагааны механизм олоогүй байгаа тул хамтын ажиллагаа гэхээсээ тус бүрдээ өөр өөрийн замаар тэмцэл явуулж байгаа. Иймээс ШХН-ийг нэгдсэн ажиллагаатай байгууллага гэхээсээ байнгын уулзалт зохиож харилцан хөөрөлддөг клуб гэж тодорхойлдог судлаачид ч цөөнгүй бий. ШХН-ийн хүн амын 96 хувь, үндэсний нийт бүтээгдэхүүний 97 хувь нь Орос, Хятад хоёрт хамаарч буй тул зөвхөн энэ хоёр орны эрх ашгийг хамгаалах байгууллага ч гэж үзэх нь буй.

ШХН нь хэд хэдэн ажиглагчтай болсноос гадна нэмж нэгдэх орнууд шинээр хүсэлт гаргах болсонтой холбоотойгоор ирээдүйн бүрэлдэхүүний талаар нэлээд бэрхшээлтэй тулгараад байна. Жинхэнэ гишүүнээр элсэхэд бэлнээ илэрхийлсэн Энэтхэг, Пакистан хоёрын эхнийхийг нь Хятад зөвшөөрөхгүй сүүлчийнхийг нь зөвшөөрч байгаа бол Орос аль алиныг нь дэмжиж байгаа. Хоорондын харилцаа нэн таагүй Энэтхэг, Пакистан хоёр хамтаар гишүүнээр элсвэл энэ байгууллагын гадаад бодлого зөрчилд орон үйл ажиллагааных нь эрчим буурах төдийгүй утга учраар бага болно. Хэрэв ШХН нь терроризмын эсрэг тэмцлээ гол зорилгынхоо тэргүүнд тавьдаг юм бол олон улсын хоригт орж, террорист гүрэн гэж зарлагдсан Иран энд байгаа нь дэндүү логикгүй гэсэн шүүмж их гардаг. Америкийн цэргийн хүчин гарсны дараа ямархуу улс орон болох нь тодорхойгүй Афганистан яах вэ? Өргөдлөө өгөөд байгаа Түрэг ямар санаа цаанаа агуулж байна вэ? Азийн орон биш гэдэг шалтгаанаар түр түдгэлзүүлээд байгаа Беларусь ШХН-д нэгдэх болов уу?

ШХН анх байгуулагдахад АНУ үүнийг төдийлөн анзаараагүйн шалтгаан нь өөрийнх нь эрх ашигт нөлөөлөхгүй гэж үзэж байв. Харин 2004 оны Астанагийн уулзалтаар Киргизстан, Узбекистанд буй цэргийн баазаа татан буулгах хугацаагаа яаралтай тодорхойлохыг АНУ-аас шаардсан ба үүний дараахан Узбекистан нь Хятад, Оросын шахалтаар АНУ-ыг өөрийн нутагт буй баазаа зургаан сарын дотор татан буулгахыг тулгасан. Гэтэл Афганистанд талиб болон Алкайдагийн эсрэг явуулсан дайны үеэр ойр дөтөөр нь эдгээр оронд цэргийн баазаа байгуулахыг

сайшаан урьсан газар нь Орос өөрөө билээ. Ийнхүү сүүлийн арав орчим жилд ШХН нь тун аажуухан явцтай боловч улам бүр АНУ ба НАТО-той сөргөлдсөн блок болох зам руу дөтөлсөөр буй. Крымын үйл явдлаас болж Орос улс Өрнөдийнхөнтэй муудалцан хоригт орсон бол саяхан Обама Японд айлчлахдаа тэдний Хятадтай хийж буй газар нутгийн маргаанд АНУ нь Японыг дэмжихээ илэрхийллээ. Энэ нь Өрнөдийг сөрсөн цэргийн эвсэл шинээр үүсэх буюу бэхжин томрох шалтаг болох боломжтой. Орос, Хятад, Энэтхэг, Пакистан, Иран гэсэн бүгдээрээ цөмийн зэвсэгтэй ба АНУ-тай харилцаа нь төдийлөн сайн бус орнуудын бөөгнөрөл болж ч болох бололцоотой харагдана.

ШХН байгуулагдсан цагаасаа цэргийн хамтарсан сургууль хийх боллоо. 2003 онд Казахстанд болсон анхны сургуулилсад ШХН нь цэргийн эвсэл мэт харагдуулахаас болгоомжилсон Хятад оролцоогүй бол ердөө хойтон жил нь дараагийн сургуулилтыг өөрийн нутагт зохион байгуулжээ. 2005 оноос ШХН-ийн далбаан дор Орос-Хятадын томоохон цэргийн хээрийн сургууль “Энхийн элч” нэртэйгээр явагдан тогтмолжлоо. ШХН нь цэргийн холбоо биш, зөвхөн терроризмын эсрэг сургуулилт хийдэг хэмээн байнга мэдэгддэг боловч, том хэмжээний хээрийн сургууль, тэр дундаа далайн цэргийн сургуулилт нь зорилгоосоо асар хальсан мэт.

Монгол улс бол бүс нутагтаа алив оронтой хилийн ямар ч маргаангүй, хил хязгаар нь хөршүүдээрээ бүрнээ хүлээн зөвшөөрөгдсөн, бүтэн димаркаци хилтэй цорын ганц орон юм. Цөмийн зэвсэггүй бүс хэмээн НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн таван гүрнээр хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн цорын ганц орон. Бүс нутагт байнга аюул учруулж буй лалын хэт даврагсадын халдлага болон хүйтэн дайны үлдэгдэл явуулгаас хол хөндий байдаг. НҮБ болон Хамтын нийгэмлэгийн хүрээнд энхийг сахиулах ажиллагаанд идэвхитэй оролцон дипломат арга замаар аюулгүй байдлаа сахих Батлан хамгаалах бодлоготой улс. Хоёр хөрштэйгээ эв найрамдалтай зэрэгцэн оршихын зэрэгцээ дэлхийн бүхий л улс оронтой хамтран ажиллах “гуравдахь хөршийн бодлого” тунхагласан төвийг сахисан бодлого бүхий Гадаад харилцааны зарчмаа тунхагласан орон билээ.

О.Машбат /Гадаад харилцааны сайдын зөвлөх/

За баярлалаа. Чөлөөтэй ярих боломж олгосонд баярлаж байна. Гадаад харилцааны яаманд ажиллаж эхэлснээс хойш иймэрхүү боломж тун ховор олдож байсан юм байна.

Төмөрчулуун гуай их сонирхолтой илтгэл тавьлаа. Дэвшүүлсэн асуудлууд их сонирхолтой байна. Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах асуудлаас гадна “...гуравдахь хөрштэйгээ харилцах асуудал эдийн засгийн агуулгаараа, бодитой хэрэгжиж чадахгүй байна. Аль 1993 онд АРЕС-д элсэнэ гэсэн асуудал тавьсан ч одоо хүртэл элсэж чадаагүй л байна. Хамгийн гол нь хяналт тавих механизм байхгүй байсан учраас...” гэсэн дүгнэлт хийлээ. Гадаад бодлогын үзэл баримтлалыг шинээр боловсруулж батлах санал тавьлаа. Сонирхолтой санаа байна. Яагаад хэрэгжсэнгүй вэ гэдэг асуулт тавиад , урьд жилүүдэд хийсэн судалгаан дээр тодорхой ярьлаа.

Үзэл баримтлалын тухай ярихад надад нэг эргэлзээ төрдөг. Үзэл баримтлалыг ярихдаа “хэрэгжсэн үү?” гэсэн асуулт тавиад байдаг. Үүн дээр жаахан эргэлзээд байна. Хэрэгжүүлэх ёстой юу? эсвэл баримтлах ёстой юу? Баримталсан уу ? гэвэл баримталсан. Баримталсан учраас ч бид нар зохих үр дүнд хүрсэн. “Москвагийн заавраар явдаг” гэж шүүмжлүүлдэг байсан бол өөрийн гэсэн юмтай боллоо. Хэрэгжүүлэх ёстой зорилтууд, үзэл баримтлал, зарчмууд бол тэнд байдаг. Тэрнийгээ баримтлаад явсан уу ? гэвэл баримтлаад л явсан. Гуравдагч хөршийн бодлогыг идэвхитэй хэрэгжүүлэхийн төлөө ч боломжоороо анхаарсан..

Хэрэгжээгүй гэж үнэлэх дээрээ тулбал, яг хэрэгжсэн, хэрэгжээгүйг ямар хэмжүүрээр ярих юм бэ? Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцсан уу гэдэг дээр эргээд яривал, сүүлийн 20 жилийн хөрөнгө оруулалтын байдлаар авч үзэх юм бол хэрэгжээгүй, үнэхээр тэнцвэртэй харилцаагүй. Эдийн засгийн хэмжүүр талаас нь харвал шүү дээ.

Хойд хөрш бол манай төмөр замыг хянаж байна. Эрчим хүчийг тэр чигт нь хянаж байна. Ингээд бодохоор паразит тогтсон уу гэвэл тогтсон. Нэг иймэрхүү юм харагдаад байгаа.

Гуравдагч хөршийн бодлого хэрэгжсэн үү, үгүй юу гэсэн асуулт гарна. Бид нарыг Барууны орнууд, Америкийн Нэгдсэн улс дэмжиж байна уу гэсэн асуулт бас гарна. Улс төрийн хэмжүүрээр үзэх юм бол дэмжиж байгаа. НАТО-ийн global partner нь болчихсон, бас Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болсон. Иймэрхүү талаас нь асуудлыг харах юм бол бид үнэхээр дэмжлэгийг олсон байгаа. Харин эдийн засаг, хөрөнгө оруулалтын талаас нь хэмжих юм бол үнэхээр байхгүй.

Эндээс үзвэл хэрэгжсэн үү, үгүй юу гэдгийн хэмжүүр нь юу юм бэ? гэхээр байхгүй болчихоод байна. Харин хэрэгжүүлэх механизм, хяналт тавих механизм дээр бол үндсэн илтгэгчийг би дэмжиж байна.

Манайд одоо нэг том дутагдал ч гэх юм уу, цоорхой нүх манай бүх бодлогод харагдаад байдаг. Стратегийн судалгааны төв бол ойрын 10 жилд нэг иймэрхүү байх юм шиг байна, 5 жилд нэг иймэрхүү байх юм шиг байна, тэгэхээр бид нар тэр үед нь нэг ийм байвал зүгээр юм байна гээд ямар нэг хэмжээгээр төсөөлдөг, эсвэл ярилцдаг болчихож. Гэтэл тэр зүйлийг хэрэгжүүлэхэд дунд нь нэг шат байна аа. Тэр нь юу вэ? гэхээр төлөвлөлтийн судалгаа. Өөрөөр хэлбэл, 5 жилийн дараа бид тийм болохын тулд одоо байгаа нөөц хэрэгслийг хэрхэн хуваарилах вэ? гэсэн асуулт байх ёстой. Цаг хугацааны тухайд ч хуваарилах хэрэгтэй болж байгаа.

Энэ төлөвлөлтийн судалгааг бид нар ерөөсөө хийж өгөхгүй, эсвэл ерөөсөө энэ талаар бодохгүй байгаа учраас бид нар тэр стратегийн зорилтынхоо хэрэгжсэн эсэхийг өөрсдөө ч мэдэхгүй суугаад байгаа байхгүй юу. Үүндээ яаж хүрэх ёстой юм бэ? Бид нар тавьсан зорилтоо бодит амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд юу хийж хэрэгжүүлэх, түүний тулд ямар хүн хүч, нөөц бололцоо хэрэгтэй вэ? гэдгээ нарийн бодож байх ёстой. Гэтэл хүч хэрэгслийнхээ хуваарилалтыг хийхдээ бид жаахан алдаад байгаа юм шиг. Үүнийг хийхийн тулд хэдэн хүн хэрэгтэй юм, хэдэн төгрөгөөр хийх ёстой юм гэдэг талаар ямар ч судалгаа байхгүй, төлөвлөлт нь ч

байхгүй байх шиг. Тэгэхээр хуваарилалтын хувьд би ямар бодолтой байна гэвэл гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжилтийн талаас нь авч үзэн өөрчлөх ёстой юу? гэдэгт хариу хаймаар байгаа юм

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гэхээсээ илүү цогцоор тавьчихсан зорилтууд болон зарчмууд нь тодорхой байгаа. Харин үүнээс ургуулаад Гадаад бодлогын үзэл баримтлал гэхээсээ илүү гадаад бодлогын стратеги гэдэг нэртэйгээр, илүү төлөвлөлттэй, 5 жилийн дотор ийм юм хийнэ, 10 жилийн дотор ийм юм хийнэ, тэгж байж бид энэ Үндэсний аюулгүй байдлын зорилтуудыг ингэж хэрэгжүүлнэ гэсэн нэлээн прагматик буюу хэмжиж болохуйц үйл ажиллагааны жагсаалттай, нөөц хэрэгслээ хуваарилчихсан тийм л зүйл гаргавал илүү зохистой байх болов уу гэж бодож байна.

Гадаад харилцаанд, ялангуяа дипломат харилцаанд хэрхэн хандах талаар хийсэн стратеги төлөвлөлт байх ёстой. Түүндээ бид хүчээ хаях нь илүү үр дүнтэй байх болов уу. Үүнээс улбаалаад бид боловсон хүчнээ нэмье, төсвөө нэмье гэсэн асуудлууд ургаж гарах юм. Бид үнэхээр ийм урт хугацааны төлөвлөлттэй болчих юм бол нөөц хэрэгслээ хуваарилсан төлөвлөлттэй болчихно. Тэгж чадвал нэгдсэн бодлогын тухай асуудлууд ч цэгцтэй болж, улс төрийн сонгуулиас сонгууль дамжаад боловсон хүчний болон ерөөсөө бүх бодлого нь савлаж байдаг гэсэн шүүмжлэлүүд нь алга болно. Яагаад гэвэл тогтвортой, удаан хугацаанд, бодитой хэрэгжих төлөвлөгөөтэй болчих учраас.

Др.Ж.Энхсайхан /Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд/

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, түүний үзэл санааны дагуу улс төр, нийгэм-эдийн засгийн шинэ бодлого явуулж эхэлж байх үед төрөөс үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалах чиглэлээр баримтлах бодлогын үндсийг тодорхойлсон баримт бичгүүд гарсан юм.

Тэр үед миний бие ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын албыг хашиж, төрийн бодлогын үндсийг тодорхойлсон энэ 3 баримт бичгийн хоорондын уялдааг ҮАБЗ-ийн ажлын хэсгийн хэмжээнд хангах үүргийг хариуцаж байсан.

Монголчуудын хэлдгээр “тулгын гурван чулуу” гэж тодорхойлмоор эдгээр баримт бичгийг боловсруулахад оновчтой олон санаа гарч, тэр үеийн улс төрийн хүчнүүд зарчмын гол асуудлуудаар санаа нийлж байсныг энд зориуд цохон тэмдэглэмээр байна. Мөн мэргэжлийн холбогдох байгууллага, хүмүүсийн саналыг авч ажилласны дүнд эдгээр баримт бичиг агуулгын хувьд баялаг болсон. Тиймээс ч өнгөрсөн 20 жилийн хугацаанд эдгээр бодлогын баримт бичгүүд түүхэн үүргээ биелүүлсэн гэж бодож байна. Түүний нэг нь гадаад бодлогын үзэл баримтлал (ГБҮБ) байсан юм.

ГБҮБ-ын агуулга, ач холбогдлын талаар Г.Төмөрчулуун доктор тодорхой ярьлаа. Түүнийг боловсруулах үед Гадаад явдлын яамыг тэргүүлж байсан Ц.Гомбосүрэн сайд ч тодорхой дурсаж, цаашид анхаарах зүйлийн талаар хэллээ.

ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын хувьд би тэр үед ГЯЯ-тай нягт хамтарч ажилласан. Миний гол үүрэг бол ГЯЯ-наас оруулж ирсэн үзэл баримтлалын үзэл санаа ҮАБҮБ-ын үзэл санаатай нийцэж байгаа эсэх, гурван үзэл баримтлалын хооронд зарчмын ялгаа, зөрүү гаргуулахгүй байхад анхаарч ажиллах явдал байсан.

Энэ 3 баримт бичиг, нэн ялангуяа ҮАБҮБ, ГБҮБ-ыг харьцуулбал нэг нь зарим талаар нөгөөгөө нөхсөн чанартай болсон. Иймээс аль алийг нь уншиж байж үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын талаар илүү цогц ойлголттой болно.

ҮАБҮБ аюулыг 9 багцад хуваан ангилсан байдаг. Гадаадын аюулын хүчин зүйл Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдлаар хязгаарлахгүй, мөн эдийн засаг, нийгэм-төрийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөө, экологи, мэдээллийн аюулгүй байдал, тэр ч байтугай хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд ч нөлөөлж байдаг. Учир нь дээр өгүүлсэн чиглэлийн аюулгүй байдлыг хангахад мөн л гадаадын хүчин зүйл, хамтын ажиллагаа чухал. Тиймээс ГБҮБ-д тусгагдаагүй зарим санааг ҮАБҮБ-д тусгах талаар ГЯЯ-тай хамтарч ажилласан. Мөн ҮАБҮБ-д тусгагдсан зарим санааг ГБҮБ-д арай дэлгэрэнгүй оруулсан байдаг.

Тухайлбал, далайд гарцгүй орны тухай, хоёрдмол харъяаллын тухай заалт ГБҮБ-д тусгагдаагүй боловч ҮАБҮБ-д тусгагдсан байдаг. ГБҮБ-д эдийн засгийн хамтын ажиллагааны нэг хэлбэр бол концесс олгох явдал байж болно гэж заасан байдаг. Харин концессийг хэрхэн ойлгох талаар ҮАБҮБ-д тодорхой зааж өгсөн гэж хэлж болно. Тэр баримт бичигт ... “гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх аливаа хөнгөлөлт, тэдний эдийн засгийн сонирхлыг хамгаалах арга хэмжээг монголын үндэсний үйлдвэрлэгчид, хөрөнгө оруулагчдад үзүүлдэг хөнгөлөлт, эдийн засгийн нөхцлөөс давуутай болохоос сэрэмжилж, хяналт тавина” гэж заасан байгаа. Хоёр хөрштэй харилцах бодлогын хувьд гэвэл ГБҮБ-д тэрхүү харилцааг гадаад бодлогын эн тэргүүний зорилт, тэр хоёр оронтой тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ гэж заасан боловч “тэнцвэртэй харилцах” гэж чухам юуг хэлэхийг тодруулаагүй байдаг. Тэгвэл ҮАБҮБ-д тэнцвэртэй харилцана гэж адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь “итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэхийг хэлнэ.... Эдгээр орнуудтай харилцахдаа хөрш орнуудаас Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, нэн ялангуяа үндэсний язгуур ашиг сонирхолын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзаж байна. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож, төвийг сахих бодлого баримтална” гэж тодорхой заасан байдаг.

ҮАБҮБ-д тусгагдаагүй боловч ГБҮБ-д тодорхой тусгагдсан заалт бол үндэсний ашиг сонирхолын тухай заалт юм. ГБҮБ-д ... “үндэсний ашиг сонирхолд ихээхэн нөлөө бүхий төслийг хэрэгжүүлэхдээ хамтран ажиллах улс буюу түншийг улс төрийн ашиг сонирхолын үүднээс сонгохыг чухалчилна” гэж тодорхой заасан байдаг. Мөн “улс төр, эдийн засаг, ШУТ, соёл хүмүүнлэгийн хүрээний гадаад харилцааны бодлого дотроос улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна” хэмээн тодорхой зааж өгсөн нь олон асуудалд хариу болсноороо чухал болсон юм.

Дурдсан гурван баримт бичгийг боловсруулж байх үед тэдгээр нь эрх зүйн хувьд ямар хүчинтэй байх талаар нэлээд ярилцацгаасан. УИХ-ын хэмжээнд

хуулийн адил жишгээр хоёр уншилга хийж батлах баримт бичигүүд нь ямар ч л байсан зүгээр тунхаглалын чанартай байж таарахгүй гэж үзэж байсан. Тиймээс тэдгээрийн хэрэгжилтийг үе үе гаргаж, УИХ-д танилцуулж байх хэрэгтэй юм гэсэн санаа тэр үед давамгайлж байсан. Гэвч тэр үед энэ талаар тодорхой шийдвэр гараагүй юм даг.

Мөн 3 баримт бичгийн төслийг хэлэлцэж байхад “нэг орноос хэт хараат байдалд орохоос сэрэмжлэх” гэдгийг яаж ойлгох, “нэг орноос технологийн хараат байдалд орох”-ыг яаж хэмжиж тодорхойлох, “гадаадын дарамт шахалт”-ыг яаж тодорхойлох, “бусад улсын стратегийн сонирхолыг бий болгох” гэж чухам юуг хэлэх, г.м. асуултууд гарч байсан. Үүнтэй холбогдуулж үзэл баримтлалуудын хэрэгжилтийн явцыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн тухай асуудал ч гарч байсан. Гэтэл тодорхой шалгуур үзүүлэлт гаргахад нэлээд судалгаа, цаг хугацаа шаардагдах байсан. Нөгөөтэйгүүр 3 баримт бичгийг 1994 оны хаврын чуулганаар батлан гарахаар тохирсон байсан тул шалгуур үзүүлэлтийн асуудлыг үзэл баримтлалуудыг батлаад хэрэгжүүлж байхдаа аажимдаа гарах нь зохимжтой юм гэж тухайн үед үзсэн юм.

Др.Ц.Батбаяр / ГХЯ-ны БТСГ-ын захирал /

Анхлан 1992 оны үндсэн хуулийн 10 дугаар зүйлд Монгол Улсын гадаад бодлогын үндсийг “олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлаж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж тодорхойлсон байдаг.

1994 оны 06 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан гадаад бодлогын үзэл баримтлалыг манай судлаач, эрдэмтэд “шилжилтийн эхэн үеийн гадаад бодлого, үйл ажиллагааны туршлагаар нотлогдсон практикт суурилахын хамт орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлагыг Монголын хөрсөнд тусгасан” чухал баримт бичиг болсон гэж дүгнэж үздэгтэй санал нэг байна.

Харин Монгол Улсын хувьсан өөрчлөгдсөн гадаад харилцааны шинэ орчин, түүний өөрчлөлт, бодит хэрэгцээтэй уялдуулан уг баримт бичгийг Монгол Улсын Их Хурал 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр шинэчилсэн бөгөөд өнөөдөр бид дээрхи үзэл баримтлалыг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгон ажиллаж

байна. Өнөөдрийн энэхүү “Гадаад Бодлогын үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан онол, практикийн бага хурал”-д Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд туссан түншлэлийн харилцааны хэлбэрийг ГХЯ хэрхэн эрэмбэлж ажиллаж байгаа тухай болон ингэхдээ баримтлаж буй шалгуур үзүүлэлтийн тухай нэг бүрчлэн ярилцая гэж бодож байна.

Ерөнхийд нь танилцуулвал: Тухайн улстай хөгжүүлж буй хоёр талын харилцааны агуулга, ач холбогдол, даацаас нь хамааруулж бид өнөөдөр дараах 4 эрэмбээр түншлэлийн харилцаагаа ялгаж, эрэмбэлж байна. Үүнд:

1. Стратегийн түншлэлийн харилцаа (ОХУ, БНХАУ, Япон)
2. Иж бүрэн түншлэлийн харилцаа (БНСУ, Энэтхэг, АНУ, ХБНГУ, Түрк)
3. Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа (Канад, Австрали, Казакстан)
4. Түншлэлийн харилцаа (бусад орон)

Тэдгээрийг дэлгэрүүлэн авч үзвээс:

1.Стратегийн түншлэлийн харилцаа

Дээр дурьдсанчлан түншлэлийн харилцааны хамгийн өндөр түвшин буюу Стратегийн түншлэлийн харилцааг Монгол Улс ОХУ-тай 2009 оноос, БНХАУ-тай 2011 оноос, Японтой 2010 оноос хойш хөгжүүлж байна. Ингэхдээ Стратегийн түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцлийг иш үндэс болгож байна.

1. Хоёр улсын хоорондын харилцааны хамгийн өндөр түвшинг илэрхийлнэ
2. Урт хугацааны тогтвортой харилцаа байна
3. Улс төрийн итгэмжилсэн харилцааг тогтоож, өндөр дээд хэмжээний айлчлалын давтамжийг ойртуулна
4. Олон улсын болон бүс нутгийн томоохон асуудлаар бодлогын зохицуулалт, хамтран ажиллах механизм шаардах харилцаа

5. Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, нэмэгдүүлэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах зэргээр эдийн засаг, худалдааны урт хугацааны тогтвортой харилцаа, харилцан хамааралтай болно
6. Батлан хамгаалах болон цэргийн салбарт бие биендээ техникийн туслалцаа үзүүлэх, цэргийн мэргэжилтэн бэлтгэхэд туслах зэргээр хамтран ажиллана
7. Соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрнэ
8. Гамшигтай тэмцэх, гамшгийн хор хохирлыг арилгах талаар бие биендээ туслана
9. НҮБ-ын болон олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд хамтран оролцоно
10. Түүх,хэл,соёл,уламжлалын уг холбоог харгалзана

2.Иж бүрэн түншлэлийн харилцаа

Түншлэлийн харилцааны дараагийн түвшинд буюу Иж бүрэн түншлэлийн харилцааг Монгол Улс АНУ-тай 2004 оноос, Түрктэй 2005 оноос, ХБНГУ-тай 2008 оноос, Энэтхэгтэй 2009 оноос, БНСУ-тай 2011 оноос хойш тус тус хөгжүүлж байна. Ингэхдээ Иж бүрэн түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцлийг иш үндэс болгож байна.

1. Улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн байна
2. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж ажиллана. Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжинэ
3. Боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт идэвхтэй хамтран ажиллана. Мэргэжилтэн бэлтгэхэд харилцан туслана

4. Батлан хамгаалах салбарт мэдээлэл, туршлага солилцох, мэргэжилтэн бэлтгэх зэргээр хамтран ажиллана
5. Хоёр улсын харилцан итгэлцлийг бэхжүүлэхийг эрмэлзэнэ
6. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын зэрэг бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж буй учир иж бүрэн түншлэл хэмээн нэрлэж байна

3.Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа

Түншлэлийн харилцааны гуравдугаар түвшин буюу Өргөн хүрээтэй түншлэлийн харилцааг Монгол Улс Канад-тай 2004 оноос, Австрали, Казакстантай 2007 оноос хойш тус тус өрнүүлж байна. Ингэхдээ Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцлийг иш үндэс болгож байна.

1. Улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн байна
2. Эдийн засгийн тодорхой салбаруудад хамтын ажиллагаа хөгжүүлнэ
3. Боловсрол, шинжлэх ухаан, соёл зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж эхэлнэ
4. Цаашид харилцаа, хамтын ажиллагааг өөр бусад салбарт хөгжүүлэхийг эрмэлзэнэ
5. Өргөн хүрээтэй түншлэл нь улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарыг биш, харин харилцан сонирхсон хэд хэдэн салбарыг онцлон хамардгаараа иж бүрэн түншлэлээс ялгаатай, зэрэглэлийн хувьд түүнээс доогуур түвшний харилцаа юм

4.Түншлэлийн харилцаа

Түншлэлийн харилцааны ерөнхий нөхцлийг дараах үзүүлэлтүүдийг иш үндэс болгон авч үзэж байна.

1. Хоёр улс байнгын харилцаатай байж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ
2. Улс төрийн харилцаа сайн болж тогтмолжино
3. Эдийн засаг, худалдааны харилцаа зарим чиглэлээр хөгжиж эхэлнэ
4. Боловсрол, шинжлэх ухаан, соёл зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт харилцаа, хамтын ажиллагаа нэмэгдэнэ
5. Түншлэлийн харилцаа нь хоёр улс хамтран ажиллах эхний түвшин бөгөөд ердийн дипломат харилцаатай харьцуулахад байнгын шинжтэй, цаашид аль ч салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдэж байгаагаараа онцлог.

Эцэст нь хэлэхэд ГХЯ-ны зүгээс хоёр талын түншлэлийн харилцаа нэг бүрийг шат ахиулан хөгжүүлэх, агуулга чанарыг нь дээшлүүлэх чиглэлд анхаарал тавин ажиллаж байна. Цаашид ч хүчин чармайлтаа сайжруулан ажиллах болно.

Др.Ж.Чойнхор /ГЯЯ-ны Тэргүүн дэд сайд асан, ОББЭЭС/

Баярлалаа.Хорин жилийн өмнө батлагдсан үзэл баримтлал маань маш чухал баримт бичиг болжээ. Дараа нь 17 жилийн дараа шинэчлэгдэн найруулагдаад хэрэгжиж яваа ийм зүйл юм. 20 жилийн өмнө маргалдаж байсан, мэтгэлцэж байсан, оруулах гэж зүтгэж байсан гэх мэт янз бүрийн л юм болж байлаа.

Цэргийн номлол, гадаад бодлогын үзэл баримтлал хоёр их холбоотой чухал баримт бичиг. Би Цэргийн номлолын талаар юм асууя, ярья гэж бодож байтал Ц.Дашзэвэг генерал дэлгэрэнгүй сайхан ярьж өглөө. Тэр үед Ерөнхий сайд Ц.Дашзэвэг генерал бид хоёрт “гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол хоёр бол яв цав нийлж байх ёстой чухал бичиг баримтууд шүү” гэж хэлж байсныг би тод санадаг юм.

Улсын их чухал ажил хийдэг улсууд тэндээсээ дорхноо гараад явчихдаг юм. Их ажилтай байдаг байлгүй. Гадаад бодлого гэхээсээ дотоод бодлого нь илүү

сонирхолтой байдаг юм уу даа гэж боддог. Иймэрхүү янзын хурал цуглаан хийхэд төрийн буулганд нь зүтгэж үзсэн улсууд л сонирхож байгаа харагдаад, бусад нь анхаарч өгөхгүй байдаг. Дотроо бодолтой явдаг байлгүй.

Д.Мягмар бид хоёрын байгуулсан Геополитикийн хүрээлэнгийн шугамаар энэ асуудлаар ордонд хурал хийхэд Н.Энхболд, Р.Амаржаргал, Сү.Батболд, Ё.Отгонбаяр, М.Батчимэг, Ц.Цолмон гэх хэдэн хүмүүс л орж ирж чагнаж байх шиг байдаг. Бусад нь анхаардаггүй. Гэхдээ амьдрал дээр тулаад ирэхээр геополитикийн асуудлаар маргалдаад байгаа юм. Х.Баттулга гишүүнтэй яриад байгаа юм нь босоо тэнхлэгийн асуудлаар яриад байгаа юм шиг боловч хэвтээ тэнхлэгийн асуудал биш байгаа даа гэж би дотроо бодож байдаг. Ингээд хэдэн зүйл хэлье.

1993 онд Оростой, 1994 онд Хятадтай шинэ цагийн найрсаг хамтын ажиллагааны гэрээ байгуулчихсан байгаад, дараа нь туршлагатай болж аваад үзэл баримтлалаа баталсан хэрэг. Тэр болтол хоёр талын гэрээ байгуулж, харилцаа тогтооход НҮБ-ын дүрмийн зарчмуудыг оруулаагүй яваад байсан юм билээ. Мэдэхгүйдээ юм уу, санамсаргүй юм уу, санаатай юм уу, хүчинд автсан уу, ямар ч атугай оруулахгүй л яваад байсан юм билээ. НҮБ-ын 7 зарчим, Хелсинкийн гурвыг нэмээд олон улсын харилцааны 10 зарчмыг анх удаа Орос, Хятадтай байгуулсан гэрээнд тусгасан юм. Тиймээс үзэл баримтлалд энэ талаар их сайхан тусгагдсан.

Үзэл баримтлал бол хууль биш. Баримтлахгүй бол ингэж шийтгэнэ гэсэн зүйл байхгүй. Тиймээс би О.Машбатын хэлсэн санааг дэмжиж байна. Үзэл баримтлал бол баримжаа авч явах л зүйл. Сүүлийн шинэчилсэн хувилбар дээр хэрэгжүүлэх механизмын талаар нэмсэн, оруулсан заалт харагддаг нь буруу зүйл бол биш. Гадаад харилцааны салбарт байж болох бүх асуудлыг нарийвчлаад заагаад байдаг баримт бичиг биш ээ. Ноён нурууг нь баримталж авч явах ёстой бичиг баримт болохоос тэрийг тэгнэ, энийг ингээгүй байна гээд байх зүйл биш. АНУ-ын Үндсэн хууль бол маш товч, маш ерөнхий байдаг. Ерөнхий зүйл эргээд буух газартай, амар байдаг. Хэтэрхий нарийвчилчихсан зүйл эргээд ороогдоод байдаг.

“Хар хайрцгийн бодлого” гээд нэг зүйл байдаг. Тэр нь ямар эд байдгийг мэдэхгүй юм. Төрийн тэргүүнтэй их ойрхон явж байснаараа манай Ц.Гомбосүрэн сайд мэдэж байж мэдэх юм. Би бол хараагүй. Байдаг бол нэрийг нь Алтан хайрцгийн бодлого гээд гоёчилчихож болмоор ч юм шиг. Элдэв долоон юм оруулахгүй, заавал Монголчуудын аминд тулсан л юмыг оруулна гэх л юм. Ганц нэг хүн юм бичиж өгөөд л байсан. Тэр нь байдаг юм уу, үгүй юм уу. Ц.Элбэгдорж ерөнхийлөгчийн аль сейфэнд, ямар юм байдаг юм бол? Байдаг л байх гэж залбирая. Тэрийг нь ингэж хийх ёстой юм гэдэг тал дээр бидэнд санаа оноо зөндөө бий.

Гадаад бодлогын үзэл баримтлалыг сайн боловсруулсан юм байна. Гурван жилийн дараа сайжруулаад тавьсан юм байна. Хамгийн гол нь цаашдаа яах юм бэ? М.Батчимэг гишүүн бол ГХЯ-ны байдлыг ноцтой дүгнээд, цаашдаа яах вэ гэдгийг бодолцсон юмнууд ярилаа. Үнэхээр тийм байж магадгүй юм гэж бодож байна. Энэ асуудал дээр эрдэмтэн судлаачдыг ГХЯ-нд оруулж ирээд, хүч сэлбэж байгаа нь зүйтэй байх.

Геополитикийн асуудлыг авч хэлэлцэж, анхаарч байхгүй бол бодлого явуулах гэж оролдоход тун их халтиргаатай байна гэж харагдаж байна. Дэлхийн геополитикийн нөхцөл байдал шинэчлэгдсэн шүү. Үүнийг мэдэж байх зайлшгүй шаардлагатай. Стратегийн гурвалжинг мэдэхгүйгээр дэлхийн бодлогод оролцоно гэж бодож болохгүй. Үүний хувьд Монголчууд бид үүцээ нээчихсэн. Бид эндээ ч ийм алттай, тэндээ ч тийм зэстэй гэж хангинаад, гуравдагч хөрш гэж оруулаад л байгаа. Говио ёстой гомдлын нулимсны төв болтол начигнуулж байна. Үүнийг дагаад баялгийн хараал гэж яриад байдаг юм бий. Бусад орнууд зовж л байх шиг байдаг юм. Афганистан, Ирак эднүүс баян л орон юм гэнэ лээ. Африкийн орнууд чинь их л баялагтай байж байгаад л балраад байгаа юм шиг харагддаг.

Бид нилээд саруул ухаан зарж байж, нилээд юм болж байж сая таван зуун км квадратаа авч үлдсэн юм шүү. Бид хилийн маргаангүй улс гээд л зарлаад байдаг. Өөрсдөө л хүлээн зөвшөөрчихсэн улс болохоос биш, Монголыг гурав хуваагаад, голыг нь бидэнд үлдээчихсэн юм шүү дээ. Бид албан ёсоор зөвшөөрсөн л болохоос Өвөрмонгол, Буриад чинь Монгол биш гэж арай хэлэхгүй байлгүй. Бид

зөвшөөрөөд, мартчихсан улс. Бусад нь мартаагүй болоод өнөөг хүртэл маргалдаад л байх юм билээ. Элдэвтэй нэг нь эвсэлд нэгдээд Нэгдсэн холбооны бүгд найрамдах улс болчихсон л байна. Бид тэгэх гэж байгаа юм биш. Гэхдээ дотроо бодоод явах нь чухал. Хэзээ нэгэн цагт юу болохыг хэн ч тааварлаж мэдэхгүй болохоор энэ талаас нь тогтуухан, алстай бодохгүй бол болохгүй. Бүх юмыг өнөөдрийн байдлаар нь авч үзэж бас болохгүй.

Илтгэгч сонирхолтой илтгэл тавьсан. Сонирхолтой саналууд дэвшүүлсэн. Тэднээс хамгийн сүүлийнх нь нэг “Д” Диверсификаци гэж хэлсэн. Тэрэн дотор 7 байгууллагыг нэрлэсэн. Хамгийн сүүлийнх нь СІСА гэсэн. Ц.Даваадорж доктортой би СІСА-ын хуралд оролцож байсан юм. Сонин хурал байна лээ. Ганцхан тэрэнд нь бид дөнгөж шургаж байгаа ухаантай юм. Бусдад нь бол хажиглагдаад, эсвэл өөрсдөө томроод л сууж байна. Уудам Азийн цээжинд ялалтын од болон гялалзсан гэдэг Монгол Улс маань хэвээрээ шахуу л байгаа шүү. Гадаад бодлогын үзэл баримтлал Монгол түүмэнд тустай зөндөө юм хэрэгжүүлсэн л дээ. Цаашдаа улам л ашиг тустай баймаар л байгаа.

Их стратегич Баабар гуай сая “ШХАБ руу битгий зүглэж үзээрэй” гэж хэлээд гарлаа л даа. Тэр нь нээрээ ч тийм аймшигтай юм уу гэхээр Монгол дунд нь зоосны нүх шиг ганцаараа хоцорчихоод байгаа юм. Энэ маань түжигнэж, тачигнасан ч гэсэн зоосны нүхийг нь тойроод л байх юм уу. ШХАБ цэргийн талаар л гээд байх юм, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны талаар хэдий нарийн юм хийгээд байгаа боловч хийгээгүй мэтээр яриад байгаа юм шиг сэтгэгдэл төрж байна. Энэ бас бодож үзүүштэй л зүйл байгаа юм.

Их судлаачийн хувьд мань хүн их л юм үзэж харсан байгаа байлгүй. Хэн нэгэн хүний таалалд нийцэх гээд ШХАБ-аас дөлөөд байгаа бол нэг намын бодлогоос цааш хэтрэхгүй. Энд бол Монгол Улсын л бодлого байх ёстой. Монгол Улсаа зүрхэндээ тээж явсан хүн бол арай өөр юм хэлж байх ёстой гэж бодогдож байна. ШХАБ-д орох нь зөв үү, буруу юу, дараа нь гуйгаад очиход оруулах юм уу, үгүй юм уу. Ер нь АПЕК гэх мэт бүхний л гадаа үлдсэн. Биднийг тоож байгаа амьтан алга. Аяндаа үүцээ задлахаар өөрсдөө орж ирээд л тачигнаж, түчигнэж байх шиг байна.

Бэрхшээл гэвэл олон юм ярьж байна лээ. Би Д.Дэмбэрэл даргын ажлын хэсгийн хэд хэдэн хуралд сууж үзсэн. Дорнод аймгийн дарга нь хил хүртэл зам тавьчихсан байна лээ. ГХЯ нь юуг нь ч мэдээгүй, тусгайлан өгөх саналгүй гэж хэлдэг гэж түрүүнд хэллээ. Бидний үед аймгийн дарга нарыг жилд нэг хоёр удаа авчраад уулздаг байсан. Үзэл баримтлал дээр ГХЯ-ыг төрийн төв, гадаад харилцааг хариуцах байгууллага гэсэн байж энийгээ хийхгүй юугаа хийж байдаг ГХЯ бэ гэж бодогдож байна. Стратегийн ач холбогдолтой зам тавьчихаад харьцах гээд сууж байгаа явдал бол арай хэтэрч байгаа санагдах юм.

Гадаад харилцааны сайд нь “би бусад яамдын сайдтай адилхан сайд болохоор бусдыгаа яаж ч чадахгүй юм” гэж “гоншигонох” маягтай. Эвгүй үг хэрэглэж байгаа бол уучлаарай. Тэгж суугаад үнэхээр болохгүй бол бичигдсэн хуулиа бариад том эрх мэдэлтэй засаг даргыг авчраад хариуцлага тооцож болох л юм шиг санагдах юм.

Шадар сайдыг энэ хурал дээр сууж байхад хэлье гэж бодсон юм. Ажил ихтэй болохоороо бас л гараад явчихлаа. Шадар сайд гэж нэг хүн ямар хэрэгтэй болоод байна? Ус үер, гал түймэр, газар хөдлөлт болохоор аргагүй их хэрэгтэй юм билээ. Пүрэвдорж гуайг байх үеийг мэднэ. Наадмын комисс чухал уу? Наадам одоо жигтэйхэн чухал шүү дээ. Шадар сайд гэсэн алдар гуншин өөр хаана байдгийг мэдэхгүй юм. Яг нарийн орчуулбал Ерөнхий сайдын орлогч л гэж энд тэндгүй байдгийг мэднэ. Тэгэхээр ГХ-ны сайд Ерөнхий сайдын орлогч хийдэг, ЭЗХ-ийн сайд Ерөнхий сайдын орлогч байдаг бол юм зохицоход арай сайн байгаа юм. Ийм хоёр сайдыг ерөнхий сайдын орлогч болгоод одоогийн тэр том сайдын албыг авч хаявал арай жаахан прагматик санагдаж байна.

Иймэрхүү хэдэн зүйлийг хэлье. Сонирхолтой сайхан зүйл ярих дараагийнхаа нөхдөд боломж олгох үүднээс яриагаа дуусгая.

Проф.Др.Д.Баярхүү /Элчин сайд асан,ОББЭЭ/

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал /1994.06.30-ны УИХ-ын 56 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/ 1994 онд УИХ-ын тогтоолоор батлагдсан гадаад харилцааны бодлогын баримт бичиг. Уг баримт бичгийг шинээр гаргах

болсон шалтгаан нь дэлхийн социалист систем, ЗСБНХУ задарч, түүний холбоотон асан Монголын гадаад нөхцөл байдал эрс өөрчлөгдсөнтэй холбоотой бөгөөд Монгол Улсад өрнөсөн улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл нь улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах аятай боломж бүрдэж, энэ тухай төрийн гадаад бодлогыг томъёолох үүднээс УИХ-аар хуульчилсан баримт бичиг баталжээ. Гадаад бодлогын үзэл баримтлал нь 1) Нийтлэг үндэслэл, 2) Монгол Улсын гадаад улс төрийн бодлого, 3) Эдийн засгийн гадаад харилцааны бодлого, 4) Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлого, 5) Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого гэсэн 5 хэсгээс бүрдсэн байв.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал /2011.02.10-ны УИХ-ын 10 дугаар тогтоол/ Гадаад бодлогын шинэчлэн найруулсан үзэл баримтлал. УИХ 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэн батлагдсан. Тус үзэл баримтлалыг 1994 онд Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг баталснаас хойшхи хугацаанд манай улсын гадаад орчин, дотоод байдалд гарсан өөрчлөлтүүдийг харгалзан үзэж шинэчлэн найруулжээ. Шинэчлэн найруулсан үзэл баримтлал нь 1994 онд баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалын үндсийг ерөнхийд нь хадгалж, сүүлийн 16 жилд дэлхийн улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, байгаль орчны зэрэг салбарт гарсан өөрчлөлт хувьсал, дэвшлийн асуудлуудыг тусгасан бөгөөд Монгол Улсын хөгжлийн өнөөгийн шатан дахь гадаад бодлогын чиглэл, хандлагыг тодотгожээ.

Түүнчлэн Монгол Улсын гадаад орчны өөрчлөлт, үндэсний аюулгүй байдлын шинэ асуудлууд, гуравдагч хөршийн бодлогыг тусгаснаас гадна Монгол Улс дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдэхэд оролцох, гадаадад буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлууд, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг тусгаснаараа онцлог юм. Уг үзэл баримтлал нь 1) Нийтлэг үндэслэл, 2) Улс төрийн гадаад харилцааны бодлого, 3) Эдийн засгийн гадаад харилцааны бодлого, 4) Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлого, 5) Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого, 6) Гадаадад байгаа

иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бодлого, 7) Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн 7 хэсэгтэй.

Шинэ үзэл баримтлалын 14.1.-д ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах;

14.2.АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх; (энэ зүйл дээр маргаан дэгдсэн, дэгдсээр байх болно)

14.3.Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох;

14.4.Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах;

14.5.хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах гэхчлэн оруулжээ.

Анхны үзэл баримтлалын 2 дугаар бүлгийн 12 дугаар хэсэгт гадаад бодлогын чиглэлүүдийг заахдаа 6 чиглэлээр улс орнуудыг жагсааснаас үүдэн тэр жагсаалтдаа өөрсдөө ороогдон, хардлага үүсгэж, гадаад зарим улсыг эмзэглүүлж байсан явдал бий.

Эндээс үндэслэн хэрэв үзэл баримтлалд дахин тодотгол хийх, эсвэл эл үзэл баримтлалыг хүчингүй болгоод шинээр гаргах аваас дараахи саналыг тусгаасай хэмээн хүсч байна. Үүнд:

-Байр сууриа илэрхийлэхэд заавал дээрхийн адил хатуу заалт оруулж, улс орнуудыг жагсааж нэрлэх, эсвэл тодорхой үүрэг амлалт авах хэрэг юу байна вэ?

-Ерөөсөө гадаад бодлогын үзэл баримтлал гэдэг бол тулгуур баримт бичиг. Эрх зүйн акт биш, гадаад бодлого явуулах хууль бас биш.

-Гадаад бодлогын тулгуур баримт бичиг болохын хувьд үзэл баримтлалыг нэмж хасч, засч, өөрчлөөд явдаг юм биш.

-Хөдлөшгүй байх ёстой. Хөдлөшгүй байхын тулд тодорхой бодлого, чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр бичиж тусгаж болохгүй юм.

-Туйлын ерөнхий заалт суулгаж байж тэр маань үзэл баримтлал болно.

-Тэр утгаар хэрэгжилт нэхэгдэж таарахгүй.

-Хэрэв улс орнуудыг дээрхийн адил жагсаалтын дагуу нэр заах гэж хатуу шийдэж байгаа бол нэрлэхгүйгээр ерөнхий байдлаар “Мөнхийн хөрш”, “Гурав дахь хөрш” хэмээн томъёолж болох юм.

Зарим жижиг улсууд Үндсэн хуулиндаа үзэл баримтлалаа суулгаж өгсөн байдаг. Үндсэн хуулиараа үзэл баримтлалаа тунхагласан явдал бий, жишээ нь Югослав эвсэлд үл нэгдэх гадаад бодлогоо 1974 оныхоо Үндсэн хуулинд тунхагласан.

АНУ-д үзэл баримтлал гэж тусгай баримт бичиг байхгүй хэрнээ ардчилал, үндэсний эрх ашиг хоёроо үзэл баримтлал болгочихсон. Цагаан ордны баримт бичгүүдэд тодотгогдож явдаг.

Манай төвийг сахих бодлого – төвийг сахина гэдэг нь чухам юу вэ, Монголын хувьд гэдгийг оновчтой томъёолох хэрэгтэй. Үнэмлэхүй загвар байна уу? 1955 оны Австрийн жишээ хамгийн зөв хувилбар байж болно.

Монгол нь НАТО-гийн PAG гишүүн улс. “Хааны эрэлд” – олон улсын цэргийн байнгын нэг механизм бий боллоо. Энэ бүхэн маань манай нөгөө төвийг сахих бодлогыг алдагдуулахгүй, Монгол Улс төвийг сахина гэдэг дээрээ зогсож байгаа гэдгийг тайлбарлах тийм гарц нь үзэл баримтлал дотор сууж өгсөн байх ёстой.

Арми цэрэг, цэргийн байгуулалт маань улам бүр иргэнлэг шинж чанартай болж байна. Арми цэргийг цэргийн машин гэж үзэхээ больж байна. Үүнийг үзэл баримтлалдаа төвийг сахих бодлоготойгоо холбож оруулж ирэх боломж бий юү? Энэ бүхнийг бодолцох хэрэгтэй мэт.

Үзэл баримтлалтай холбогдуулан тодотгол хийдэг зөв механизмаа бид олж чадсан гэдгийг энд тэмдэглэхийг хүсч байна. Өмнө үг хэлсэн нөхөд энэ талаар тухайлан анзаарсангүй. Юу гэхлээр бид 1994 онд үзэл баримтлалаа батлаад 1996 онд анхныхаа тодотголыг хийсэн. 1996, 2000, 2004, 2008, 2012 оны УИХ-ын сонгуулиудын дүнд байгуулагдсан шинэ Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрийн гадаад бодлогын хэсгийн заалтуудаар тухай бүрт нь тодотгол хийгээд ирсэнийг бид нэг том ололт байжээ гэж үзэх хэрэгтэй.

Үзэл баримтлалын заалтууд дээр ороогдохгүй байх, эсвэл элдэв шүүмжлэл сонсохоос зайлсхийх, ерөөсөө “ам таглах” нэг боломжит суваг бол “Гадаад бодлогын хөх ном” гэж үзэж болно. Ер нь жил болгон ийм номоо гаргаад хэвшчихвэл заавал үзэл баримтлалтай байх гэх албагүй. Үзэл баримтлал гэж нэрлэхээр хэвлэмэл бичиг баримт тэр бүр гадаад улс орнуудад байдаггүй. Хэрэв интернэтээс хайгаад үзвэл “Гадаад бодлогын үзэл баримтлал” гэж гарчигласан баримт бичиг тун цөөхөн хэдхэн улс дээр л байдаг. Нэлээд нь хөх номоороо үзэл баримтлалаа нотлоод явдаг юм шиг байгаа юм.

Өмнө үг хэлсэн нөхдийн ярианд үзэл баримтлалын хэрэгжилт гэж олонтаа гарлаа. Хэрэгжилтийг олон нийт шаардаж байна гэж ярилаа. Хэрэв хэрэгжилт шаардах аваас манай ГХЯ, дипломат алба Гадаад бодлогын үзэл баримтлалын заалтуудыг өнгөрсөн 20 жилд ягштал, бүр давуулан хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Манай дипломатчид өөрсдөөсөө шалтгаалах бүхнийг бүр давуулан биелүүлсэн шүү. Ганцхан жишээ хэлье. Европын Холбоотой монголын барааг татварын

хөнгөлөлттэй нэвтрүүлэх чиглэлээр ГХЯ, Брюссель дэх ЭСЯ хангалттай ажилласан. Үр дүн нь тааруухан байгаа бол манай эдийн засаг, бизнесийн нөхөдтэй л ярих ёстой. Эдийн засаг хөгжүүлэх гадаад таатай нөхцлийг ГХЯ бүрдүүлж өглөө, чадлаа, тэгээд эдийн засгаа хөгжүүлэх эрх нь нээлттэй байна. Эдийн засгийг эрхэлдэг нөхөд л үүнд хариу өгөх учиртай.

Өмнөх нөхдийн ярьсан ШХАБ ба Монгол Улс сэдвээр өөрийн байр сууриа илэрхийлье. Баабарын илтгэлд дурдсан үнэлэлт дүгнэлттэй санал нэг байна. ШХАБ өөрөө түүхий байна. Манай оршин буй Ази тив, мөн Номхон далайн бүс нутагт бүс нутгийн, бүс нутаг хоорондын, олон улсын, салбар бүс нутгийн олон талт үйл явц, институци, дэглэм, байгууллага, форумын тоо 320-иос давж гарсан баримт бий. Өөрөөр хэлбэл Ази-Номхон далайн бүс нутагт олон улсын байгууллага гэдэг нь сонгодог утгаа алдаж, бараг “нохойн наадам” болох дөхсөн байна. Тийм 320-ын нэг нь энэ ШХАБ шүү дээ.

Саяхны түүх юм даа. Хилийн бүсэд итгэлцлийг бэхжүүлэх тухай хэлэлцээрт 1996 онд ОХУ, БНХАУ, Казахстан, Киргиз, Тажикстан гэсэн 5 улс Шанхай хотноо гарын үсэг зурснаар “Шанхайн тав” хэмээх үйл явц эхэлсэн. Эхэн үедээ “Шанхайн тав”-ын үйл ажиллагаа цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудалд төвлөрч байсан. Эдгээр орон хамтын ажиллагаагаа илүү институцичлэх шийдвэр гаргасанд Узбекистан нэгдэж, 2001 оны 6 дугаар сард 6 орны төрийн тэргүүн нарын Шанхай хотноо хийсэн уулзалтаар Шанхайн хамтын ажиллагааны байгууллага буюу ШХАБ-ыг байгуулсанаа албан ёсоор зарласан. Эдгээр 6 улс 2002 онд ШХАБ-ын Хартид гарын үсэг зурсан.

Гишүүн орнуудын итгэлцэл, найрамдал, сайн хөршийн харилцааг бэхжүүлэх, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, терроризм, салан тусгаарлах үзэл болон хэт даврах үзлийн бүх хэлбэр, хар тамхины хууль бус наймаатай хамтран тэмцэх нь ШХАБ-ын үндсэн зорилго юм. Өөрөөр хэлбэл цэрэг-улс төрийн харилцаа давамгайлна гэсэн үг. Монгол Улс 2004 онд, Иран, Пакистан, Энэтхэг Улс 2005 онд, 2012 онд Афганистан ШХАБ-ын ажиглагчийн статустай болсон.

Беларусс, Шри Ланка 2009 онд тус байгууллагын яриа хэлцээний түншийн статустай болсон. Улмаар Турк 2011 оноос ийм статустай гэж тооцогдож байгаа.

Тэгэхлээр жинхэнэ гишүүн 6, ажиглагч 5, яриа хэлцээний түнш 3, цаашаа уригдсан Туркменистан, ТУХН, АСЕАН, НҮБ, ЕврАзЭС, АНУ гээд мөн 6 субъект байна. Нийлүүлээд тооцвол 20 субъект жагсаж байгаа ба тэдэн дунд Монгол гоцлоод байх цаг нь болоогүй хэмээн үзэж байна.

Монгол Улс Төв Азийн бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн хамтын үйл явцад идэвхтэй оролцох гадаад бодлогын зорилтын хүрээнд ШХАБ-ыг тус бүс нутгийн олон талт хатмын ажиллагаанд оролцох нэг чухал суваг гэж үзэн 2004 онд ШХАБ-д ажиглагчийн статустай болсон хэрэг.

Монгол Улс ШХАБ-ын хүрээнд эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа, тухайлбал, эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү оролцох бодлого баримталдаг боловч тэр хамтын ажиллагаа нь эхлээгүй байна.

Ажиглагчийн статустай болсноосоо хойш Монгол Улс ШХАБ-ын гишүүн орнуудын төр засгийн тэргүүн нарын уулзалтад тогтмол оролцож, салбарын сайд нарын уулзалт болон бусад арга хэмжээнд зохистой түвшинд орлохыг эрмэлзэж ирсэн. Ер нь ажиглагчийн байр сууриа хадгалж, ажиглагч гишүүний давуу эрхээ эдлэх нь зөв болов уу. Ажиглагч гэдэг нь огтын гишүүн бус улсаас юугаараа илүү юм бэ гэдэг асуудлыг ч бид удаа даваа шууд бус хэлбэрээр тавьсаар ирсэн. Гэтэл манай улсыг жинхэнэ гишүүнээр элсүүлэх шахалт ирсээр байна. Жинхэлж болохгүй учир шалтгааныг Баабар хэллээ. Би ч бас олон талаас нь харж дүгнэж байна. Жинхэллээ гэж бодъё. Ямар их үүрэг хариуцлага, шахалт дарамт ирнэ гэж тооцох вэ?

Лав манай батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаа эрс саарна. АНУ, НАТО-той тогтоосон цэргийн харилцаа хумигдана. Энхийг сахиулахад цэргээ илгээхэд ч хүндрэлтэй болно. “Хааны эрэлд”– олон улсын цэргийн байнгын энэ механизм маань хумигдсаар хумигдсаар алга болно. Сүүлдээ

Монголд америкийн ганц ч цэрэг ирж чадахаа болино. Ийм л дүр зураг харагдаж байна.

Проф. Ц.Дашзэвэг /БХЭШХ-ийн судлаач, БХИС-ийн профессор, дэслэгч генерал /

Миний бие өнөөдрийн илтгэлдээ Цэргийн номлол, түүнтэй адилтгах баримт бичгийн тухай товч мэдээлэл, Монгол Улсын цэргийн анхны номлол, "Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичгийн үзэл санаа, Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо зэрэг асуудлыг хөндөх болно.

Дэлхийн улс орнууд цэргийн аюулгүй байдлаа хангахдаа: цэргийн илэрхий давуу хүч, чадавхитай болж цэргийн аюулгүй байдлаа хангах, батлан хамгаалах зорилтоо хангахуйц үндэсний зэвсэгт хүчнээрээ улс орноо батлан хамгаалах, олон улсын цэрэг-улс төрийн холбоонд нэгдэж, аюулгүй байдлаа хамтын хүчээр хангах, цэрэг-стратегийн хувьд тэргүүлэхүйц пуужин, цөмийн зэвсгийн хүч хэрэгсэлтэй болж улсынхаа цэргийн аюулгүй байдлыг хангах, цэргийн тэргүүлэх гүрний ивээлд багтаж эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, зэвсэгт хүчингүй улсын статус авч дайнаас зайлсхийх, найр тавих замаар улсынхаа бүрэн эрхт байдлыг хангах, төвийг сахих аргаар цэргийн аюулаас хамгаалах гэсэн бодлого баримталдаг. Тэгвэл **Монгол Улс цэргийн аюулгүй байдлаа ямар аргаар хангах вэ?** гэсэн асуулт урган гарч байна.

Цэргийн номлол, түүнтэй адилтгах баримт бичгийн тухай ерөнхий ойлголт

Цэргийн номлолоор болзошгүй дайны мөн чанар, зорилго, шинж байдал хийгээд улс орныг дайнд бэлтгэх, эсхүл түрэмгийллийг няцаахтай холбогдол бүхий цэрэг-улс төр, эдийн засаг, эрх зүй, цэргийн бодлогын чиглэлийг тогтооно гэсэн байдаг. Харин **Үндэсний цэргийн стратеги** нь улс орны цэрэг-улс төрийн дээд удирдлагаас боловсруулан дэвшүүлсэн зорилго, үүргийг хэрэгжүүлэх арга замыг заасан Штабуудын нэгдсэн хорооны даргаас тодорхойлон бэлтгэн гаргадаг үзэл баримтлалын баримт бичиг болно. Тэгвэл **Цэргийн үзэл баримтлал** гэдэг бол цэрэгт ойрын ирээдүйд тулгарч болох цэрэг-улс төрийн асуудал (цэрэг-улс төрийн томоохон үүрэг)-ын шинж чанар, шийдвэрлэх боломжит арга замыг тодорхой цаг хугацааны хүрээнд онол, практикийн үүднээс томъёлон тогтоож буй удирдамжийн

нэгдмэл цогц болно гэсэн үзэл баримтлалыг агуулсан баримт бичиг юм. Дэлхийн улс гүрнүүд **Цэргийн номлол**, түүнтэй адилтгах өөр өөрийн баримт бичгийг мөрдлөг болгодог. Жишээ нь:

- ОХУ, Беларусь, Казахстан, Узбекистан гэх мэт улсууд "Цэргийн номлол", АНУ гэх мэт улсууд "Үндэсний цэргийн стратеги", НАТО "Стратегийн үзэл баримтлал", БНХАУ "Батлан хамгаалах номлол" гэсэн баримт бичигтэй байна.

Ул орнууд өөр өөрөөр нэрлэдэг боловч Цэргийн номлолын баримт бичигт цэргийн хүчний зориулалт, чиг үүрэг, үүргээ биелүүлэх бэлтгэлийг хангах арга зам, цэргийн байгуулалтын зорилтын чиглэл, цэргийн хүч хэрэгслийг улс төрийн зорилгоор ашиглах арга хэлбэрийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй хүлээн авсан, харьцангуй урт хугацаанд удирдлага болгож мөрдөх албан ёсны удирдамжийн цогц тогтолцоо бөгөөд цэргийн байгуулалтыг хөгжүүлэх чиглэл, улс орныг болоод зэвсэгт хүчнийг дайнд бэлтгэх, дайныг явуулах арга, хэлбэрийг тогтоож буй албан ёсны ойлголт, удирдамжийн чиглэлийн тогтолцоо болж харьцангуй урт хугацаанд төрөөс баримтлах цэргийн бодлогын зарчим, гол зорилт, үндсэн чиглэлээ тусгадаг.

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын шинэчлэл

Монгол Улсын хувьд 1994 оны 6 дугаар сарын 30-нд УИХ-аас Монгол улсын үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлал, Цэргийн номлолыг батлан гаргаснаар төрийн цэргийн бодлого шинэчлэгдэж энэхүү шинэчлэл нь олон улсын харилцаа, зах зээлийн эдийн засгийн харилцаа, төрийн ардчилсан тогтолцоонд гарсан өөрчлөлтийг тусгасан нийгмийн захиалга байсан гэж хэлж болно. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлах хамгаалах тогтолцооны баримт бичгийг Монгол улсын үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлогын үндэс(Цэргийн номлол), Батлан хамгаалах тогтолцооны хууль тогтоомж, Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийн баримт бичиг гэсэн байдлаар жагсааж болох юм.

Монгол Улсын Цэргийн номлол(1994 оны)-ын бүтэц, үндсэн агуулга

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, түүнд сөргөөр нөлөөлж болох гадаад, дотоод хүчин зүйл, учирч болзошгүй аюул

заналхийллээс сэргийлэх, үндэсний язгуур ашиг сонирхол, тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, нутаг дэвсгэр, улсын хилийн халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах нь Монгол Улсын Цэргийн номлолын үндсэн агуулга болж байдаг. Цэргийн номлол нь аливаа дайн, түрэмгийллийн талаарх төрийн үзэл баримтлалыг тодорхойлох, дайны аюулыг сэргэмжлэн зайлуулах, улс орноо түрэмгийллээс хамгаалах нөхцлийг бүрдүүлэх, хамгаалах, зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалт, зэвсэгт тэмцэл явуулах талаар төрөөс баримтлах албан ёсны үзэл баримтлал болно. Улс орныхоо аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар урьтал болгон хангахыг эрмэлзэх болсноо тунхаглан зарласанд Монгол Улсын Цэргийн анхны номлолын ач холбогдол оршиж байгаа төдийгүй цэргийн аюулгүй байдлыг хангах гадаад, дотоод бодлогод баримтлах үндсэн чиглэл, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болсон юм.

Монгол Улсын Цэргийн номлолыг "Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс" болгон шинэчлэн өөрчилсөн нь:

УИХ-ын 1998 оны 56 дугаар тогтоолоор Цэргийн номлолыг Монгол Улсын "Төрийн цэргийн бодлогын үндэс" болгон өөрчлөн баталсан байдаг. "Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичигт улс орныг батлан хамгаалах, зэвсэгт хүчнийг шинэчлэх бодлого, аливаа зэвсэгт түрэмгийлэлд төрөөс хандах хандлага, дайн, зэвсэгт мөргөлдөөний аюулаас хамгаалах төрийн бодлогын үндсэн чиглэл, цэргийн байгуулалт, зэвсэгт тэмцэл явуулах арга хэлбэрийн талаар төрөөс баримтлах үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлаа хангах таатай нөхцлийг бүрдүүлэх энх тайванч гадаад бодлогоо илэрхийлж, "Цэргийн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх нь маргаантай асуудлыг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй", Монгол Улс өөрийгөө хамгаалах зарчимд нийцүүлэн "Өөр улсын эсрэг ямарч тохиолдолд цэргийн хүч түрүүлж хэрэглэн цэргийн аюул заналхийлэл бусдад учруулахгүй, бусдын зэвсэгт түрэмгийлэлд өөрөө ертсенөөс бусад тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй" гэдгээ зарласнаараа ач холбогдолтой юм.

Тэгвэл Монгол Улсын ерөнхийлөгчийн 2002 оны зарлигаар баталсан **"Зэвсэгт хүчнийг ашиглах номлол"** нь Монгол Улсын төрийн цэргийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд зэвсэгт хүчний байгуулалтыг төгөлдөржүүлэх урт

хугацааны зорилтыг тодорхойлж зэвсэгт хүчнийг ашиглах стратегийн төлөвлөгөө, цэргийн байлдааны ба хээрийн албаны дүрэм, зааврыг боловсруулан мөрдөх Зэвсэгт хүчнийг бэлтгэх ашиглахтай холбогдсон цэргийн мэргэжлийн удирдлагын байгуулалтуудын гаргах шийдвэр, эрх зүйн баримт бичгийн тулгуур үндэс болсон баримт бичиг юм. Зэвсэгт хүчнийг ашиглах талаар баримтлах гол үзэл баримтлал “Зэвсэгт хүчнийг ашиглах номлол”-оор тодорхойлогдоно.

"Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичгийн агуулга

"Төрийн цэргийн бодлогын үндэс" нь МУ-ын цэргийн бодлогын үндсэн зарчим болж 1. цэргийн аюулаас хамгаалах чиглэлд: аливаа зэвсэгт түрэмгийлэлд төрөөс хандах хандлагыг тодорхойлж 2. улсыг батлан хамгаалахад хүн ам, эдийн засаг, нутаг дэвсгэрээ бэлтгэх чиглэлд төрийн бодлогын үндсэн чиглэл болдог бол 3. зэвсэгт хүчнийг бэлтгэх чиглэлд: зэвсэгт хүчний чиг үүргийг тодорхойлж зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх, зэвсэгт түрэмгийллийг саатуулан няцаахад зэвсэгт хүчнийг бэлтгэх бодлогыг мөн адил тусгасан байдаг.

Хоёр хөршөө чухалчлан ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харьцаж, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн. Хүч чадлын хувьд эн тэнцэхгүй хоёр хөршийн дунд Монгол Улс аюулгүй байдлаа улс төр-дипломат"-ын аргаар хангах зарчим баримтлахаас өөр арга байхгүй болно. Улс орныхоо аюулгүй байдал, хөгжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг сааруулах, даван туулах "Гуравдагч хөрш"-ийн бодлого Монгол улсын геостратегийн байршилтаас урган гарч байна.

Тэгвэл Монгол Улсын улс орноо батлан хамгаалах **цэрэг - улс төрийн бодлогын** үндэс нь төр, улсын тогтнохуйн аюулгүй байдлаа хангах чиглэлд өөрийгөө батлан хамгаалах зорилтоо бүх нийтийн батлан хамгаалах тогтолцоонд тулгуурлан хэрэгжүүлэх, цэргийн салбарт итгэлцэлийг бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах механизм бий болгох хүчин чармайлт, хамтын ажиллагаанд оролцох, дэлхийн улс орнуудтай, нэн ялангуяа хөрш гүрнүүдтэй бүх талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, цэргийн итгэлцэлийг бий болгох, үндэснийхээ язгуур ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх аливаа үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийх буюу татагдан оролцохоос сэргэмжлэх замаар гадны цэргийн заналхийлэл үүсэх шалтаг, шалтгаан гаргуулахгүй байх, НҮБ-ын

дүрмийн 51 дүгээр зүйлийн дагуу улс орноо түрэмгийллээс дангаараа буюу хамтын хүчээр хамгаалах эрх зүйн үндэсийг хоёр болон олон талын шугамаар бүрдүүлэн баталгаажуулах зэрэгт чиглэгдэнэ.

Улс орноо батлан хамгаалах **нийгэм, эдийн засгийн бодлогын** үндэс нь: Монгол Улс гадны зэвсэгт түрэмгийлэлд өртвөл түүнийг саатуулан няцаах өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцлийг бүх хүч хэрэгсэл боломжийг нэгтгэн дайчилж ард иргэдийн дэмжлэг оролцоонд тулгуурлан явуулахад орших бөгөөд **улсын дайчилгаа, орон нутгийн хамгаалалт** хэлбэрээр хэрэгжинэ. **Улсын дайчилгаа** нь улс орны эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор нөхөн хангах зорилгоор авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээ байдаг бол **орон нутгийн хамгаалалт** нь батлан хамгаалах тогтолцооны үндэс, өөрийгөө хамгаалах стратегид үндэслэн төрийн бүх шатны байгууллагын хамтын ажиллагаа, нийт иргэдийн оролцоо, нутгийн нийгэм, эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурладаг.

Орон нутгийн хамгаалалтад үндэслэн батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог нөхцөлдүүлж буй хүчин зүйлс нь нэгд, манай улсын геостратегийн байршлаар тодорхойлогдож; хоёрт, улсын эдийн засгийн чадавхи, боломжоор нөхцөлдөж; гуравт, эх орноо батлан хамгаалах бодлогын урьдчилан сэргийлэх стратегээр дэвшигдэж; дөрөвт, эвсэлд үл нэгдэх гадаад бодлогын зарчмаас урган гарч байгаа тул төрийн энэ бодлогыг хэрэгжүүлэх арга механизмыг оновчтой хуульчлан тогтоож, хэрэгжилтийг зохистой зохион байгуулах асуудал тулгамдсан хэвээр байна.

Тэгэхлээр **Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны** “тулгын гурван чулуу” нь 1-рт: Орон нутгийн хамгаалалт, 2-рт: Дайчилгааны тогтолцоо, 3-рт: Зэвсэгт хүчин болж байна. Монгол Улсын өөрийгөө хамгаалах зарчим нь орон нутгийн хамгаалалтад үндэслэсэн батлан хамгаалах тогтолцоонд тулгуурладаг. Харин дайчилгааны тогтолцоо нь зах зээлийн харилцаа, цэргийн гүйцэтгэх үүргийн онцлогт зохицсон нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий байна. Монгол Улс тайван цагт батлан хамгаалах хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн боломжинд нийцсэн цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг хандлагатай зэвсэгт хүчинтэй байна гэсэн байдаг.

Монгол Улсын зэвсэгт хүчний стратегийн үүрэг

Монгол Улсын зэвсэгт хүчний стратегийн үүрэг нь гадны зэвсэгт түрэмгийллийг саатуулан няцаахад орших бөгөөд, зорилго нь Монгол Улсын улс төрийн удирдлагад улс төр-дипломатын идэвхитэй үйл ажиллагаа явуулах боломж олгох юм. Үүний үр дүнд улс төр-дипломатын аргаар НҮБ, болон нөлөө бүхий улс орнуудаас түрэмгийлэгч талд дарамт шахалт үзүүлж, түрэмгийллээсээ татгалзахад хүргэнэ.

"Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичигт Зэвсэгт хүчний тайван цагийн үүргийг 1-рт: эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт түрэмгийллээс хамгаалахад бэлэн байх, 2-рт: улсын хил хамгаалах, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, 3-рт: улсын онц чухал объектыг хамгаалах, 4-рт: хөнөөх хэрэгслийн хөнөөл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюулаас хүн ам эд баялагийг хамгаалахад туслах, 5-рт: дайчилгааны нөөцийг бүрдүүлж, хүн амыг цэргийн хэрэгт сургах, 6-рт: хүмүүлэнгийн үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх, 7-рт: НҮБ-ын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх, 8-рт: бусад үүрэг гэж заажээ.

Төрийн цэргийн бодлогыг шинэчлэх хүчин зүйлс

Дэлхийн олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын шинэ нөхцөл, үүний дотор терроризм, үндэстэн дамнасан болон зэвсэг хэрэглэсэн гэмт хэрэг, шашны хэт үзэлтнүүдтэй холбоотой бусад аюул улам бүр өсч байгаа мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1910 онд, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал 1911онд тус тус шинэчлэгдсэн, Монгол Улсад нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих үйл явц амжилттай хэрэгжсэн мөн зах зээлийн харилцаанд суурилсан эдийн засаг, парламентын засаглал бүхий иргэний ардчилсан нийгмийг байгуулах үйлсэд гарч буй ахиц дэвшил зэрэг нь батлан хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтыг тодорхойлон төрийн бодлогын үндсийг шинэчлэн тунхаглах хүчин зүйлс болж байна.

Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлогын үндэс нь Улс орныг батлан хамгаалах тогтолцоо, батлан хамгаалах бодлогын чиглэл, зэвсэгт хүчний байгуулалтын тодорхойлсон төрийн бодлогын баримт бичиг, Батлан хамгаалах асуудлаар Монгол Улсын хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс тус тус болно.

Ч.Баатар /ГЯЯ-ны дэд сайд асан,ОББЭЭС/

Монгол Улсын гадаад бодлого хэдийнээс үндсээрээ өөрчлөгдсөн юм бэ?, анхны үзэл баримтлал хэзээ гарсан бэ? гэдгийг юуны өмнө эхэлж тодруулъя.

МАХН-ын Төв Хороо 1988 оны эцсээр болох бүгд хурлаараа Гадаад бодлого, харилцааны асуудлыг хэлэлцэхээр төлөвлөгдсөн байсан юм. Үүнтэй уялдан НТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн эрхлэгч Л.Ринчин “Үнэн” сонинд гадаад бодлогын асуудлаар том нийтлэл гаргахаар мөн төлөвлөгөөнд орсон байсан. Уг нийтлэлийн эхийг боловсруулж гаргах үүргийг надад өгсөн юм.Ингээд “Өөрчлөлт шинэчлэлийг гадаад харилцааны салбарт” гэсэн гарчигтай, Ло Эрдэнэ /Ринчин гэдэг түвд нэрийн монгол орчуулга/ нэртэй том нийтлэл “Үнэн” сонины 1988 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 301 дугаарт гарсан. Ринчин эрхлэгч маань нэрээ нууцлан хэвлүүлснийг бодоход нийтлэлд хөндөгдсөн асуудлуудаас нэлээд бэргэн болгоомжилж байсан бололтой. Уг нийтлэлд анх удаа тэр үеийн гадаад бодлогыг нэлээд дорвитой шүүмжилж гадаад бодлогын салбарт хийх шинэчлэл өөрчлөлтийг цогц байдлаар гарган тавьсан юм. Улс төрийн үйл явцын өрнөлөөс болоод НТХ-ны бүгд хурал гадаад бодлогын асуудлыг хэлэлцэж чадаагүй боловч нийтлэлд дурдагдсан чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах чигийг Ринчин гуай дээд удирдлагаасаа авсан байсан.

Ингээд дээрх нийтлэлд дэвшүүлж тавьсан асуудалд тулгуурлан Гадаад бодлогын үзэл баримтлал боловсруулах шийдвэрийг мөн Ринчин гуай гаргаж нэлээд хэдэн яамны мэргэжилтнүүд орсон ажлын хэсэг байгуулан түүнийг нь би ахалж ажилласан юм. Гадаад бодлогын анхны үзэл баримтлалын төслөөр хоёр удаа хэлэлцүүлэг зохиосон болно. Үзэл баримтлалын төслийг бэлэн болгосон тэр

үед би НТХ-ны ГХХ-ээс АИХТ-ийн Гадаад харилцааны хэлтэст шилжин тэнд нэг сар ажиллаж байтал Гомбосүрэн сайд намайг яамандаа буцааж татаж авсан. Энэ үед Бэхбат сайд ЗХУ-д Нийгмийн ухааны академийг төгсч ирээд Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх болохдоо уг Үзэл баримтлалыг АИХТ-ийн хуралдаанд оруулж, зарлиг гаргуулан мөрдүүлж эхэлсэн түүхтэй. Энэ нь Монгол Улсын Гадаад бодлогын анхны Үзэл баримтлал байсан юм. Үзэл баримтлалыг маш товч, ерөнхий байх ёстой гэж би үзэж байсан. Тиймээс уг үзэл баримтлал нэлээд цомхон болсон. Энд анх удаа Монгол Улс бие даасан, нээлттэй, энх тайван ч гадаад бодлого явуулах, Эвсэлд үл нэгдэх бодлого баримтлах, хоёр хөрштэйгөө аль алинтай нь тэнцвэртэй, сайн хөршийн харилцаа хөгжүүлэх зэрэг шинэ гадаад бодлогын тулгуур баримтлал, зарчмын шинэ чиг бодлогууд тусгагдсан юм.

Энэхүү үзэл баримтлал нь өнөөдөр ойг нь тэмдэглэж байгаа 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалын анхдагч суурь үндэс болж өгсөн юм. 1994 оны Үзэл баримтлалын гол онцлог нь нэгдүгээрт анхны үзэл баримтлалыг нэлээд дэлгэрэнгүй болгосон, хоёрдугаарт Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Цэргийн номлолтой хамт цогц баримт бичиг болж гарсан явдал юм. Дээрх бүх үзэл баримтлал нь Монгол Улс гадаад бодлого явуулах, аюулгүй байдлаа хангахдаа баримталж байх чиг баримжаа, гольдролыг тогтоож өгсөн баримтлал байсан. Энд ярьсан хүмүүсийн үгэнд гараагүй хамгийн том ололт амжилт нь Монгол Улс гадаад бодлого, үйл ажиллагаагаа бие даан, өөрийн толгойгоор мэдэж шийдэж явуулдаг болсон явдал юм.

Үзэл баримтлалын зарим маргаан дагуулж байгаа томъёоллын талаар тодруулга хийе. Хоёр хөрштэй “Тэнцвэртэй харилцах” тухай томъёолол эдүгээ анхны ойлголтоос нэлээд өөрөөр тайлбарлагдах болоод байна. Түүнийг анх томъёолж оруулахдаа Монгол Улс хөрш хоёр том гүрнийхээ нэгтэй нь найзалж эвсэн, нөгөөдөхтэй нь дайсанасан өрөөсгөл бодлого баримталж болохгүй. Хоёр хөрштэйгөө аль алинтай нь тэнцвэртэй, найрсаг сайн харилцаатай байх бодлого явуулах ёстой гэдэг ойлголт, утгаар орсон юм. Гэтэл одоо хувь, процентийн асуудал мэтээр яригдаж байгаа нь буруу юм.

Өөр нэг шүүмжлэл дагуулдаг зүйл нь Эвсэлд үл нэгдэх бодлого юм. Гомбосүрэн сайд энэ талаар зөв ярилаа. Монгол Улс ЭҮНХ гэдэг хэрэгтэй хэрэггүй нь үл мэдэгдэх байгууллагад гүйж очоод нэгдчихсэн мэтээр ойлгодог. Гэтэл ийм бодлого гаргасан нь өөр учир шалтгаантай. Монгол Улс ЗХУ-тай хоёр талын гэрээ хэлэлцээрээр цэрэг улс төрийн эвсэл холбоонд байсан холбоотон улсууд болно. Энэ нь үндсэндээ БНХАУ-ын эсрэг чиглэлсэн эвсэл холбоо болсон. Зөвлөлтийн цэргийг Монголоос гаргах нь нэгэнт тодорхой болж байсан түүхэн тэр нөхцөлд Монгол Улсын аюулгүй байдлыг ямар аргаар хангах вэ гэдэг асуудал хурцаар тавигдсан. Ингээд аюулгүй байдлаа “ Улс төр, дипломатын аргаар хангах” шийдвэрт хүрсэн. Үүний тулд нэг хөршийнхөө эсрэг чиглэсэн цэрэг улс төрийн эвслийн бодлогоос татгалзах шаардлагатай болсон. Үүнийг Монгол Улс “Эвсэлд үл нэгдэх бодлого явуулах”-аа тунхагласнаар хэрэгжсэн юм. Хятадын эсрэг ЗХУ-ын цэрэг армийн түшиц газар болж байна гэж хурц шүүмжлэлд өртдөг байдлыг үүгээр тасалсан төдийгүй, зөвлөлтийн цэрэг гарах ёстойг сануулсан бодлого байсан. Нөгөөтэйгүүр, Монгол Улс БНХАУ-тай үнэнхээсээ сайн хөршийн ёсоор харилцахаар шийдлээ гэдэг ойлголтыг Бээжинд бий болгосноор монгол, хятадын харилцааг сэргээн хөгжүүлэх үүд хаалгыг нээж өгсөн билээ. Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, өнөөдрийн хувьд өөр хаанаас ч биш, зөвхөн хоёр хөршөөс л Монголд аюул учрах магадлалтай. Тиймээс хоёулантай нь сайн харилцаатай байх нь аюулгүй байдлаа зэвсгээр биш, бодлогоор хангах чухал арга болно.

Энд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагатай холбогдсон асуудал мөн маргаан дагуулсаар байна. Би ГХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын захирал байхдаа ШХАБ-д зөвхөн ажиглагчаар л байх асуудлыг 2002 онд ГХЯ-ны хүрээнд шийдвэрлүүлсэн юм. Уг байгууллага нь олон түвшин, салбартай бөгөөд стратегийн түвшиндээ энэ бол цэрэг улс төрийн эвслийн шинжтэй, гол нь АНУ-ын эсрэг бодлого үйл ажиллагаагаа уялдуулах зорилготой гэдгийг оросын өндөр албан тушаалын хүмүүс нотолсон байдаг. Зөвхөн ажиглагч байх нь зөв шийдвэр гэдгийг том стратегич Баабарын амнаас сонсоход таатай байна.

Чойнхор сайд манай төр засгийн удирдлагад “хар хайрцаг”-ны бодлого байдаг эсэх асуудлыг хөндлөө. Би “Гуравдах хөрш”-ийн үзэл баримтлалыг бие

даан боловсруулаад төр, засгийн удирдлагуудад танилцуулсан бөгөөд сүүлд нь ГХЯ түүнийг төрийн дээд байгууллагад албан ёсоор өргөн барьсан юм. Энэ хүрээнд “Далд баримтлал” гэдэг нэг ёсондоо хар хайрцагны бодлого боловсруулж хүргүүлсэн. Удаа дараагийн удирдлагуудын сейфэнд байгаа гэж найдаж байна. Манай том дипломатууд мөн тийм зүйл бодоход хүргүүлдэг биз. Тэднийг нэгтгэн баяжуулж мөрдөж ажилладаг эсэхийг нь харин мэдэхгүй юм.

Одоо өнөөгийн байдалд ойртуулж ганц нэг санаа хэлье. Манай Гадаад бодлогын үзэл баримтлал гол нь өөрийн ашиг сонирхлын үүднээс харж хийгдэж ирсэн. Манай улсын аюулгүй байдал өөрөөс нь гэхээсээ, гадаад хүчин зүйлээс голлон хамаардаг. Эдийн засагтай адил олон улсын харилцаа 20-30 жилийн мөчлөгтэй байдаг гэдгийг америкийн том судлаач тогтоосон байдаг. Дэлхийд ноёлсон ганц том гүрэн геостратегийн аюултай бодлого явуулдгийг бид Чингис хааныхаа жишээнээс мэднэ. Тангад гэдэг улсын хаан нэг буруу өгүүлбэр хэлснээсээ болж улс үндсээ утсгуулж мөөхөлгөсөн жишээ бий.

Энд зарим хүмүүс цөөхөн орныг эс тооцвол бусад улсад үзэл баримтлал байдаггүй гэж яриад байна. Тэдэнд геостратегийн тогтсон том бодлого байдгийг би АНУ-ын жишээгээр хэлье. Урьд нь АНУ, ЗХУ эн тэнцүү өрсөлдсөн хоёр “хэт их” гүрэн байсан. ЗХУ-ыг мөхсний дараа АНУ дахин өөртэй нь энэ тэнцүү өрсөлдөгч дэлхийн хаана ч гаргаж ирэхгүй байх бодлогыг стратеги зорилтоо болгож ирсэн. Энэ бодлогынхоо хүрээнд ЗХУ-ыг задалж унагасантай адил ОХУ-ыг 2030-аад он гэхэд задалж сулруулах зорилт тавин ажиллаж байна. Украинд болж буй үйл явдал задлах үйл ажиллагааных нь эхлэл болж байна гэж үзнэ. Мөн БНХАУ-ыг өөрөө дотроосоо задрана гэсэн дүгнэлт хийчихээд түүнийг гүйцэлдүүлэхээр ажиллаж байна. Мөн дэлхийн гурван далайд тогтоосон ноёрхолоо хэвээр хадгалахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулсаар байна.

Чойнхор сайд сая дэлхийн геостратегийн байдал гэнэт өөрчлөгдөн хувьсаж болзошгүйг санууллаа. Биднээс хэн нь ЗХУ-ыг задарч унана гэдгийг урьдчилан мэдэж байсан билээ? Хэрэв хөрш орнуудад маань дээрх нөхцөл байдал үүсвэл манай улс яах ёстой вэ? гэдгээ эртнээс сайтар бодож төлөвлөж ажиллах шаардлага гарна гэж үзэж байна.

Др.Ж.Гөлгөө /Элчин сайд асан, ОББЭЭ /

Эдийн засгийн аюулгүй байдал хийгээд хамаарлын асуудлаар би Та бүхэнтэй санал бодлоо хуваалцъя.

Өмнөд хөрштэй эдийн засгийн чиглэлээр харилцах тухайд Монголчууд бид ацан шалаанд ороод удаж байна. Нэг талаас энэ зах зээлээс хэт хамааралт байдлыг багасгахыг бодлогын түвшинд мэрийсээр атал нөгөө талаас худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлхээ холбоо маань газар зүйн, зам тээврийн, үнэ өртгийн бодит нөхцлүүдээс үүдэн улам бүр тэлсээр байна. Эл эсрэг тэсрэгийг яаж авцалдуулах вэ, алтан дундаж нь хаана байх ёстой вэ гэдэг асуулт урт, дунд хугацааны бодлогын гол сэдэв болон хувирч байна.

Гадаад бодлогын үзэл баримтлал (19 дүгээр зүйл)-д Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ гэж заасан. Мөшгийг хөөвөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “...Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална (3.2.5.3). Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална (3.2.2.2)...” гэж заасан буй. Эдүгээ БНХАУ-д манай барааны экспортын 95%, импортын 27% нь ногдож байна. 2013 оны эхний 10 сарын байдлаар Монгол улсад ороод буй 14,1 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгийн 26,7% нь өмнөд хөршийнх ажээ. Дээр нь Гонконгийн 1,7%-ийг нэмбэл даруй 28,4% болж байна. Үнэт цаасны хэлбэрт хөрөнгийг энд бас нэмж бодолцох ёстой. Эдгээр тоо баримт нь дээрх үзэл баримтлуудад тогтоож өгсөн чиг баримжаа, шалгуур үзүүлэлтүүдийг давж гарах хэмжээнд хүрчихээд байгаа бөгөөд цаашид ч манай эдийн засагт БНХАУ-ын хүчин зүйл бусад орнуудынхаас илүүтэй нөлөөлөх нь маргаангүй юм. Энэ нь Ерөнхий сайдын өнгөрсөн 10 дугаар сарын айлчлалын үед хүрсэн тохиролцоонуудаас ч тодорхой харагдаж байна. Тухайлбал, ойрын 20 жилд Хятадаас 10-аад төсөлд 70-80 тэрбум долларын хөрөнгө орох болсныг хэвлэлүүдээр мэдээлсэн.

Тэгэхээр эдийн засгийн өсөлтийг тэргүүлэх байранд тавьж БНХАУ-тай аж ахуйн харилцааг цаашид эрчимжүүлэх үү, эс бөгөөс хамааралт байдлыг хязгаарлахыг чухалчилж хэлхээ холбоог одоогийн түвшинд барих уу гэдэг сонголтын өмнө бид тулж ирээд байна. Биднийхээр бол, даяаршлын орчин цагийн нөхцөлд үйлдвэрлэх хүчнээ аль болох хурдацтай өсгөж, эдийн засгийн хийгээд нийгмийн дэвшлээ түргэтгэж чадсан улс орон эдүгээ цагт тусгаар тогтнол, үндэсний дархлаагаа хадгалах боломжоор илүү хангагдаж байна. Судлаачдын бүтээлээс харахад ч эдийн засгийн аюулгүй байдлыг хамгийн ерөнхий байдлаар “хүн ардынхаа амьдралын түвшинг хэлбэрэлтгүй дээшлүүлэх зорилтыг ханган эдийн засгийн бие даасан хөгжлийг бүрдүүлж буй тогтолцоо” гэж тодорхойлсон нь олонтоо тааралдана. Тэр нь тэгэхлээр зөвхөн гадаад хүчин зүйлээс эс хамааралт байх төдийгүй, юун түрүүнд үйлдвэрлэхүй хүчнийхээ хөгжлийн хувьд өрсөлдөхүйц чадавхитай байх ёстой аж. Аюулгүй байдлыг хангахад цэрэг зэвсэглэлийн үүрэг буурч эдийн засгийн ерөнхий түвшингээр, өрсөлдөх чадвараар нөхцөлдсөн “зөөлөн” хүчин зүйлсийн ач холбогдол өсч байна. Бие даасан байдлын баталгаа нь шуурхай маневрлах боломжийг хангахуйц валютын арвин нөөц, орчин цагийн төмөр зам, авто зам, бас агаарын тээврийн сүлжээ зэрэг материаллаг хүчин зүйлс болон хувирч байна. ГБҮБ-ийн 18 дугаар зүйлд дэвшүүлсэн “үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь” зорилго нь чухамхүү энэ үзэл санаанд нийцэж байна.

Манай орны газар зүйн байршил хийгээд хойд хөршийн эдийн засгийн бүтцээс үзэхүл эрчимтэй өсөлтийн хөдөлгүүр нь өмнөд хөрш л болж таарч байна. Энэ гаргалгаа ямар ч болов ойрын ирээдүйд буюу 15-20 жилийн хугацаанд үнэ цэнээ алдахгүй болов уу. БНХАУ нь 1,2 тэрбум хүнтэй хамгийн багтаамжтай төдийгүй, тогтвортой өсч буй, бас үйлдвэржин буй зах зээл юм. Цар хүрээний хувьд төдийгүй өсөлтийн хурдац, бас технологийн дэвшлийн хувьд тэрээр дэлхийн тэргүүлэх эдийн засаг болон хувирч байна. Манай экспортод ойрын ирээдүйд давамгайлсаар байх эрдсийн түүхий эдийг тээвэрлэн авах дэд бүтэц, шингээх чадамж түүнд л бий. Харин бидний тухайд анхнаасаа ойлгож бүх түвшинд байнга

санаж ажиллавал зохих нэг зүйл бий. Энэ нь бид урд зах зээлгүйгээр хэвийн амьдрахад хэцүү, харин тэд бидэнгүйгээр амьдарч чадна гэдэг тухай болно. Өөрөөр хэлбэл, бид яриа хэлэлцээнд оролцохдоо зөвхөн өөрийн эрх ашгийн үүднээс хандах биш, түншийнхээ ашиг сонирхлыг бүрдүүлэх, харилцан хамаарлыг буй болгоход анхаарвал зохино. Эл хамаарал нь зөвхөн хэрэгцээт барааг нь нийлүүлэх төдийд биш, хөрөнгө нь орж ирсэн, ашигтай ажиллах болон борлуулалтын хариуцлагыг бас нөгөө тал хуваалцахуйц үйлдвэрлэлийн харилцан хамааралт холбоо байх ёстой. Цаашдаа хэрэглээний түүхий эд, хувцас, хивс, даавуу, мах зэргийн экспорт ч Хятадын зах зээлд нэмэгдэх боломжтой. Иргэдийнх нь орлого өсөхийн хэрээр натурал хүнс, эко бүтээгдхүүн худалдан авах хэрэгцээ нь нэмэгдэх нь мэдээж.

Эдийн засгийн аюулгүй байдлын үнэмлэхүй шалгуур нь бүрэн эрхт байдал юм. Үүнийг судлаачид үндэсний хэмжээнд стратегийн шийдвэр гарах эрх мэдэл хийгээд байгалийнхаа баялгийг чадамжтай холбон үздэг. Өөрөөр хэлбэл улс орны дотоод зах зээлээ хянан удирдах эрх мэдэл нь амин чухал салбар, үйлдвэр, компаниудаа удирдан хянах эрх мэдэл юм.

Монголчуудын тухайд ойрын ирээдүйд баримжаа болгох шалгуур нь тэгэхлээр босго хязгаарын тоон үзүүлэлт биш харин дээр дурдсан чадамж, бүрэн эрхээр илэрхийлэгдэх нийлмэл үзүүлэлт болох нь. Гадаад орнуудтай аж ахуйн чанартай хэлхээ холбоог хөгжүүлэх боловч удирдлага хяналтыг нь эрх мэдлээсээ гаргахгүй гэсэн үг. Үндэсний аюулгүйн баримтлалд ч энэхүү томъёоллыг шалгуур үзүүлэлт болгон нэмж оруулахыг санал болгож байна.

Харилцааг хөтлөн явуулах механизмын хувьд гэвэл төрийн оролцоо, зохицуулалт түлхүү шаарддаг өмнөд хөршийн онцлогийг бодолцохоос өөр аргагүй. Хамтын ажиллагааны зарчим, цар хүрээг эхлээд төр, засгийн байгууллагуудын түвшинд тоймлон тогтоодог практикийг нь хүлээн авах, түүнд нь дулдуйдаж аль болох урт хугацааны тогтвортой харилцааг бүрдүүлэхийг чармайх нь манай талд ашигтай ч байж болно. Харин хамааралт байдлыг багасгах нэг түлхүүр нь хойд хөршийн оролцоо мөн. Энэ үүднээс төмөр болон авто зам, нефть, хийн хоолой, цахилгаан дамжуулах шугам зэрэг Орос-Монгол-Хятадын гурвалсан төслүүдээс

болгоомжлох биш харин хөхиүлэн дэмжих чиглэлийг бид баримталж эхлэсэн нь сайн хэрэг юм.

Гуравдагч зах зээлийн ач холбогдлыг үгүйсгэхгүй байна. Гэхдээ транзит тээврийн одоогийн боломж, түүхий барааны овор хэмжээ зэргээс хамааран манай дийлэнх экспортын бараа ойрын ирээдүйд бусад орнууд руу төдий л гарч чадахгүй юм. Оюу толгой зэрэг төслийн жишээнээс харахад ч Монгол дахь гадаадын компанийн хувьд Хятад борлуулалтын гол зах зээл байх нь. Монгол-Хятад-гуравдагч улсын компаниуд гэсэн гурвалсан хэлхээг аль болох дэмжих шаардлага гарах нь.

Гуравдагч түншүүдийг дэмжих бодлого, практик үйл ажиллагаандаа бид өөрсдөө алдаа гаргасаар буйг дашрамд тэмдэглэе. Жишээ нь, хоёр хөрштэй чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах тухай санал санаачилга үе үе цухалцсаар байгаа нь зөвшөөрч эс болох зүйл юм. Тэдний бараа гааль хориггүй орж ирэх тусмаа манай зах зээлд улам л давамгайлна гэсэн үг. Эдүгээ бидний дунд хамгийн “таашаалт” сэдвийн нэг болоод буй АПЕК-т элсэх тухай асуудал ч эцсийн дүндээ өмнөд хөршийн бүх төрлийн бүтээгдхүүнд татвар ногдуулах эрхийг маань хязгаарлана гэсэн үг. Эрдсийн болон хэрэглээний түүхий эдэд аль ч зах зээл гаалийн саад учруулдаггүй тул манай экспортод чөлөөт худалдааны зохицуулалт шаардагдахгүй шүү дээ.

Тэгэхээр өмнөд хөрштэй эдийн засгийн чиглэлээр харилцах тухайд хоёрын хооронд, тодорхойгүй, “шийрэгнэсэн” байдалдаа цэг тавьж эхлээд эдийн засгийн эрчимтэй өсөлтийг тодорхой хугацаанд хангах явдлыг тэргүүн зэрэгт тавих нь зөв гэдэг дээр санал нэгдэцгээе. Энэ нь аливаа хязгаарлалт, босгогүйгээр худалдааны, хөрөнгө оруулалтын харилцааг өргөтгөж, хил дамнасан дэд бүтцүүдээс цэрвэх биш харин хөхиүлнэ гэсэн үг.

Хятадтай аж ахуйг уялдуулахаас болгоомжлох үндэслэл нь чухам юу билээ, тэрээр хэдий хугацаанд үйлчлэх билээ гэдэг асуултад товч хариулахыг хичээе. Монголыг нэгтгэх, нөөц баялгийг нь эзэмдэх, мөлжих гэж байна гэсэн хардлага энэ үзлийн цөм нь. Тийм ээ, Хятадуудад ийм бодлого байсаан. Ялангуяа Монголчууд

тусгаар тогтнолоо сэргээн зарласан өнгөрсөн зууны эхний хагасын турш энэ бодлого, үйл ажиллагааг Гоминданы засаг захиргаа тун идэвхтэй явуулсан. Гэхдээ дэлхийн бөмбөрцгийг хэдхэн том гүрэн хуваан колонижилж байсан XVIII-XIX зуунд аль ч улс, үндэстний ухамсар сэтгэхүй, гадаад бодлогын зорилт ийм л байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тэр цагт үндэстэн хоорондын харилцаан дахь “тоглоомын дүрэм” нь тийм байж. Монголыг эрхшээл, нөлөөндөө оруулахыг зөвхөн Хятад биш Япон ч, Орос ч эрмэлзэж байсан. Манж Го хэмээх тоглоомын улсыг Япончууд Өвөр Монголд байгуулж байсан түүх саяхных. Тэр нь Хятадын хойд хэсэг, зүүн Монгол, Оросын Алс дорнод дахь санаархлыг нь хэрэгжүүлэх түшиц болох байв. Барон Унгерний цагаантныг устгах нь Зөвлөлтийнхний хувьд тэргүүлэх зорилт байсан ч Монголд нөлөөгөө бэхжүүлэх бодлого давхар явж байсан. Хэрвээ тэр үед бид хүчирхэг хэвээрээ байсан бол зэргэлдээх улс түмний хувьд мөн л эзэрхийлэл явуулах байсан гэдэгт огт эргэлзэхгүй байна, тэгэх тусмаа бид дэлхийн талыг хурааж явсан “уламжлалтай” улс.

Эдүгээ улс үндэстэн хоорондын харилцааны дүрэм өөрчлөгдсөн гэж найдъя. Нөгөө талаас, үндэсний хэмжээний амар амгаланг урт хугацаанд хангах олон улсын нөхцөл нь хөрш орнуудтай найрсаг харилцааг хангах тухай БНХАУ-ын номлолыг ч иш үндэс болгоё. Эдийн засгийн өсөлтийнх нь үр шимээс хөршүүд нь бас хүртэх ёстойг манай Гадаад хэргийн сайдын саяхны айлчлалын үеэр Хятадын албаныхан цохон тэмдэглэцгээсэн нь бас нэгийг өгүүлнэ. Харин нэгэнт байгуулсан гэрээ хэлцлийнхээ утга санаа, үг үсгийг чандлан сахиж, биелүүлдэг соёлд бид суралцах ёстой. Гэрээ тохиролцооноосоо нэг талаар буцах болчимгүй алхмууд хийгдсээр байгааг санацгаая. Чалкотой байгуулсан гэрээний талаар 2013 онд өрнөсөн шуугиан үүний тод жишээ.

Эцэст нь өмнөд хөрштэй хэрэгжүүлж буй аж ахуйн харилцааны үр ашгийн асуудал ихээхэн маргаан дагуулдаг. Өөрөө үйлдвэрлэсэн бол илүү зардал гаргахуйц барааг түүнээс хямдаар үйлдвэрлэсэн зүйлээ борлуулж олсон мөнгөөрөө худалдаж авч чадаж байвал харьцангуй ашиг үүсдэгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн. Манай хоёр улсын худалдаанд дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн энэ л шалгуурын үүднээс хандах ёстой байх. Гэхдээ хөгжье гэвэл

мөлжигдөх ёстой, мөлжүүлэхгүй гэвэл хөгжих ёстой гэсэн диалетик тойрогт орших үнэмлэхүй үнэнийг бас хүлээн зөвшөөрөх ёстой болно. Түүнийг энгийнээр илэрхийлвэл харилцан ашигтай байх явдал юм.

Др. Л.Хайсандай /ОУСХ-гийн зөвлөх/

Бид Төмөрчулуун докторын илтгэлийг их анхааралтай сонслоо. Энэ илтгэл манай улсын 1994 оны ГБҮБ-ыг онолын талаас нь авч үзсэн их аятайхан илтгэл боллоо гэж би хувьдаа үзэж байна.

Дөрвөн “Д”-ын чиг шугам гэдэг нэр томъёоллынх нь хувьд бол Монголын ГБҮБ-ыг юм уу, гадаад бодлогыг гадаадын хүмүүст ойлгуулж, олон улсын хэмжээнд ярьж, хэлэхэд иймэрхүү ойлгомжтой хэлбэрээр илэрхийлж болох юм. Гэхдээ 1994 оны ГБҮБ бол Др. Төмөрчулууны хэлээд байгаа дөрвөн “Д” гэдэг юмыг чинь монголоороо илэрхийлчихсэн юм шүү дээ. Монголын үндэсний язгуур эрх ашиг дээр суурилсан, нээлттэй, олон тулгуурт, эвсэлд үл нэгдэх гадаад бодлого явуулна гээд тодорхойлчихсон. Энэ бол монгол хэллэгээрээ яг тэр дөрвөн “Д”-г илэрхийлсэн томъёолол байгаа юм.

Дөрвөн “Д” гэдгийн Десоветизация, Деидеолигизация 2 бол бараг нэг л юм даа. Үүнийг салгаж үзээд байх шаарлагагүй гэж санагдаж байна. Ер нь тэгээд манай нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого гэдэг маань ардчиллыг буюу Демократизация-г илэрхийлж байгаа гэж бодож байна.

Д.Баярхүү судлаачийн хэлсэнтэй би санаа нийлэхгүй байна. ОУ-ын судалгаа болон янз бүрийн зүйлийг харж суухад бол гадаадын олон оронд ГБҮБ гэх мэт олон зүйлсийг гаргаад байдаггүй харагддаг. Манай 1994 оны ГБҮБ-д ОУХ-ны хэллэгэнд, томъёололд, нэршилд тэр болгон тааралдаад байдаггүй томъёолол оруулж өгсөн байдаг. Жишээ нь: “Олон тулгуурт”, “Гуравдах ертөнц” гэх мэт.

1994 оны ГБҮБ-ыг их чамбай боловсруулсан. Манай нэртэй дипломатууд, эрдэмтэд боловсруулсан болохоор нэг их их өөлөх шалтгаан гаргамааргүй юм шиг байгаа юм. Яагаад гэвэл, чиг шугамаа зөв тодорхойлсон. Монголын нийгэм, эдийн засаг, улс төрийн шинэ тогтолцооны үеийн гадаад бодлого, түүний үйл

ажиллагааны баримтлалыг гаргасан чухал баримт бичиг гэж би хувьдаа бодож явдаг. Манайдаа бол нэлээд дэвшилттэй, сайн болсон үзэл баримтлал.

Гадаад харилцааны байгууллага маань эдийн засгийн харилцаан дээр их анхаарч, үүнийг чухамдаа Гадаад харилцааны яамны үүрэг болгох ёстой. Улс хоорондын харилцааны үндсийн үндэс нь эдийн засгийн харилцаа байдаг. Аливаа улс төрийн сонирхлыг сэдэж өдөөгч нь бодит сонирхол буюу эдийн засгийн сонирхол байдаг. Тийм учраас эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа бол тухайн улсын геополитикийн маш чухал хүчин зүйл болдог. Энэ утгаараа манай гадаад харилцаа, ялангуяа улс төрийн гадаад харилцаа маань амжилттай сайн явж байгаа. Харин Гадаад харилцааны яамныхан эдийн засгийн гадаад харилцаанд маш их үүрэгтэй баймаар байна. ГХЯ-ны бүтцэд анх гадаад худалдаа, эдийн засгийн харилцаатай холбоотой газрууд байсан. Одоо байхгүй болсон.

Сүүлийн үед гадаад орнуудтай эдийн засгийн болон бусад гэрээ хэлэлцээр байгуулж байгаа байдал, хэрэгжүүлж байгаа үйл явц их учир дутагдалтай байна. Үүний шалтгаан нь гадаад харилцаанд шинжлэх ухааны үндэс дутагдаж байна. Эрдэмжүүлэх шаардлагатай байна. Манай оронд гадаад харилцаа болон ОУ-н харилцааны чиглэлээр олон эрдэмтэн, судлаачид байдаг. Эдгээр хүмүүсийг бүрэн ашиглаж, улс хоорондын харилцааны амин чухал салбарт анхаарахгүй бол Монгол улсын нэр хүнд, цаашлаад ОУ-н тавцанд манай орны эзлэх байр суурь буурах, сулрах хандлагатай болж эхэлж байна. Тийм учраас байгуулагдаж байгаа гэрээ хэлэлцээрүүдэд ГХЯ ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай байна. Энэ бол миний хэлэх гэсэн нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, миний ажиглаж байгаагаар ГХЯ-ны боловсон хүчин, хүний нөөцийн асуудал дээр их анхаарах хэрэгтэй байна. Мөн өнөөгийн дипломат үйл ажиллагаа болон олон улс хоорондын үйл явцад мэдлэгтэй, туршлагатай дипломатчдыг татаж оролцуулах ажил их дутмаг байна. Эдгээр хүмүүсийг ашиглахгүй байгаагаас манай орны үнэлэмж ихээхэн буурч байна. ГХЯ-ны бүтцийг эрдэмжүүлэх асуудал дээр тогтож хэлбэл, олон жил ярьсны эцэст Дипломат Академи байгуулсанд баяр хүргэмээр байна. Монгол улсын гадаад харилцааг бид нар улс төржсөн байдлаар, улс төрийн үүднээс явуулаад байх биш, нэлээд их

тулгууртай, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны үндэстэй, асар их судалгаатай явуулж байж л энэ гэрээ, хэлэлцээрийг байгуулдаг, улс хоорондын харилцааг хөгжүүлдэг байх хэрэгтэй байна. Манай орон олон улсын байгууллагууд болон бусад орнуудтай дипломат харилцаа тогтоохдоо их анхаарч үзүүштэй байна. Бид өөрсдийнхөө хэмжээнд, өөрсдийнхөө геополитикийн ухаанаар, өвөрмөц онцлогоороо асуудлуудад хандмаар байна. Бид их гүрэн байсан учраас манайхан дэлхийн хэмжээнд сэтгэдэг тал бий. Тэгэхдээ бас бид өөрсдийнхөө өнөөгийн байгаа геополитикийн байр суурьнаас аливаа их , бага асуудалд хандаж явбал зүгээр юм уу гэж бодож байна.

ГХЯ-ны дэргэд байгуулж байгаа “Дипломат Академи” болон “Гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтын судлагааны төв”-ийг байгуулсан шиг байгуулах хэрэгтэй. Түүрэн Гомбосүрэн сайд их сайхан хэллээ. Бид хаа хамаагүй газартай дипломат харилцаа тогтоож, элчин сайдын яам байгуулж байснаас энэхүү хоёр шинэ нэгжээ буюу Академи, Төв хоёрыгоо тордож өгмөөр байна. Гадаад харилцааны талаар мэргэшсэн, бэлтгэгдсэн өчнөөн сайхан мэдлэг боловсролтой эрдэмтэн, судлаач нар байна. Эдгээр хүмүүсийнхээ хүчийг нэгтгэмээр байна. Санхүүгийн хувьд нь үнэхээр сайн дэмжиж өгөмөөр байна. Тэгэхгүй бол одоо гадаад харилцааны судалгаа “шүүрэн шанага шиг савирсан, энд тэндгүй үрэн таран маягтай явж байна. Тийм учраас гадаад бодлого маань нэгдсэн нэг цонхтой байдаг юм бол судалгааг нь бас төвлөрүүлэх хэрэгтэй байна. Баярлалаа.

И.Очирбал / Ахмад дипломат, ОББЭЭС/

Өнөөдөр бидний ийнхүү цуглаж, санал бодлоо солилцож байгаа нь цагаа олсон чухал арга хэмжээ болж байна.

Сайдын зөвлөх О.Машбат сая “ГХЯ-нд ирснээсээ хойш би анх удаа л иймэрхүү нээлттэй ярилцлаганд орж байна” гэж хэллээ. Гайхмаар юм.Энэ бол үнэхээр сүүлийн үед тасалдаад байгаа нэг зүйлийг л харуулж байна. Шулуухан хэлэхэд, энд тэнд, нэг хоёр хүний гар хөл орсон тиймэрхүү л ажил болоод байх шиг санагдаад байгаа юм. Үүнтэй холбогдуулаад бодмоор ярьмаар зүйл их байгаа.

Энд тэр болгоныг би хөндөхөө больё. Нэг хоёрхон зүйл дээр саналаа хэлмээр байна.

УИХ-ын гишүүн М.Батчимэгийн хэлсэн үгэнд маш зүйтэй саналууд гарч ирлээ. Энэ санааа бодлыг судлах боловсруулахад манай ГХЯ-ны нөхдүүд ч оролцсон юм байна. Нэмж хэлмээр юмнууд ч бас байна.

Хамгийн түрүүнд гадаад яамны нэр төр, нөлөө, гадаад бодлогыг чиглүүлэх үүргийг хангахын тулд тодорхой хэмжээний боловсон хүчин байх хэрэгтэй байна. Боловсон хүчин, хүний нөөцгүйгээр гадаад бодлогыг явуулна гэдэг бол ёстой шал хоосон, худлаа зүйл. Гэтэл ийм зүйл болчихоод байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрээр бид НҮБ-ын гишүүн бүх орнуудтай дипломат харилцаа тогтооно гэж манай сайд хэлсэн. Юу бодож тэгж хэлж байна вэ? Дипломат харилцаа гэдэг бол тоглоомын асуудал биш шүү дээ. Хэн дуртайтайгаа харилцаа тогтоогоод явж байна гэсэн үг биш. Хоёр орны сонирхол, манай өөрийн үндэсний сонирхол болон нөгөө талын ашиг сонирхол нийлж байж дипломат харилцаа явах ёстой. Яахав, томоохон орнуудын хувьд бол мэдээжийн хэрэг бид өөрсдөө гуйж очих хэрэгтэй. Хаа хамаагүй, энд тэндгүй 200-хан, 300-хан мянган хүнтэй улстай дипломат харилцаа тогтоолоо ч гэх шиг, 14 улсын нэр шинээр биччихээд сууж байна. Энэ бол ерөөсөө манай ажлын арга барилын янз байдлыг л харуулж буй хэрэг.

Үүний цаана гадаад бодлогод нөлөөлж байгаа нэг гол айттар зүйл бол төр засаг дөрвөн жил болоод л солигддог, үүнийг дагаад бүх юм орвонгоороо өөрчлөгддөг байдал. Энэ нь ганц гадаад харилцааны салбарт ч биш, эдийн засгийн бүх салбарт намын харьяаллаар хүмүүсийг ажилд томилдог болчихсон. Энэ бол ялангуяа гадаад харилцаанд маш хортой арга хэмжээ болж байна. Мэдээжийн хэрэг сайд хүн өөрийн гэсэн багтай байдаг л гэж ярьдаг. Тэгэхдээ тэр нь хэмжээнээсээ хэтэрч болохгүй. Гэтэл манай дипломат албаны хуулинд заасанчлан гадаад яамны ажилтан намын харьяалалгүй байна гэж аль 1990-ээд оноос л ярьсан. Гэтэл энэ бодлого хэрэгжихгүй байна. Үүнээс болоод энэ яаманд байсан манай ажил хийх, судалгаа хийх чадалтай хүмүүс маань тараад тараад

явчихсан.Оронд нь харин ч намын харьяалал, нөмөр нөөлгөнд дулдуйдсан хүмүүс энэ яамаар дүүрэн болж. Энэ талаар би М.Батчимэг гишүүнд хэлсэн, дараа саналаа хүргүүлэх болно .

Жинхэнэ судлаачдыг бэлтгэнэ гэвэл дурын хүнийг судлаач болгоно гэж бодохын хэрэггүй. Болгоно гээд ч болдог зүйл биш. Гомбосүрэн сайдын түрүүн хэлдгээр өчнөөн олон зүйлийг хийж үзэж байж, алдаж онож байж л арга барилыг нь олж авах ёстой.

Би сая Др.Г.Төмөрчулууны илтгэлд их сонин зүйлийг олж харлаа. “Дагуул орон өөрийн саталайт орны нөлөөнд орох ёсгүй” гэж юу ярьж байгаа юм бэ? Дагуул орон гэдэг чинь саталайт орон шүү дээ. Иймэрхүү байдлаар бид судалгаа хийж болохгүй.

Би ахмад хүний хувьд нэг зүйл хэлэх ёстой.ГХЯ-ны удирдлага ахмад дипломатууд бид нартай уулзаж, санал бодлыг маань сонсохоо бүр байсан. Зарим нь биднийг загнаад, та нар өөрөө яваад, өөрсдөө олоод үзэхгүй юу гэж байсан үе ч бий. Жилдээ 2 удаа ахмадууд уулздаг. Түүн дээрээ биднийг зөвхөн дайлаад л өнгөрдөг. Хуучин бид нар 1 цагийн хугацаанд яамны удирдлага, зарим газар, хэлтсийн дарга нартай уулзаж ярилцаад, тэд нарын ажил байдлыг сонсоод, санал бодлыг нь мэддэг байсан. Одоо бол би л лав мэдэхгүй байна.

Академи, судалгааны төв байгууллага л гэнэ. Яагаад, юуны учир байгуулсан юм бэ? гэдэг нь ойлгомжтой баймаар. Байгуулсан нь бол зөв. Гэхдээ үүнийгээ жинхэнэ үр дүнтэй ажил болгохын тулд олон нийтийнхээ саналыг сонсоод, дээд удирдлагад нөлөөлөхийг бодох хэрэгтэй байна. Баабар сая биднийг шоолж байна шүү дээ. “Гадаад яамны жилийн төсөв 50 тэрбум төгрөг. Зарим яам 200, 300 тэрбум төгрөгийн төсөвтэй байдаг. Төрийн нүд, чих болдог гадаад яам нь техникийн их сургуулийн төсөвтэй адилхан” гэж. Үүнийг ч гэсэн манай эрхэм удирдлагууд сонсч, харж, бодож байгаа гэж ихэд найдаж байна. Өөр ярьж хэлмээр зүйл их байгаа ч гэсэн цаг бага байгаа учир ингээд дуусгая.

Др. В. Энхболд /Элчин сайд асан/

УИХ-аас 1994 онд баталсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын түүхэн ач холбогдол, үүрэг ролийн талаар өмнө нь үг хэлсэн илтгэгч нартай санал нэг байна. Иймд гадаад бодлогын салшгүй хэсэг болох эдийн засгийн дипломат үйл ажиллагааны талаар цөөн хэдэн үг хэлье.

Жилээс жилд дэлхийн эдийн засаг тэлэх хэрээр эрчим хүчний түүхий эдийн эх үүсвэрийн төлөө өрсөлдөөн улс орнуудын харилцаанд зонхилох боллоо. Үүнтэй уялдаж олон улсын харилцаанд "гео-эдийн засаг", "эрчим хүчний аюулгүй байдал", "стратегийн түншлэл", "эдийн засгийн дипломат" гэх мэт шинэлэг нэр томъёо сүүлийн үед өргөн хэрэглэгдэх болов. Энэ нь мөнөөх эрчим хүчний түүхий эдийн хэрэгцээ нь нэмэгдэж, нөөц нь хомсдож байгаатай холбоотой гэж үзэж болох юм. Олон улсын эрчим хүчний байгууллагын судалгаагаар 2010-2030 оны хооронд газрын тос, байгалийн хий, нүүрсний хэрэглээ жилд дунджаар 1.7 хувиар өсч, 2030 онд Хятад, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнууд эдгээр түүхий эдийн гол хэрэглэгчид байх тооцоо гарчээ.

Эрчим хүчний түүхий эдийн эрэлттэй уялдаж манай уул уурхайн салбарт олон улсын хөрөнгө оруулагчдын сонирхол эрс нэмэгдсэн билээ. Манай хоёр хөрш орон болон гуравдагч түнш орнуудын хөрөнгө оруулагчдын зүгээс Монголд хөрөнгөө байршуулах, уул уурхай, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрт идэвхийлэн оролцох, уул уурхайн ордод түшиглэж гадаадын санхүүгийн бирж дээр хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжих болов. Зүүн хойд азийн бүс нутагт эрчим хүчний эрэлт өсч буйтай уялдаж хойд хөрш ОХУ-ын төр засаг холбогдох зохицуулалт хийж эхэлсэн байна. 2009 онд ОХУ-ын Думаас 2030 он хүртэлхи эрчим хүчний шинэ стратеги баталсан ба үүний дагуу эрчим хүчний түүхий эдийн экспорт нь Европ чиглэлээс аажмаар Алс Дорнод, нэн ялангуяа Зүүн Хойд Ази,болон Ази, Номхон далайн зүгт чиглэх болов. Түүнчлэн 2012 оны 12 дугаар сард "Орос-Хятад эрчим хүчний салбарт хамтарч ажиллах хэлэцээр"-т тус хоёр орны засгийн газрын дэд тэргүүн нар гарын үсэг зурсан нь хоёр хөршийн стратегийн түншлэлийн харилцаанд эрчим хүчний хамтын ажиллагаа, нэн ялангуяа газрын тос, байгалийн

хий болон нүүрсний салбарт хамтран ажиллах асуудал чухал байр суурь эзэлж буйг нотолж байна.

Эрчим хүчний түүхий эдийн эрэлт, нийлүүлэлт, мөн эрчим хүчний аюулгүй байдлын асуудлын улмаас улс орнуудын гадаад харилцаанд “эдийн засгийн дипломат үйл ажиллагаа” чухал үүрэг рольтой болж байна. Японы гадаад харилцааны сайд Сэижи Маехара 2001 онд гадаад бодлогын талаар тавьсан илтгэлдээ “Японы эдийн засгийн дипломат бодлого нь 4 тулгуур баганаас бүрдэх ба үүнд: чөлөөт худалдааны систем, нөөц баялаг, эрчим хүч, хүнсний урт хугацааны тогтвортой хангамж болон олон улсын дэд бүтэц” гэж тодорхойлжээ. Харин Энэтхэгийн дипломатын холбооны үзэж буйгаар “Эдийн засгийн дипломат үйл ажиллагаа нь аливаа улс хоорондын харилцаанд эдийн засгийн аюулгүй байдал болон тухайн орны стратегийн ашиг сонирхолын үүднээс эдийн засгийн механизмыг оновчтой ашиглах асуудал” гэжээ. Хятадын хувьд энэ асуудалд онцгойлон анхаарч 2012 онд гадаад харилцааны яаманд эдийн засгийн дипломат үйл ажиллагааг зохицуулах тусгай газар байгуулан БРИКС, Их-20, АПЕК болон бүс нутгийн эдийн засгийн интеграцийн асуудлуудыг хариуцуулсан байна.

Иймд Монгол улсын хувьд хувьсан өөрчлөгдөж байгаа олон улсын нөхцөл байдал, ялангуяа бүс нутагт идэвхжиж буй эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцыг оновчтой мэдэрсэн эдийн засгийн дипломат үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд дараахь асуудалд анхаарах нь зүйтэй.

2009 онд Монгол улсын засгийн газраас баталсан “Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дүгнэн хянаж, улмаар өнөөгийн олон улсын харилцааны нөхцөл байдалд уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай байна. Энэхүү баримт бичиг Монгол улсын эдийн засгийн дипломат үйл ажиллагааны гол удирдамж чиглэл нь болох учиртай юм.

Эдийн засгийн дипломат үйл ажиллагаа нь эдийн засгийн хөгжил, худалдаа, хөрөнгө оруулалт, зээл тусламж, уул уурхай, эрчим хүч, аюулгүй байдал гэх мэт олон салбарын зангилаа асуудал байдаг тул уг бодлого, стратегийн шинж

чанартай асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн яам нь зангидан хариуцдаг олон улсын нийтлэг жишгийг манай засгийн газрын бүтэц зохион байгуулалтын хувьд харгалзан үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Эдийн засгийн дипломатын чиглэлээр залуу дипломатчдыг системтэйгээр сургах, давтан сургах, нэн ялангуяа “хэлэлцээ хийх ур чадвар”-ыг сайжруулах сургалт, хөтөлбөрт хамруулах нь зүйтэй. ГХЯ-ны дэргэд шинээр байгуулагдсан Дипломатын академийн сургалтын хөтөлбөрт эдгээр сургалтыг оруулж боловсон хүчнийг бэлтгэх нь оновчтой байх талтай.

Д.Батжаргал / ГХЯ-ны БТСГ-ын зөвлөх/

“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” нь “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-тай нягт уялдсан нэг нэгнээ нөхсөн даацтай сайн баримт бичиг болсон гэж боддог. Гадаад харилцааны тулгуур баримт бичиг гэсэн утгаараа үүргээ сайн биелүүлж байгаа гэж дүгнэж болно. Мэдээж, аливаа хууль баримтлал цагийн урсгалд өөрчлөлтийг тусган “амьд” байх ёстой ч гол чиг шугам нь алсын хараатай хийгдсэн болохыг цаг хугацаа харуулсан.

Үзэл баримтлалд шалгуур үзүүлэлт байх, тогтоох тухай хүмүүс ярьж байна. Миний хувьд ингэх шаардлагагүй гэж бодож байна. Үзэл баримтлал гэдэг нь баримталж явах “дээс” тогтоосон баримт бичиг болохоос хөтөлбөр, төлөвлөгөө биш. Хүмүүсийн шүүмжилж байгаачлан үзэл баримтлалд орсон эдийн засгийн зорилт, зорилгын хэрэгжилт муу байна гэдэг ч юм уу, шалгуур үзүүлэлт тогтоох тухай яриаг дэмжмээргүй байна. Харин үзэл баримтлалдаа тулсан нийгэм эдийн засаг, соёл, боловсролын салбарт хэрэгжүүлэх тодорхой хөтөлбөртэй байх ёстой болов уу. Тухайлбал, 2009 онд боловсруулсан “Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр” шиг маш тодорхой үйл ажиллагааг төлөвлөсөн, үзэл баримтлалыг “дагалдсан” дунд болон урт хугацааны хөтөлбөрийг боловсруулж гаргах шаардлагатай. Тэр хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг ханган биелүүлэхэд оролцогч талууд байнга анхаарах ч учиртай. Өмнөх эдийн засгийн хөтөлбөрийг харахад хэрэгжилт муугүй, ер нь ийм хөтөлбөр хэрэгтэй юм байна гэдгийг хэлэхийн хамт хугацаа нь дуусахад хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг гаргаж,

дүгнээгүй байдлаас харахад гадаад бодлогын төлөвлөлт үгүй, урсгалаараа явдаг гэсэн шүүмжлэл дагуулах нь аргагүй юм гэж бодогдож байна.

Мөн үзэл баримтлалд орсон зарим зүйл заалтыг ойлгомжтой болгох тухай яриа гардаг. Жишээлбэл “Гуравдагч хөрш”-ийн томъёоллыг энгийн иргэд яг аль улсыг хэлээд байна гэж их асуудаг. Миний бодлоор үзэл баримтлалд заасан байдал нь зөв гэж боддог. “Тодорхойгүй байдал” нь зөвддөг ч үе байдаг. Ер нь зарим орны гадаад бодлогын баримт бичгийг харахад мэргэжлийн бус хүнд ойлгоход төвөгтэй хэлбэрээр бичигдсэн байхтай тааралддаг.

Цаашид “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д нэмэлт хийх, өөрчлөх болвол эдийн засгийн дипломат бодлогыг сайтар суулгах, энэ агуулгаар нь баяжуулах шаардлага байгаа гэж бодогддог.

Я.Дашням / Элчин сайд асан, ОББЭЭ/

Хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах тухай асуудал нь хувь, процентын тухай асуудал биш юм. Урд өмнө нь нэг гүрэнтэй хэтэрхий илүү харилцаатай байсан явдлыг тэнцвэржүүлж, хоёр хөрштэйгөө адилхан сайн харилцана гэж ойлгож байсан. Харин өнөөдөр зэс, ноолуураа хэнд нь хэдэн хувь өгч байна вэ? гэдэг нь өөр асуудал. Манай орны гадаад худалдааны хувьд аль нэг улс нь илүү жин дарж байж болох юм. Гэхдээ улс төрийн бодлого бол хэвээрээ байгаа гэж бодож байна.

Хоёрдугаарт, бид бол цөмийн статусгүй орон. Манай цөмийн зэвсэггүй статусыг олон улс баталгаажуулсан. Үүнийг дэмжиж тогтоол гаргасан байдаг. Гэхдээ өөрчлөгдөхгүй юм гэж байдаггүй. Дэлхийд болж байгаа үйл явдлууд бас л нэг шинэ зүйл гаргаад ирдэг. Миний бие Украинд нэлээд хэдэн жил ажилласны хувьд хэлэхэд Украины цөмийн цэнэгүүд, пуужинг ЗХУ задарсны дараа ОХУ өөртөө авахдаа Украйны газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хамгаална гэж гэрээ хэлэлцээр байгуулсан юм. Гэтэл өнөөдөр Крым хэний талд орчихоод байгаа нь тодорхой. Энэ юуг харуулж байна гэвэл үндэсний эрх ашиг, үндэсний аюулгүй байдал гэдэг бол байгуулсан гэрээ хэлэлцээр, амлалтаас илүү хүчтэй байдаг юм байна. Энэ нь харин тухайн улсынхаа хувьд бол зөв биз. Жишээ

нь, Хар далайн флотыг Орос орон эргүүлж авснаараа бараг 1917 оноос хойш олоогүй олзоо олж байна гэж хэлж болно. Яагаад гэвэл, ЗХУ задрах үед Орос улс зүүн тийш шахагдаж, хөлддөггүй усан боомтгүй болсон. Бальтийгаа алдсан. Севастополийн флотыг Украинд түрээсэлдэг байсан юм. Харин одоо Хар далайн флотыг авсан нь ОХУ-ын хувьд маш том ололт.

Орос, Украины асуудлын талаар Монгол Улс дундыг барьж байгаа байх. Тэр нь энэ нь зөв гэж үзээгүй байх. Ер нь олон улсын эрхзүйд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал гэдэг нэр томъёо байхаас хүн амын бүрэн бүтэн байдал гэж байдаггүй. Үүнийг аль ч улс анхаарч байх ёстой. Украины явдлын дараа манай сонин хэвлэлүүдээр мэдэхгүйгээсээ болоод хачин жигтэй мэдээллүүд гарч байна билээ. Аль нэг улс ирээд манай аль нэг аймагт санал асуулга явуулаад саналыг нь авчихвал аймаг аймгаараа тасраад, захаасаа алга болчих юм шиг утгатай зүйл бичсэн байсан. Тийм зүйл гэж байхгүй. Хүн амын хувьд бол ямар үндэстэн байх, гадаад оронд орогнох, гадаад паспорттой болох, гадаадын иргэн болох тухай бол жич асуудал. Энэ бол улс орны тусгаар тогтнолтой холбоогүй асуудал. Гол санаа нь манай орны цөмийн зэвсэггүй статусыг цөмийн зэвсэгтэй орнууд дэмжсэн нь албан ёсны баталгаа болж чадах уу, үгүй юу гэдгийг хойшид анхаарах нь зүйтэй байх.

Эвсэлд нэгдэх асуудлын тухайд түрүүн Гомбосүрэн сайдын хэлснээр бас л бүрхэг болж байгаа гэдэг нь үнэн юм. Хуучин хоёр туйлт юмуу, эвсэлд нэгдэх нэгдэхгүйн тухай асуудлыг Зөвлөлт, Америкийн хоёрын зонхилдог эвслээс барьж байсан бодлого юм. Харин өнөөдрийн хувьд ажваас НАТО –той тэрсэлдэхээр, түүнтэй сөргөлдөхөөр эвсэл гэвэл Шанхайн гэрээний орнууд байж магадгүй юм гэж сая Элчин сайд Ч.Баатар ярилаа. Тиймээс одоо дэлхий чухамдаа 2 туйлт биш, 1 туйлтай болчихоод байна. Тэр нь АНУ. Харин хуучин ЗХУ-ын байр суурийг Хятад улс эзлэх хандлагатай байх шиг.

Гадаад харилцааны салбарт айлчлалууд их болж байна. Хуучин цагт гадаад оронд ажлын айлчлал хийнэ гэдэг нь том орны том даргын хийдэг ажил байлаа. АНУ-ын ерөнхийлөгч тэр оронд ажлын айлчлал хийжээ гэдэг ч юм уу. Ер нь социалист орнуудын хувьд гадаад оронд ажлын айлчлал хийх тухай асуудал

байгаагүй. Учир нь айлчлах болгондоо гэрээ хэлэлцээр байгуулдаг, түүний бэлтгэл ажил гэж 2-3 сарын турш хэлтэс, газрууд ажилд дарагддаг байлаа. Гэтэл одоо энд тэнд айлчиллаа гэх атлаа ямар гэрээ хэлэлцээр байгуулав, ямар үр дүнд хүрэх гэдэг тухай сонин хэвлэл, мэдээллээр бичиж, ярьж байгаа нь харагдахгүй юм. Тиймээс гадаад айлчлалын чанарыг сайжруулахад анхаарах нь зүйтэй байна. Зөвхөн ГХЯ гэлтгүй манай улсын хэмжээгээр гадаад айлчлалаар хээнцэрлэх явдал их түгээмэл болсон байна. Гадаад харилцаа ярьдаггүй хүнгүй болсон. 76 “гадаад харилцааны сайдтай” болсон. Хуучин бидний үзэж байснаар бол парламентын харилцаа гэдэг нь их хязгаарлагдмал, төрийн харилцаа нь түүнээс жич гэж үздэг байлаа. Одоо төрийн, парламентынх нь ялгагдахаа больсон байна.

Монгол улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал үүсгэн батлагдаад 20 жил, шинэчдэгдэн багтлагдаад 3 жил болж байхад мань мэт нь тэтгэвэрт гарчихсан юм байна. Тиймээс харамсалтай нь хэрэгжүүлэх ажилд нь оролцож амжаагүй. Хажуугаас нь харж байхад хэрэгжиж л байна, болж л байна. Үүнийг үндсээр нь шинэчилнэ, өөрчилнө гэсэн асуудал байхгүй байх. Харин нэмэлт, өөрчлөлт оруулах байх гэж бодож байна.

Др. Д.Мөнхтөр: /Стратегийн судалгааны хүрээлэнгийн Европ, Хойт Америкийн судалгааны төвийн эрхлэгч/

Др. Төмөрчулуун гуайн илтгэсэн Гурван Д-гийн чиг шугам дээр нэмээд 3Д+1Г гэж томъёолж болохоор гуравдагч хөршийн бодлогын талаар товч ярья.

Гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш манай дотоод, гадаад орчин нэлээд өөрчлөгдлөө. Монгол улсын хувьд дэлхийн хамтын нийгэмлэгт бие даасан байр сууриа бэхжүүлэн, олон улсын харилцаанд нэг чигийн урсгалт харилцаанаас эрх тэгш, хамтрагч, түншийн харилцаанд шилжих хариуцлагатай үе эхэлж байна гэж бодож байна. Хоёр хөршийн бодлого, үйл ажиллагаа илэрхий идэвхижиж, дотоод эдийн засгийн хүнд үеээ ардаа орхиж, гадаад бодлогодоо анхаарал хандуулж, бүс нутаг, олон улсын харилцаанд өөрийн жинтэй байр суурийг бий болгож, нөлөөллөө бэхжүүлэхийг чармайж байна. Гэвч нөгөө талд нь бидний гуравдагч хөршүүд олон улсын харилцаанд нөлөөгөө хадгалахаар хичээж байна. Гэсэн хэдий ч дараалсан эдийн засгийн хямрал зэрэг

бэрхшээлийн улмаас чамгүй хүндрэл учирч байна. Нөхцөл байдал ийнхүү өөрчлөгдөж байгаа учраас бид гуравдагч хөршийн бодлогоо дүгнэж цэгнэж, нөхцөл байдалд тааруулах хэрэгтэй болж байгаа. Юуны түрүүнд энэ бодлогын талаар дотооддоо нэгдмэл байр суурьтай болж, ойлголтын зөрүүг арилгаж, учирч болзошгүй эрсдлийг тооцож, цаашдын ирээдүйн хандлага ямар байхыг тодорхойлох шаардлага тулгарч байна. Хэд хэдэн санаа дурдвал, гуравдагч хөрш, гуравдагч түнш гэх зэргээр янз бүр бичиж ярьж байгааг нэг мөр болгох, үзэл баримтлалдаа заасан хувилбарыг хэрэглэж хэвших, гуравдагч хөршийн нэрсийг жагсаах нь зүйтэй эсэх, “улс, холбоод зэрэг” гэж оруулсан байгаа учраас магадгүй ЕАБХАБ, НАТО зэргийг нэмж оруулах нь зүйтэй эсэхийг шийдэх нь зөв байна. Гуравдагч хөршийн сайн, муу талуудыг түрүүн дурдлаа.

Мөн гуравдагч хөршийн шалгуур үзүүлэлтүүдийг заасан байдаг. Үүнд өндөр хөгжилтэй, ардчилсан гэж заасан байдаг нь харилцаж байгаа улс орондоо тусгайлан шалгуур тавьж, зааглаж үзэж байгаа хэрэг бус. Харин хөгжилд хүрэхэд үлгэр жишээ болгох үүднээс ардчилсан, өндөр хөгжилтэй гэдэг үгийг оруулсан байдгийг илүү өргөн хүрээнд тусган ойлгох нь зүйтэй юм. Гуравдагч хөрш гэдэг нь нэгэнт газарзүйн тухайд ярьж байгаа ойлголт биш учраас гуравдагч хөршийг сонгох боломжтой. Иймээс манай ардчилал хөгжлийг тууштай дэмжигч, дорвитой хандивлагч, хөрөнгө оруулагч, аюулгүй байдал, хөгжил дэвшил, эдийн засгийн хувьд ач холбогдолтой улс бүр гуравдагч хөрш байх боломжтой гэсэн байр суурь ч байдаг.

Гуравдагч хөршийн бодлого нь ямар нэг хязгаартай байх уу гэсэн асуудал гардаг. Олон улсын харилцааны түүхийг аваад үзэхэд аливаа бодлого нь тодорхой хугацаанд хэрэгжээд зогссон жишээ байдаг. Жишээ нь 1970-аад онд Герман улсын Ост политик байна. Одоо АНУ “дахин тэнцвэржүүлэх бодлого” гэж ярьж байгаа. Энэ мэт бодлогууд нь тодорхой хугацаанд хэрэгжээд үр дүнд хүрэх нь хүрч, хүрээгүй нь зогсож, саарсан байдаг. Харин манай гуравдагч хөршийн бодлого бол мөнхийн хөршүүдийн дундах мөнхийн бодлого байх ёстой юм. Энэхүү бодлогод цаг хугацааны хязгаар тавих боломжгүй боловч, ил гаргах, эрчимжүүлэх, эсвэл сааруулах, засварлах зэрэг ажлыг хийх боломжтой юм. Тэгвэл энэ бодлого ямар

үед тодорч, ямар үед эрчимжиж, эсвэл саарч байх хязгаарыг бид тодорхойлох ёстой юм.

Хэрэгжих салбарын тухайд улс төр, соёл, хүмүүнлэг гэх мэтээр тодорхой заасан буй. Батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарыг оруулаагүй байдгийг тодруулан хэлэх хэрэгтэй. Энэ нь сүүлийн жилүүдэд өргөжин хөгжиж байгаа аюулгүй байдлын гадаад хамтын ажиллагаанаас ангид мэт харагддаг. Энэ нь нөгөөтэйгүүр бид дотооддоо аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн харилцааны зааг хүрээг нарийвчлан ялгаж, хэвшээгүй байдагтай холбоотой юм. Эндээс цэргийн харилцаа нь хамгийн бага хүрээтэй, улмаар батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал нь хамгийн өргөн хүрээтэй асуудал юм. Дээрх 3 түвшинг авч үзвэл, аюулгүй байдлын түвшинд гуравдагч хөрштэйгөө харилцаж байгаа нь хоёр хөршийн аюулгүй байдалд харшилсан, эсвэл давж гарсан зүйл байхгүй байна гэж үзэж байгаа. Тухайлбал Монгол Улс олон улсын эхийг сахиулах ажиллагаа, НҮБ-ийн мандаттай үйл ажиллагаанд оролцож байгаа нь зэвсэгт хүчнийхээ чадавхийг сайжруулах, олон улсын тавцанд нэр хүндээ өсгөхөд чиглэсэн бодлого гэж үзэж байна.

Илтгэгч нарын сэдэвтэй холбогдуулан санал хэлэхэд, заавал дагаж мөрдөхөөс гадна хэрэгжилтийг нь шүүн ярилцах албагүй гэсэн дүгнэлттэй судлаачийн хувьд би санал нэгтэй байна. Учир нь энэхүү үзэл баримтлал нь луужингийн үүрэг гүйцэтгэх болов уу. Харин тулгарсан асуудлыг хэрхэн шийдэж даван туулах нь тухайн үеийн нөхцөл байдлаасаа шалтгаална гэж үзэж байна.

Энэхүү хурлыг зохион байгуулсан Дипломатын Академийн хамт олонд талархал илэрхийлье. Дипломатын Академи үүсэн байгуулагдсанаараа дипломат албыг эрдэмжүүлэх үйлсэд томоохон алхам боллоо гэж үзэж байна. Мөн залуу үеийг ахмад үетэй холбох гурван цагийн хэлхээ болж өгөх таатай нөхцөл бүрдэж байна гэж үзэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Др.С.Баттулга /МУИС-ийн ОУХНУС-ийн захирал/

Өнөөдөр би ГБҮБ гэхээсээ илүү судалгааны чиглэл бүхий их сургуульд Гадаад бодлогын үзэл баримтлалыг тусгах талаар буюу гадаад харилцааны

чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэж ирсэн сургуулийн асуудалд та бүхний анхаарлыг хандуулах гэж байна. Хэлэх зүйл маань 3 хэсгээс бүрдэж байгаа.

1. Оршлын оронд: “Харилцаа” гэх “Бренд”

МУИС-ийн ОУХДС (одоогийн ОУХНУС) бол Монгол улсад олон улсын харилцаа, дипломат албаны чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэж эхэлсэн анхны, цоо шинэ, төрийн сургууль билээ. Энэ сургуулийн үнэт зүйл, алсын хараа, сургалт, судалгааны стратеги чиглэлийг тодорхойлоход баримжаа болгож байх ёстой чухал баримт бичиг бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (ҮАБҮБ), Гадаад бодлогын үзэл баримтлал (ГБҮБ) мөн. Эдгээр үзэл баримтлалд зарчмын өөрчлөлт орох цаг үетэй давхцан тус сургууль өөртөө ямар нэгэн өөрчлөлт хийж байсан байдаг.

МУИС-ийн бүрэлдэхүүнд анх 1991 онд ОУХДС байгуулагдах үед гадаад хэлний тэнхмүүд голлох үүрэгтэй байв. 1994 онд ГБҮБ батлагдан гарч байхад тус сургууль мэргэжлийн хөтөлбөрүүдээ ид боловсруулж байлаа. Тус сургууль 2001 онд ОУХС, ГХСС гэсэн 2 салбар сургууль болж салсан байдаг. Энэ үеэс ОУХС-ийн сургалт судалгаанд олон улсын харилцааны чиглэл голлох үүрэгтэй болсны зэрэгцээ олон улсын эдийн засаг, олон улсын эрхзүйн чиглэлээр өргөжжээ. 2011 онд ГБҮБ шинэчлэгдэн батлагдах үе МУИС хөгжлийн шинэ стратегийн чиглэлээ тодорхойлж баталсан цаг үетэй давхцадаг.

МУИС-ийн шинэ стратеги зорилт бол өрсөлдөхүйц чадавхтай, “судалгааны их сургууль” болох явдал юм. Энэ шинэ зорилтын хүрээнд МУИС-д бүтцийн өөрчлөлт хийгдэж, 2014 оноос ОУХС МУИС-ийн бүрэлдэхүүний 5 сургуулийн нэг болж, “Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль” болон өргөжлөө. Энэ өөрчлөлтийн дараа зарим нэг хүн “олон улсын харилцаа, нийтийн удирдлага гэсэн 2 чиглэл яаж зохицох юм бэ” гэж тээнэгэлзэж байсан. Гадаад бодлого урт хугацаанд тогтвортой, залгамж холбоотой байдаг бол төрийн бодлого цогц, системтэй, гадаад дотоод бодлого нь нягт уялдаатай, залгамж сайтай, тогтвортой байх ёстой билээ. Нөгөөтэйгүүр, зарим нэг хүн манай сургуулийг “дипломатч болгож өгдөг сургууль” гэх ташаа ойлголттой явдаг юм шиг санагддаг. Дипломатч

хүн бол урт хугацаанд тодорхой сорилтуудыг давж шалгарсан, шигшигдсэн, туршлага хуримтлуулсан, мэргэжлийн хүн байдаг тул бид яаж ч хичээгээд ийм хэмжээний хүнийг бакалаврын түвшинд бүү хэл магистрын түвшинд бэлдэх боломжгүй юм. Тэгвэл өнөөдөр бид монголын төлөө, төрийн албанд ажиллах хүсэл тэмүүлэлтэй, төрийн албаны ажилтны суурь шаардлага, чадвар, мэдлэгтэй боловсон хүчний бааз суурийг бэлтгэх ёстой болох нь илүү тодорхой боллоо. Дээрх утгаар бол энэ сургуулийн бүтэц, агуулга хоорондоо уялдаатай, үндэсний эрх ашигт нийцсэн, цар хүрээний хувьд илүү өргөжсөн гэж хэлж болно.

Өнөөдөр ОУХНУС-ийн өмнө МУ-ын Үндсэн хууль болон ҮАБҮБ, ГБҮБ-ын тулгуур үзэл санаа, зарчим, Төрийн албаны хуульд заасан шаардлагыг зайлшгүй харгалзаж, сургалт судалгааг чанарын өндөр түвшинд зохион байгуулах, өрсөлдөхүйц, чадвартай боловсон хүчнийг бэлтгэн гаргах, олон улсын харилцааны судлаачдын залуу халааг бэлдэх, мэргэшүүлэх, тэдний карьерын боломжийг бүрдүүлэх, олон улсын харилцаа болон хөгжлийн бодлогын чиглэлээр салбар дундын судалгааг хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Бид ойрын болон дундын хугацаанд олон улсын харилцаа, удирдлагын мэргэшсэн сургууль болж, энэ чиглэлээр ахисан түвшний сургуулийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх зорилт дэвшүүлж байгаа болно. Сайхан зорилт байж болно, гэхдээ тэрхүү зорилт нь бодит агуулга, үр дүнгээр баталгаажих ёстой.

2.Боломж хийгээд асуудал

Тус сургууль 20-оод жилийн хугацаанд саад бэрхшээл багагүй туулсан бололтой байдаг хэдий ч чамлахааргүй их зүйл хийж бүтээжээ. Энэ хугацаанд гадаад хэл, орон судлал, олон улсын харилцаа, олон улсын эдийн засаг, эрхзүйн чиглэлээр 2000 гаруй үндэсний сэхээтэн бэлтгэн гаргажээ. Судалгаа, шинжилгээний ажил хийхийн зэрэгцээ гадаад харилцаандаа анхаарал хандуулж иржээ. Мөн гадаадын ижил төстэй мэргэжлийн цөөнгүй сургуулийн туршлагыг судалж, хөтөлбөрийн агуулгаа хэд хэдэн удаа шинэчилсэн байдаг. Ж.Баясах профессор тус сургуулийн захирал байх үед, Ц.Гомбосүрэн гуай тухайн үед ГЯЯ-ны сайд байх үед, М.Дүгэрсүрэн гуай захирлын зөвлөхөөр ажиллаж байх үед тус сургуулийг ГЯЯ-ны зүгээс нэлээд дэмжиж байсан байдаг. Тухайлбал ГЯЯ-ны

дипломатуудыг ОУХДС-д жилдээ 20 цагийн хичээл заахыг үндсэн ажлынх нь дагуу үүрэг болгож байсан байх жишээтэй . Н.Алтанцэцэг профессор захирал байх үед тус сургууль хичээлийн шинэ байранд нүүн орж, оюутан, багшгүй баярлацгаасан гэдэг. 2013 онд “олон улсын харилцаа”, “олон улсын эдийн засгийн харилцаа” гэсэн 2 хөтөлбөр Үндэсний магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр болжээ. Энд өнөөдөр гадаадын 60 гаруй иргэн суралцаж байна. Жил бүр хамгийн авьяас чадвартай, гадаад хэлний гүнзгий мэдлэгтэй, өөртөө итгэлтэй залуучууд элсэн орж байна. Энэ жилийн элсэлтээс харахад ОУХНУС-д УБ хотын 100 элсэлтийн квотод 2626 элсэгч бүртгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл монголын нийгэмд “Харилцаа” гэсэн боловсролын “брэнд” нэгэнт бий болж, энэ “брэнд”-ийн суурь бэхэжжээ. Энэ бол энэ хамт олны амжилт, боломжийн үндэс юм.

МУИС 2010 онд өмнөх стратеги зорилтоо дүгнэхдээ нэлээд шүүмжлэлтэй хандаж, хатуухан үнэлгээ өгсөн байдаг. Түүний үр дүнд шинэ стратеги зорилтоо бүс нутагтаа өрсөлдөхүйц хэмжээний “судалгааны их сургууль” болно гэж тодорхойлсон. Нөгөөтэйгүүр сүүлийн үед нийгэмд дээд боловсролын салбарт шүүмжлэлтэй хандах өнгө аяс нэмэгдсэн. Ажил олгогчдын зүгээс ч бидний бэлтгэн гаргаж буй боловсон хүчний чадварт сэтгэл хангалуун бус байгаа нь ажиглагдах боллоо. Үнэндээ бид асуудлаа “шилжилтийн үе”-тэй холбон тайлбарлаж, өөрсдөөсөө зайлуулан, аргалсаар ирсэн талтай. Энэ нь үнэний ортой байж болох хэдий ч дээд боловсролын салбарыг үнэгүйдүүлж, зарим талаараа оршин тогтнохын төлөө чанараас илүү тооны хойноос хөөцөлдөхөд хүрсэн байсныг бид хүлээн зөвшөөрч байгаа билээ.

Үүнээс үүдэн дараах асуулт аяндаа гарч ирнэ. Бид монголдоо хэрэгтэй, гадаад харилцааны чиглэлийн боловсон хүчийг бэлтгэн гаргаж чадаж байна уу? “Бүтээгдэхүүн” маань чанар, агуулгын хувьд “бренд” байж чадаж байгаа бил үү? Бид арай явцуу хүрээнд мэдлэг бүтээж, чанараас илүү хэлбэр хөөх гээд байгаа юм биш биз? Бид суралцагчдынхаа хүсэл, тэмүүллийг хэр анхаарч, тэдний төлөө хэр үйлчилж чадаж байгаа вэ? Бид нийгмийн хариуцлагаа бүрэн ухамсарлаж байгаа бил үү?

“Чадаж байгаа” гэж хэлэх хүн байгаа байх. Зарим хүн “чадахгүй байна” гэх байх. Зарим талаар би ч бас эргэлзэж байгаа юм.

3.Бид хойшид юу хийх ёстой вэ.

Бид “дипломатууд”-ыг бэлдэж байгаа юм биш ээ. Харин бидний гол зорилго бол бидний бэлтгэн гаргаж байгаа боловсон хүчний дотроос жинхэнэ монгол дипломатч, стратеги төлөвлөгч, удирдагч болохуйц хүн нэгдсэн бодлого, системийн хүрээнд бэлтгэгдэж, тодорхой шат дамжлага, сорилтуудыг даван туулж, шилэгдэж, шалгарч гарах тэрхүү нөхцөл, боломжийг бүрдүүлэх, уг системийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох явдал юм. Төрийн албаны болон гадаад харилцаа, дипломат албаны ажилтан эзэмшсэн байх суурь чадвар, мэдлэг, дадлыг чанартай эзэмшүүлэх, тэрхүү сургалт судалгааны систем, агуулгад дээрх үзэл баримтлалд туссан түлхүүр үзэл санаа, үндсэн ойлголтууд шингэсэн байх нь зүй зохистой юм. Эдгээр тулгуур үзэл баримтлалд тулгуурласан, зөв зохистой системийг төлөвшүүлэхэд олон талын оролцоог хангаж, төр бас анхаарч байваас төрийн болон дипломат албанд хандах өнгөц хандлагыг сая үгүйсгэх боломжтой болно.

ОУХНУС дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хойшид дараах зүйлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Үүнд:

1.Бодлогын хувьд: Монгол улсын хөгжлийн чиг хандлагатай уялдаатай, ҮАБ, ГБУБ-ын тулгуур үзэл баримтлал, зарчимд тулгуурласан, залгамж чанартай, нээлттэй, тогтвортой, нийгмийн төлөө үүрэг хариуцлагатай байх, сургалт судалгаа цогц, уялдаатай, академик эрх чөлөөгөөр хангагдсан байх

2.Сургалтын хувьд: ҮАБҮБ, ГБУБ-ын тулгуур үзэл санааг сургалтын агуулгад цогц байдлаар шингээх, боловсон хүчнийг бэлтгэхдээ төрийн болон дипломат албаны ажилтанд тавих шаардлагыг зайлшгүй харгалзах, сургалтын үйл ажиллагаа хүн төвтэй, мэдлэгт суурилсан байх, хөтөлбөрийн агуулгад гадаадын мэргэжлийн сургуулиудын стандарт агуулга болон үндэсний эрх ашигт нийцсэн агуулгыг зөв тэнцэлтэйгээр багтаах, сургалтанд зэрэг цолтой ахмад дипломатууд оролцох боломжтой байх, мөн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн

дипломат орчуулагчийг бэлтгэн гаргах, хөтөлбөрийн агуулгыг томъёолох үйл ажиллагаанд мэргэжлийн оролцоог хангах

3.Судалгааны хувьд: Олон улсын харилцаа, удирдахуй, бодлогын чиглэлийн судалгааг ҮАБҮБ, ГБҮБ-ийн чиг хандлагатай уялдуулах, шинжлэх ухаанч, салбар дундын, нээлттэй болгон хөгжүүлэх,үндэсний эрх ашигт нийцсэн судалгааны хамтын ажиллагааг дэмжих, мөн түүнчлэн багшлах, судлаач боловсон хүчин мэргэжлийн, шилдэг байх гэж үзэж байна.

Монгол улс маань хөгжиж байгаа, бид цөөхүүлээ билээ. МУИС-ийн хуулийн сургуулийн төгсөгчид Монголын хуулийг авч явдаг шиг ОУХНУС-ийг төгсөгчид цааш нь боловсорч мэргэшээд Монголын гадаад харилцааг авч яваасай гэж хүсч байна. Тэр утгаараа энэ сургууль гадаад харилцаа, дипломат албаны болон Төрийн захиргаа, удирдлагын чиглэлийн мэргэшсэн сургууль болох ёстой. Ийм сургуулийг мэргэшсэн судлаач, эрдэмтэд, дипломатуудын хамтын хүчээр хөгжүүлж, бид хамтдаа авч явах ёстой юм. Эцэст нь энэ мэргэжлийн сургуулийг өрсөлдөхүйц түвшинд хөгжүүлэн бэхжүүлэхэд Та бүхний дэмжлэг хэрэгтэй, оролцоо чухал гэдгийг дахин тэмдэглэн хэлэхийг хүсч байна. Та бүхэнд баярлалаа.

Проф. С.Энхбаяр / МУИС, ОУХНУС-ийн багш/

Аливаа орчуулга түүний дотор дипломат баримт бичгийн орчуулга нь манай улсын гадаад бодлогын нүүр царай, бусад улс орон, олон улсын байгууллагатай харьцах гүүр болж байдгаараа бичлэг, найруулга, үг сонголт, хэлний хэм хэмжээ, мэдрэмж зэрэг үзүүлэлтүүдийг дээд зэргээр баримталж туйлын хариуцлагатай, чамбай ажиллахыг орчуулагчдаас шаарддаг. Харамсалтай нь өнөөдөр орчуулгад тэр дундаа, албан бичгийн орчуулгад ч алдсан нь оносноосоо ихдээд хэтийдээд байгаа нь ажиглагдаж байна.

Тухайлбал,Монгол улсын гадаад бодлогын тулгуур баримт бичиг болох Гадаад бодлогын үзэл баримтлалын англи орчуулгыг монгол эхтэй нь тулган харьцуулбаас орчуулгын ноцтой гэж үзэж болохоор алдаа нилээд байгааг нягталж

үзээд энэхүү товч илтгэлийг тус бага хурал дээр сонордуулах нь зүйтэй юм байна гэж би үзсэн юм.

Үзэл баримтлалын англи хувилбар11 нүүрээс бүрдэж байна. Энд 30 орчим алдаа байгаа нь нэг нүүрэнд гурван алдаа байна гэсэн үг бөгөөд ийм чухал баримт бичгийн хувьд энэ бол бага тоо биш. Энэ 30-аад алдаанд үг, үсгийн алдаа ороогүй. Ер нь ийм алдаа бараг байхгүй гэж болно, Англи хэлний дүрмийн алдаа ч цөөн байна. Үүнээс үзвэл англи хэлний мэдлэг харьцангуй сайтай хүмүүс орчуулжээ гэж үзэж болохоор.

Үзэл баримтлалын орчуулгын үндсэн алдаа нь үг буруу оноосон, сонгосон, мөн санаа болон бүхэл бүтэн өгүүлбэр хаяж орчуулсан алдаа байна. Энэ бол ноцтой бөгөөд харамсалтай зүйл. Өөрөөр хэлбэл, орчуулгын үнэн зөв байх үндсэн зарчмыг алдагдуулсан гэсэн үг. Манай орчуулагч, судлаачид дээр үеэс эх текст буюу бичвэрийн утгыг алдагдуулахгүй байх тал дээр ихээхэн анхаарч, үгэнд халдаж болно, утгад халдаж болохгүй гэж үзсээр ирсэн. Энэ санааг манай эрдэмтэн гүүш, орчуулагчид тэртээ дундат зуунд бүтээсэн “Мэргэд гарахын орон нэрт даяг оршвой” гэсэн толь бичигтээ хөндсөн байдаг. Тэрхүү алдарт бүтээлд орчуулгын үндсэн зарчим, арга барил, орчуулгын хувиргалтууд болон орчуулагчдад тавих шаардлага зэрэг орчуулгын онолын үндсэн асуудлуудыг авч үзсэн нь монголчуудын билиг оюуны арвин баялаг сантай байсныг гэрчлэх хөдлөшгүй баримт мөн.

Онолын энэ зарчим, арга барилыг дараа дараагийн үеийн орчуулагчид ч баримталж, чанартай чамбай орчуулга хийсээр ирсэн билээ. Утгыг хөндөхгүйгээр шаардлагатай газар ганц нэг үг орхих, нэмэх, солих зэрэг үгсийн сангийн хувиргалтууд хийдэг. Гэтэл энэхүү үзэл баримтлалын орчуулгаас харахад үг бус бүхэл санаа болон өгүүлбэр орхиж гэсэн тохиолдол нилээд байна. Эх текстэн дэх өгүүлбэрийн цаад утга санааг бүрэн гүйцэд ойлгоогүй, судалгаа хийлгүйгээр шууд барьж авч орчуулсан тал харагдаж байна. Үзэл баримтлалын орчуулгын алдааг цөөхөн жишээгээр авч үзье.

Гадаад бодлогын үзэл баримтлал нь оршил болон таван бүлгээс бүрдэж байна. Оршилд бүтэн санаа орхисон, оновчгүй үг сонгосон, дүрмийн зэрэг 3 төрлийн алдаа байна. Тухайлбал, хоёрдох догол мөрөнд байгаа

“In line with trends of advancing human society, in particular with requirements of economic and technological progress, the nations of the world are drawing closer together, and conditions for enhancing their relationship are taking shape.” гэсэн өгүүлбэрийн монгол орчуулгаас үзэхүл доогуур нь зурсан санаанууд англи хувилбарт тэр чигтээ хаягджээ.

“Хэдийгээр дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор, түүний дотор эдийн засаг, технологийн хөгжлийн шаардлагаар ойртож, харилцан уялдаа холбоогоо бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байгаа боловч улс орнуудын шашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж үндсэрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасахгүй байна.” гэж буулгажээ

Өөрөөр хэлбэл, өгүүлбэрт байгаа зөрчилдсөн санааг орхиж мөлийлгөсөн байна. Мөнхүү оршлын дөрөвдэх доголын

“The restructuring and reforming of the country's political, social and economic systems provide it with favorable conditions for conducting a foreign policy based on realism and according priority to its national interests.” гэсэн өгүүлбэр монгол эх дээрээ “Манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн байгууллын өөрчлөлт, шинэчлэлт улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах аятай боломж бүрдүүлж байна.” гэж байна. Энд “...бодит байдалд тулгуурласан гадаад бодлого” гэдгийг “...a foreign policy based on realism” гэж орчуулжээ. Аливаа “зм” үүд угтаа онол сургаал байдаг. Уг нь “based on reality” гэх байсан.

according priority to - энд дүрмийн алдаа байгаа нь according гэж үгийн ард “to” угтвар зайлшгүй шаардлагатай, гэтэл ард нь priority гээд бас to угтвар давхардахаар найрлага зүйн хувьд тохиромжгүй болох учир шууд given priority to гэж орчуулж болох байсан.

“Нийтлэг үндэслэл” гэсэн бүлэг 6 зүйлтэй бөгөөд 4 зүйлд нь алдаа байна.

Энэхүү бүлгийн 2-р зүйлд “Mongolia’s foreign policy objectives reside in ensuring its independence and sovereignty by following the trends of human society’s advancement, maintaining friendly relations with all countries, strengthening its position in the international community and forming with influential countries in the region and in the world a network of relationships based on the interdependence of political, economic and other interests.” гэсэн өгүүлбэрт...a network гэсэн шууд тусгагдахууныг forming гэсэн үйл үгийнх нь ард холбож with influential countries... гэсэн байц гишүүд араас нь үргэлжилж орох ёстой байсан. Өөрөөр хэлбэл, ... forming a network of relationships based on the interdependence of political, economic and other interests with influential countries in the region and in the world гэж найруулсан бол англи хэлний дүрэмд илүү нийцэх байлаа.

Энэ бүлгийн 3-р зүйлийн эцсийн “Гадаад орнууд дахь Монголын сонирхлыг улс төр эрх зүйн аргаар бататган хамгаална” гэсэн санааг мөн хаян орчуулжээ. “Mongolia’s interests in foreign countries shall be safeguarded by political and legal means” гэсэн байдлаар ч болов орчуулах ёстой байж.

6-р зүйлийн “Considerations of foreign relations shall be in political, economic, scientific, technological, cultural and humanitarian fields of foreign policy.” өгүүлбэрийн монгол хувилбар нь “Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл хүмүүнлэгийн хүрээний гадаад харилцааны бодлого дотроос улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна.” гэсэн байна. Дээрх хоёр өгүүлбэрийн утга хоорондоо дүйхгүй байна....” улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна.” гэсэн утга англи хувилбарт огтхон ч байхгүй байна. Энэхүү үзэл баримтлалыг монголоос англи руу, англиас монгол руу орчуулсны алин болохыг мөхөс би ойлгосонгүй.

“Монгол улсын гадаад улс төрийн бодлого” хэмээх 2-р бүлгийн 10-р зүйлд “олон улсын тавцанд” гэснийг “in the international arena” гэжээ. “arena” гэсэн үгийн өмнө “at” гэсэн угтвар хэрэглэдэг. “in”-ийн оронд ядаж “on” хэрэглэсэн бол дүрэмд ойр байх байсан. Энэ бол жижиг зүйл бишээ. Энэ бүлгийн 11-р зүйлд...Settling

pressing regional and international issues гэсэн хэсэг англи хэл гадарлах ямар ч хүнд оновчгүй, сонсголонгүй санагдах болов уу.

12-р зүйлийн “с”-д .. greater attention shall be given to Asia... гээд дараахан нь “е”-д мөн ...Particular attention will be given to.. гэсэн байна. Албан ёсны тогтсон ...Attention paid to...гэсэн хэллэг байгаа, ядаж attention drawn to...гэх мэтээр өөр хувилбар хэрэглэсэн бол найрлага зүй талдаа зохимжтой байх байсан. Ер нь орчуулгад ч, аливаа бичлэгт ч нэг өгүүлбэрт нэг үгийг 2-3 давтахаас зайлсхийдэг, мөн дараалсан өгүүлбэрүүд буюу ойролцоо өгүүлбэрүүдэд аль болох ижил утгатай өөр үг сонгож хэрэглэх нь аливаа бичлэгийн найрлагыг аятай болгодог бөгөөд бид ч оюутнуудтайгаа орчуулга хийх явцдаа энэ зарчмыг баримтлахыг хичээдэг.

“Эдийн засгийн гадаад харилцааны бодлого” 3-р бүлгийн 20-р зүйлийн 1 буюу а зүйлийн “Foreign economic activities should be focused on enhancing the country's potential, increasing export resources, developing economic infrastructure and producing import substituting goods;” буюу “Эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг улс орны эдийн засгийн чадавхи, экспортын чиглэлийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх, эдийн засгийн дэд бүтцийг бүрэлдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;” гэсэн англи, монгол хоёр өгүүлбэрийг харьцуулахад монгол өгүүлбэрийн найрлага муу, англи дээр байгаа “эдийн засгийн гадаад үйл ажиллагааг хөгжүүлэхэд...зүйлд түлхүү анхаарна гэсэн санаа харагдахгүй, зэрэгцсэн адил гишүүн өгүүлбэрүүд мэтээр жагсаажээ.

20.3-ын “Pursuing the policy of modernizing existing industries by re-equipping them with advanced technology and techniques, and developing export-oriented industries such as food, light, mining and chemical industries as well as biotechnology and new products on the basis of raw materials available in the country”

“Одоо байгаа үйлдвэрүүдийг орчин үеийн шилдэг техник, технологиор шинэчлэн тоноглох, хүнс, хөнгөн үйлдвэр, уул уурхай, хими, биотехнологи, шинэ материалын зэрэг экспортын чиглэлтэй аж үйлдвэрийг өөрийн орны түүхий эдэд тулгуурлан хөгжүүлэх чиглэл баримтлах” Англи текстэнд “шинэ материалын” гэж ямар үйлдвэрийг өгүүлээ вэ?

“хүнс, хөнгөн үйлдвэр, уул уурхай, хими зэрэг экспортын чиглэлтэй үйлдвэр болон биотехнологи, өөрийн орны түүхий эдэд тулгуурласан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэсэн баймаар санагдана.

Шинжлэх ухаан, технологийн гадаад харилцааны бодлого гэсэн 4-р бүлгийн 231-д “Introducing advanced technology and methods into production and services. In doing so, priority will be given to the selective introduction of research-intensive technology...” “Үйлдвэрлэл, үйлчилгээнд дэвшилт арга технологи нэвтрүүлэх. Чингэхдээ оюуны их багтаамжтай технологийг сонгон нэвтрүүлэхийг эрхэмлэх.” гэсэн хоёр өгүүлбэрийн доогуур нь зурсан хэсгийн орчуулга хоорондоо хэрхэвч дүйгээгүй санагдана. Оюуны их багтаамжтай гэдэг нь тогтсон нэр томъёо юм болов уу, эрчимтэй судалгаа бүхий технологи гэсэн шиг л буумаар снагдах юм.

“Соёл хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого” 5-р бүлгийн 24-д “recovering cultural and art relics from abroad” гэсэн санааг “хальж гарсан зүйлийг сурвалжлан олох...” гэж бүдүүвчлэн орчуулснаас гадна хальж гарсан зүйл гэдэг нь оновчгүй болжээ. Мөн энэ зүйлийн монгол хувилбарт байгаа “улс түмнийг танин мэдэх” гэсэн санаа англи өгүүлбэрт алга байна.

26.1-д “Safeguarding the rights, freedoms, legitimate interests and the security of Mongolian citizens residing or traveling abroad through the promotion of broad cooperation with foreign countries in the legal sphere” “Гадаад орнуудтай эрх зүйн өргөн хамтын ажиллагаа хөгжүүлж, гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхол, аюулгүй байдлыг хамгаалах” гэсэн өгүүлбэрүүдийн орчуулгыг харьцуулахад монгол өгүүлбэрийн найрлага сулаас гадна зөвхөн гадаадад оршин суугаа төдийгүй гадаад орноор жуулчлан яваа иргэдийн гэсэн чухал санааг орхигдуулжээ. Зүй нь “Гадаад орнуудтай эрх зүйн хүрээнд /эсвэл салбарт/ өргөн хамтын ажиллагаа хөгжүүлэх замаар гадаадад оршин суугаа буюу аялан яваа Монгол Улсын иргэдийн...” гэж буулгасан бол англи эхийн санаа бүрэн утгаараа буух байсан болов уу.

26.4-ийн “Giving priority to training in developed countries of Mongolian students, managerial personnel and specialists in the field of market economy, politics, law,

management and marketing as well as in the leading areas of the country's scientific and technological fields..."өгүүлбэрийн доогуур нь зурсан хэсэг, тодруулбал, ...in developed countries гэсэн нийлэмж үг огт байраа олоогүй ажээ. Энэхүү үзэл баримтлалыг монголоос англи, англиас монгол руу орчуулсны алин болох нь ойлгомжгүй байгааг өөрийн эрхгүй дахин дурдмаар.

Дараагийн өгүүлбэр нь "In doing so, Mongolia shall seek to benefit from specialized funds of international organizations and developed countries, scholarships гэж байгаа бөгөөд доогуур нь зурсан хэсгийг "олон улсын тусгай болон хөгжингүй орны төрөлжсөн сан..." хэмээн хөрвүүлснийг юү гэж ойлгох вэ. "...олон улсын байгууллага болоод хөгжингүй орнуудын төрөлжсөн сан" гэхэд л болох биш үү?

Дүгнэлт:

- Энэхүү орчуулгад ерөнхийдөө үгийн оноолт оновчгүй, хоёр хэлний хэл зүй, өгүүлбэр зүй, найруулга зүй болон ерөнхий хэм хэмжээг ер харгалзан үзээгүй, дөхүүлсхийж оромдсон байдал ажиглагдаж байна.

- Орчуулгын онолын үндсэн зарчмыг алдагдуулж чухал чухал санааг орчуулахаас зайлсхийсан буюу хайхрамжгүй хандсаны алин болох нь тодорхойгүйгээр орхижээ.

- Орчуулгын онолын мэдлэг болон дадлага туршлага муутай улс орчуулжээ гэсэн сэтгэгдэл төрж байна.

Эцэст нь: Энэхүү орчуулгад анализ хийж, харьцуулж үзэхдээ бусдын хийсэн ажлыг үгүйсгэж өөлөх гэсэнгүй, цааш цаашдын орчуулгад хариуцлагатай, ул суурьтай хандаж сайжруулаасай гэсэн санаа өвөрлөж буйгаа цохон тэмдэглэе.

Л.Галбадрах /Хурлын хөтөч/

Өнөөдрийн бага хуралд хавсралт илтгэлийн хэлбэрээр үг хэлэх болон санал бодлоо илэрхийлэхээр нэрсээ өгсөн хүмүүс бүгд үг хэлж дууслаа.Төлөвлөсөн цагаасаа бараг нэг цагаар илүү хуралдлаа. Хүмүүс ч маш идэвхтэй оролцлоо. Хурлыг хөтлөн явуулах үүрэг хүлээсний хувьд би Та бүхэнд чин сэтгэлийн

талархлаа дахин илэрхийлье. Та бүхний хэлсэн үгэнд манай гадаад бодлогын үндсэн чиглэл, асуудлууд тусгалаа олсон төдийгүй цаашдын бодлого, үйл ажиллагааны чиг баримжаа болохуйц санал ч гарлаа. Анхаарч бодууштай асуудлууд, бүр засч залруулмаар зүйлүүд ч нэлээд байгаа нь ажиглагдаж байна. Эсрэгцсэн, зэрэгцсэн санаа, дүгнэлтүүд ч яригдлаа. Энэ бүхэн бол манай өнөөдрийн онол, практикийн бага хурал зорилгоо биелүүлж чадсаныг харуулж байна.

Та бүхний тавьсан илтгэл, хэлсэн үг, дэвшүүлсэн санаа хийгээд шүүмжлэлтэй зүйлүүдийг огтхон ч орхигдуулалгүйгээр эмхэтгэн бэлтгэж ном болгон хэвлүүлэх болно. Чингээд бага хурлын ажиллагааг хааж үг хэлнэ үү хэмээн Др. Х.Бэхбатыг урьж байна.

**“ГБҮБ- 20 жил” сэдэвт бага хурлыг хааж Дипломат Академийн захирал,
Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд, ОББЭЭС, Др. Х.Бэхбатын хэлсэн үг**

Хаалтын үг гэж тусгайлан бэлдсэн юм байхгүй. Байх ч учиргүй. Яагаад гэвэл өнөөдрийн бидний яриа хөөрөө, санал солилцох үйл явц хийгээд магадгүй өрнөх мэтгэлцээний шинж байдал, бүр гүнзгийрүүлбэл үр дүн гэж болохоор зүйлийг би урьдаас таах аргагүй байсан хэрэг. Гэхдээ бага хурал маань ингээд өндөрлөж байгаа учир эцэст нь хэлмээр зүйл байна аа. Эхлээд хувийн шинж чанартай зарим санаа оноогоо хэлмээр байна. Ерөнхийдөө бидний өнөөдрийн яриа, хэлэлцүүлгийн явцад нэлээн тодорхой цухалзаад байгаа нэг санаатай холбогдуулаад хэдэн үг хэлье гэж санасан юм.

Аливаа үзэл баримтлал буюу концепци гэдэг маань ер нь өөрийн гэсэн үндэслэлтэй байх ёстой. Утга агуулга, хэлбэрийн хувьд 2 үндсэн, эсрэг тэсрэг юм шиг мөртлөө хоорондоо нягт холбоотой шаардлагад үндэслэх ёстой байх. Нэг нь positive буюу descriptive, өөрөөр хэлбэл зураглан дүрсэлсэн, нөгөө нь normative буюу prescriptive, өөрөөр хэлбэл хэм хэмжээ тогтоосон, ийм үндсэн 2 шаардлагын дагуу авч үзэх учиртай байх аа.

Энэ утгаар манай үзэл баримтлалыг авч үзэх юм бол, хэдийгээр энэ 2 шаардлага хосолсон ч гэсэн норматив, хэм хэмжээ тогтоосон тал нь арай түлхүү

байдаг юм. Өөрөөр хэлбэл үг үсэг, томъёоллыг нь аваад үзэхээр “тэгнэ”, “тиймээс тэгнэ” гэх буюу тэгэх хэрэгтэй гэсэн утгаар байж байгаа. “Тэгж болно” “тэгж ч болох юм” “үгүй ч байж болно” гэсэн үг үсэг, ойлголт бараг байхгүй. Тэгээд ч энэ баримт бичиг өөрөө парламентаар буюу хууль тогтоох дээд байгууллагаар батлагдаж, төр, олон түмний баримтлах, хэрэгжүүлэх үзэл баримтлал, төрийн бодлого болж хувирсан байна. Тэгэхлээр илүү ерөнхий байх ёстой, шалгаад, үнэлээд дүгнээд байх механизм хэрэггүй, тийм шаардлага байхгүй гэж үзэх нь нэлээн учир дутагдалтай гэж хэлмээр байна.

Үнэхээр ийм юм баримжаална, баримтална гэсэн л бол баримжаалж, баримталж байна уу, үгүй юу гэдгийг үнэлж, дүгнэх шаардлага нь угаасаа л хамт байна шүү дээ. Бид юуг нь баримтлаад, юу хийсэн, алийг нь баримтлаагүй, хийгээгүй байна вэ гэдгийг харж, үзэж, дүгнэх бололцоо нь өгөгдмөл байх ёстой. Тийм үнэлэлт дүгнэлт хийж байдаг механизм нь ч ямар нэг хэмжээгээр байх ёстой. Тэгэхдээ тэр механизм нь харин ажилладаг байх ёстой.

Механизм нь байсан ч гэсэн ажиллуулахгүй байна уу гэдэг асуудал бол өөр түвшний асуудал юм гэж хэлмээр байна. Өөрөөр хэлбэл, норматив тал нь түлхүү байгаа учраас үүнд мониторинг хийдэг, дүгнэдэг, болохгүй байгаа юмыг нь засах гэж оролддог механизм заавал байх ёстой юм гэдгийг би өөрийн, хувийн зүгээс хэлмээр санагдсан юм.

Манай өнөөдрийн энэ онол, практикийн гэж нэрлээд байгаа бага хуралд олон хүн оролцлоо. Манай улс төрчид ч оролцлоо, мэргэжлийн дипломатууд, ахмад болон залуу үеийн төлөөлөл ч оролцлоо. Бас эрдэмтэн мэргэд, судлаачид оролцлоо. Нийтдээ 20 гаруй хүн тодорхой зүйл хөндөн ярьж, олон сайхан санаа дэвшүүллээ. Энэ маань их олзуурхууштай зүйл. Өөрөөр хэлбэл зарим хүмүүсийн хэлж байсанчлан ийм үйл явдал, ийм бага хурал сүүлийн үед “дутагдаад байсан” юм. Энэ “дутагдаад байсан” гэх ойлголт төрнө гэдэг маань өөрөө тодорхой үр дүн. Ийм үр дүнтэй болж байгаад би хувьдаа баяртай байна.

Хурлыг эцэст нь заавал дүгнэж хэлэх ёстой гэвэл би үндсэндээ 4 зүйлээр, 4 багц чиглэлээр дүгнэж хэлж болох юм гэж бодож байна.

Нэгдүгээрт, ГБУБ бол өөрөө түүхэн чухал ач холбогдолтой баримт бичиг болсон юм. Энэ бол Монгол улсын гадаад бодлого, Монгол улсын гадаад харилцааны хувьд том ололт, ахиц байсан гэж хүн бүхэн санал нэгтгэйгээр үнэлж, дүгнэж байна. Үүний зэрэгцээ энэ бол өмнөө түүхтэй, хувьсаж өөрчлөгдөж яваа, процессын асуудал юм. Өөрөөр хэлбэл, энэ баримт бичиг маань зогсонги юм биш, хувьсаж өөрчлөгдөж байгаа, амьд процесс юм байна. Энэ баримт бичиг цаашдаа ч хувьсаж, өөрчлөгдөж болно, энэ бол нээлттэй асуудал юм гэсэн ойлголт нийтлэг байна.

Хоёрдугаарт, Ерөнхийдөө баримтлал буюу баримжаа гэсэн ойлголт нь илүү буюу түлхүү байх ёстой. Их тодорхой байх тусмаа ороогддог гэдэг нь яриа байхгүй үнэн. Тийм учраас хэрэвзээ ойрын ирээдүйд эргэн харах шаардлагатай болбол энэ чиглэл рүү түлхүү анхаарах хэрэгтэй гэсэн ийм сэтгэгдэл аяндаа гарч ирж байна.

Ер бол засч залруулах юм байна. Харин засч залруулна гэвэл үнэлж дүгнэх, мониторинг хийх механизмын тухай асуудал хамт яригдах ёстой. Манайд дунд бөгөөд удаан хугацаанд мониторинг хийж, бие даасан үнэлэлт, дүгнэлт өгч, судалгааны продукт гаргах ажил маш муу. Холбогдох байгууллагууд гэвэл эдгээр нь өөрийгөө цагаатгах, зөвтгөх, өмөөрөх реакцтай байдаг. Тийм учраас тайлан гэх мэт нь дандаа “бүх юм болж байна, мундаг байна” гэсэн үнэлгээтэй гардаг. Иймд бие даасан үнэлгээ, судалгаа хийж байдаг чадавхийг улсын хэмжээнд бий болгон бэхжүүлэх асуудал их чухал юм гэсэн дүгнэлт гарч байна.

Цаашилбал, бодлогын үр ашгийн асуудал, нэгдсэн бодлого, нэгдсэн бодлогын зохицуулалт дутагдаж байна. Энэ хүрээнд Гадаад яамны буурч байгаа үүрэг ролийг сэргээж, өндөржүүлж, бэхжүүлэх шаардлагатай байна. Үүний гол арга нь боловсон хүчний чадавхийг өсгөх тухай асуудал юм. Үүнийг 2 замаар өсгөнө. Нэг нь механик буюу орон тоо нэмэх арга. Нөгөөх нь чанаржуулах буюу сургалт явуулах, давтан сургалт явуулах аргаар чадавхийг нь өсгөх явдал юм. Өөрөөр хэлбэл, орчин үеийн маш хурдан өөрчлөгдөж байгаа нөхцөл байдлыг эзэмдэх тэр чадварыг суулгаж, байнга тэтгэж байх тухай асуудал юм гэж ойлгоцгоож байна.

Сүүлчийн нэг дүгнэлтийг хэлмээр байна. Монгол улсын хэмжээнд гадаад харилцаа, гадаад бодлогын коммюнити байх ёстой. Байгаа гэхэд тэр маань их тархай бутархай байна. Бакалаврын боловсрол олгодог сургуулиасаа эхлээд судалдаг, шинжилдэг тинк танк хэд байна вэ? Гадаад яамны сургадаг, судалдаг чадвар чансаа хэр байна вэ? гэх зэргээр аваад үзэх юм бол ерөөсөө хоорондоо уялдаа, холбоо, хамаарал, хамтын ажиллагаа, хамтран ажиллах процесс маш муу байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын маань гадаад бодлогын сэтгэлгээний чадавх учир дутагдалтай, үүнийг хөгжүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай байна. Тэгэхээр гадаад бодлогод оролцогч бүгдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй. Тэр үндсэн дээр чанар маань бүхэлдээ сайжрах юм гэсэн дүгнэлт гарч байна. Тийм учраас яриа хэлэлцүүлэг, онол практикийн хурал, семинар, иймэрхүү зүйлийг аль болох олшруулах, тогтмолжуулах, оролцогч бүгдийн харилцан үйлчлэлийг сайжруулах, гүнзгийрүүлэх шаардлагатай байна гэсэн ийм дүгнэлт гарч байна гэж ойлгож байна. Өнөөдрийн арга хэмжээг нээх үед дурдсанчлан энэ удаагийн хурал маань баярын хурал биш. Бодох, сэтгэх, хуваалцах, ийм хурал. Онол практикийн шинжтэй. Тэр утгаараа манай хурал үр дүнтэй боллоо гэдгийг эцэст нь дахиад хэлье.


Хурлыг үр дүнтэй болгоход оролцсон бүх хүмүүст, энэ танхимд байгаа та нартаа Академийнхаа болон ГХЯ-ныхаа нэрийн өмнөөс талархал дэвшүүлж, сайн сайхныг хүсэн ерөөе!

ҮНДЭСНИЙ ТАГНУУЛЫН АКАДЕМИЙН ТАГНУУЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН СУДАЛГАА


Үндэсний тагнуулын Академи (ҮТА)-ийн Тагнуул судлалын төвөөс уламжлал болгон зохион явуулдаг “Үндэсний аюулгүй байдал ба гадаад бодлого” сэдэвт социологийн судалгааг 2014 оны 3 дугаар сард Улаанбаатар хот, Замын-Үүд болон 21 аймгийн иргэдийн дунд явуулав. Судалгааг иргэдийн дунд санал асуулгын хуудас тарааж, шууд бөглүүлэх хэлбэрээр зохион байгуулсан. Улаанбаатарт санал асуулгын 115, дурдсан аймаг бүрт дунджаар 50, нийт 1180 хуудсыг нийгмийн бүх бүлгийн төлөөлөл болохуйц иргэдийн дунд тарааж, саналыг авсан болно.

Судалгаанд оролцогчдыг нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл:


Судалгаанд оролцогчдын нас




Хүйсийн байдал



Боловсролын түвшин



Ажил эрхлэлтийн байдал



Нэг. “Үндэсний аюулгүй байдал ба гадаад

бодлого” судалгааны дүн

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох гадаад хүчин зүйлийг нэрлэнэ үү?

Хариултын	Тоо	Хувь
1. даяаршил	153	13

2. том гүрнүүдийн нөлөө	448	39
3. нэг улсаас хараат байдалд орох	484	42
4. бусад	69	6

2. Монгол Улсад хүнсний аюулгүй байдал хэр хангагдсан гэж Та үздэг вэ?

1. хангагдсан	34	3
2. шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа	530	45
3. хангагдаагүй	575	49
4. мэдэхгүй	36	3

3. Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд төрөөс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

1. үндэсний хэмжээний лаборатори байгуулах	185	16
2. улсын хилийн боомтуудад лаборатори байгуулах	298	25
3. импортын бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх	672	57
4. бусад	23	2

4. Манай улсад иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал хэр хангагдсан бэ?

1. сайн	108	9
2. дунд	648	55

3. муу	348	30
4. мэдэхгүй	70	6

5. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал хэр баталгаатай байна гэж Та үздэг вэ?

1. бүрэн хангагдсан	25	2
2. баталгаа муутай	745	64
3. хангагдаагүй	334	28
4. мэдэхгүй	70	6

6. Экологийн аюулгүй байдал Таны оршин суугаа нутагт ямар байна вэ?

1. маш хүнд байдалд орсон	145	12
2. муудаж байна	784	67
3. хэвийн	238	20
4. сайн	10	1

7. Хүн амын удмын сангийн аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулж буй хүчин зүйлийг нэрлэнэ үү?

1. агаарын бохирдол	350	30
2. хүнсний аюулгүй байдал	483	41
3. хүний наймаа	87	7
4. хар тамхи, мансууруулах бодис	105	9

5. цус ойртолт	123	10
6. бусад	30	3

8. Хэрвээ Та гадаадын тусгай албаны үйл ажиллагаанд өртвөл хаана хандах вэ?

1. Тагнуулын ерөнхий газарт	683	59
2. Цагдаагийн ерөнхий газарт	402	35
3. Хил хамгаалах ерөнхий газарт	51	4
4. Гаалийн ерөнхий газарт	21	2

9. Гадны шашны урсгалууд манай улсын аюулгүй байдалд хэр нөлөөлөх вэ?

1. нөлөө ихтэй	375	32
2. зохих нөлөөтэй	559	48
3. төдийлэн нөлөөлөхгүй	134	11
4. мэдэхгүй	106	9

10. Монголын ард түмний эв нэгдэлд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. хэт намчирхах	500	42
2. баян хоосны ялгаа	187	16

3. шударга бус байдал	350	30
4. нутгархах үзэл	56	5
5. шашин	61	5
6. бусад	26	2

11. Үндэсний аюулгүй байдлыг хангахад шинээр ямар төмөр зам тавих нь ашигтай вэ?

1. өргөн	284	24
2. нарийн	128	11
3. аль алийг нь	358	31
4. мэдэхгүй	396	34

12. Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэн Таны оролцоо ямар байх ёстой вэ?

1. чухал	957	84
2. төдийлэн хамаагүй	78	7
3. шаардлагагүй	26	2
4. мэдэхгүй	85	7

13. Төрийн албан хаагчид болон иргэдэд үндэсний аюулгүй байдлын онол практикийн асуудлаар сургалт явуулах шаардлагатай эсэх?

1. зайлшгүй шаардлагатай	456	39
--------------------------	-----	----

2. шаардлагатай	595	51
3. шаардлагагүй	45	4
4. хамгийн зөв бодлого	73	6

14. Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг Та хэрхэн үздэг вэ?

1. маш зөв бодлого	130	11
2. зөв	508	45
3. шүүмжлэлтэй ханддаг	442	39
4. буруу	54	5

15. Гуравдагч хөршийн бодлогыг Та хэрхэн үздэг вэ?

1. маш зөв бодлого	230	21
2. аль нэг улсыг тусгайлан нэрлэх нь зохимжгүй	712	63
3. манай улсад ашиггүй бодлого	181	16

16. Гадаад харилцааг “эдийн засагжуулах” нь чухал эсэх?

1. улс орны хөгжилд хэрэгтэй бодлого	395	34
2. хэт эдийн засагжуулах шаардлагагүй	325	28
3. туйлширсан бодлого	156	14
4. мэдэхгүй	280	24

17. Монгол Улсад гадаадаас учирч болох аюул занал?

1. терроризм	132	11
2. шашны нөлөө	313	27
3. хүний наймаа	432	38
4. тусгай албадын ажиллагаа	170	15
5. бусад	100	9

18. Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад элсэх шаардлагатай юу?

1. даруй элсэх шаардлагатай	108	9
2. ажиглагч хэвээрээ байх	405	35
3. шаардлагагүй	202	17
4. мэдэхгүй	450	39

19. Манай улсад аль орны нөлөө хамгийн их байна вэ?

1. ОХУ	120	10
2. Хятад	878	75
3. АНУ	54	5
4. Япон	21	2
5. Солонгос	5	7
6. Европын холбоо	10	1

20. Гадаадын зээл тусламж авах талаар Таны бодол?

1. их хэмжээгээр авах шаардлагатай	36	3
2. тооцоо, судалгаатай хандах	764	66
3. аль болох авахгүй байх нь зөв	353	31

21. Монгол Улсын иргэд олноороо гадаадад гарч байгааг Та хэрхэн үздэг вэ?

1. чөлөөтэй гарах нь зөв	253	22
2. хязгаарлах шаардлагатай	373	32
3. үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй	431	38
4. мэдэхгүй	92	8

22. Гадаадад буй манай иргэдийн аюулгүй байдал хэр баталгаатай гэж Та үздэг вэ?

1. ямар ч баталгаа байхгүй	659	57
2. гадаадад буй ДТГ анхаардаг	118	10
3. тагнуулын байгууллага анхаарах ёстой	208	18
4. мэдэхгүй	167	15

23. ОХУ, Монгол Улсын иргэд харилцан визгүй зорчих асуудлыг Та хэрхэн үздэг вэ?

1. маш зөв	173	15
2. зөв	469	41
3. буруу	337	29
4. мэдэхгүй	174	15

24. БНХАУ-ын иргэд манай улсад визгүй зорчих асуудлыг Та хэрхэн үзэх вэ?

1. визтэй зорчдог хэвээр байх нь зөв	448	39
2. визгүй байж болох	119	10
3. визгүй байж хэзээ ч болохгүй	510	44
4. мэдэхгүй	78	7

25. Гадаадад ажиллах хүч гаргах нь хэр оновчтой гэж Та үздэг вэ?

1. зөв	85	7
2. буруу	271	24
3. зохион байгуулалттай байх ёстой	742	64
4. мэдэхгүй	56	5

26. Гадаадаас ажиллах хүч авах нь хэр оновчтой гэж Та үздэг вэ?

1. зөв	46	4
--------	----	---

2. буруу	493	43
3. зохион байгуулалттай байх ёстой	557	48
4. мэдэхгүй	57	5

Хоёр. 2012, 2014 оны социологийн судалгааны

харьцуулсан дүгнэлт

1. Судалгаанд оролцогчдын 81 хувь нь “том гүрнүүдийн нөлөө” болон “нэг улсаас хараат байдалд орох”-ыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох гадаад хүчин зүйлээр нэрлэжээ. **Энэ хоёр хүчин зүйл тус бүрдээ 2012 оныхоос өссөн ба иргэдийн 13 хувь нь “даяаршил”-ыг өөр нэг хүчин зүйлээр нэрлэжээ.**
2. Монгол Улсад хүнсний аюулгүй байдал “хангагдсан” гэж санал асуулгад оролцсон иргэдийн 3 хувь нь үзжээ. Үүний цаана “хангагдаагүй”, “шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа” гэж үзэх иргэд 94 хувь байна. **Эдгээр тоо баримтаас манай улсын хүнсний аюулгүй байдал болоод хүний аюулгүй байдалд бодит аюул, занал тулгараад байна гэж дүгнэхээр байна.**
3. Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд “импортын бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх” хэрэгтэй байна гэж судалгаанд оролцогчдын 57, “улсын хилийн боомтуудад болон үндэсний хэмжээний лаборатори байгуулах” шаардлагатай гэж 41 хувь нь үзжээ. **Иймд, эдгээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлбэл манай орны хүнсний аюулгүй байдлыг хангахад тустайг судалгаанд оролцогчид бүрэн дэмжэв.**
4. Манай улсад иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал “муу” хангагдсан гэж үзэх иргэдийн тоо 2012 оныхоос 6 хувиар буурч, “сайн” хангагдсан гэж үзэх иргэдийн тоо 3 хувиар өсчээ. **Гэвч иргэдийн дийлэнх нь буюу 55 хувь нь “дунд” зэрэг хангагдсан гэж үзсэн хэвээр байна.**

5. Судалгаанд оролцсон иргэдийн 64 хувь нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал “баталгаа муутай”, 28 хувь нь “хангагдаагүй” гэж хариулжээ. **Үүнээс үзэхэд иргэдийн 92 хувь нь эдийн засгийн аюулгүй байдлын баталгаа муу байна гэж дүгнэсэн байна.**
6. Экологийн аюулгүй байдлыг өөрийн оршин суугаа нутагтаа “муудаж байна” гэж санал асуулгад оролцогч иргэдийн 67, “хэвийн байна” гэж 20, “маш хүнд байдалд орсон” гэж 12 хувь нь үзжээ. **Экологийн аюулгүй байдал муудаж байна гэж үзэх иргэдийн тоо 2012 оныхоос бага зэрэг өсч маш хүнд байдалд орсон гэх иргэдийн тоо бага зэрэг буурчээ.**
7. **Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 71 хувь нь “хүнсний аюулгүй байдал” болон “агаарын бохирдол”-ыг хүн амын удмын сангийн аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулж буй хүчин зүйлээр нэрлэжээ.** Мөн иргэд “цус ойртолт”, “хар тамхи, мансууруулах бодис”-ыг зохих нөлөөтэй гэсэн байр суурьтай байгаа аж.
8. Хэрэв гадаадын тусгай албаны үйл ажиллагаанд өртвөл судалгаанд оролцогчдын 59 хувь нь “Тагнуулын ерөнхий газарт”, 35 хувь нь “Цагдаагийн ерөнхий газарт” хандах аж. **Үүнээс үзэхэд манай улсын иргэдийн олонх нь гадаадын тусгай албаны үйл ажиллагаанд өртвөл хаана хандахаа ухамсарлаж байгаа гэж дүгнэж болохоор байна.**
9. Гадны шашны урсгалууд манай улсын аюулгүй байдалд “зохих нөлөөтэй” гэж судалгаанд оролцогчдын 48, “нөлөө ихтэй” гэж 32 хувь нь хариулжээ. **Эдгээр хариултуудад санал өгсөн иргэдийн тоо 2012 оныхоос 4 хувиар нэмэгдсэн нь гадны шашны сөрөг нөлөө нэмэгдэж байгааг харуулж байна.**
10. Иргэдийн 42 хувь нь Монголын ард түмний эв нэгдэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлээр “хэт намчирхах”-ыг, 30 хувь нь “шударга бус байдал”-ыг, 16 хувь нь “баян хоосны ялгаа”-г нэрлэжээ. **Ард иргэдийн хэт намчирхаж байгаа нь манай ард түмний эв нэгдэлд сөрөг нөлөөтэй гэж үзэх иргэдийн тоо 2012 оныхоос 10 хувиар өсчээ.**

11. Үндэсний аюулгүй байдлыг хангахад шинээр “өргөн” төмөр замыг тавих нь ашигтай гэж иргэдийн 24 хувь нь, “нарийн” гэж 11 хувь нь, “аль алийг нь” гэж 31 хувь нь үзжээ. **Үүнээс харахад манай улсад шинээр ямар төмөр зам тавих нь ашигтай талаар иргэд нэгдсэн ойлголт, төсөөлөл байхгүй байна.**
12. Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэний оролцоо “чухал” гэж судалгаанд оролцогчдын 84 хувь нь үзсэн ба 2012 оныхоос даруй 12 хувиар өсчээ. **Монгол Улсын аюулгүй байдлыг хангах нэг чухал хүчин зүйл нь иргэдийн үүрэг, оролцоо гэдгийг манай иргэд сайтар ухамсарлаж байгаа нь тус судалгааны дүнгээс харагдлаа.**
13. Төрийн албан хаагчид болон иргэдэд үндэсний аюулгүй байдлын талаар онол, практикийн сургалт явуулах “шаардлагатай” гэж иргэдийн 51, “зайлшгүй шаардлагатай” гэж 39 хувь нь хариулжээ. **Үүнээс харахад иргэдийн 90 хувь нь дээрх асуудлаар иргэд, төрийн албан хаагчдад сургалт явуулахыг дэмжсэн байр суурьтай байна.**
14. Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг “зөв” гэж судалгаанд оролцогчдын 45, “шүүмжлэлтэй ханддаг” гэж 39 хувь нь үзжээ. **Энэ асуудалд иргэд хуваагдмал байр суурьтай байна гэж дүгнэж болохоор байна.**
15. Гуравдагч хөршийн бодлогын талаар иргэдийн 63 хувь нь “аль нэг улсыг тусгайлан нэрлэх нь зохимжгүй”, 21 хувь нь “маш зөв бодлого”, 16 хувь нь “манай улсад ашиггүй бодлого” гэж хариулжээ. **Эндээс манай иргэд гуравдагч хөршийн бодлогыг дэмжиж байгаа ч зарим улсыг тусгайлан нэрлэсэн явдалд шүүмжлэлтэй ханддаг нь ажиглагдлаа.**
16. Гадаад харилцааг “эдийн засагжуулах” талаар судалгаанд оролцогч иргэдийн 34 хувь нь “улс орны хөгжилд хэрэгтэй бодлого”, 28 хувь нь “хэт эдийн засагжуулах шаардлагагүй”, 14 хувь нь “туйлширсан бодлого” гэсэн байр суурьтай байна. **Энэ асуудлаар мөн манай иргэд нэгдсэн байр суурьгүй байна гэж дүгнэж болохоор байна.**

17. Монгол Улсад учирч болох аюул заналын талаар судалгаанд оролцогчдын 38 хувь нь “хүний наймаа”, 27 хувь нь “шашны нөлөө”, 15 хувь нь “тусгай албадын ажиллагаа”, 11 хувь нь “терроризм”-ийг нэрлэжээ. **Хүний наймаа, терроризм гэж хариулах иргэдийн тоо тус бүр 4 хувиар буурч, шашны нөлөөний аюул занал ихэсч байна гэж үзэх иргэдийн тоо 7 хувиар өсчээ.**
18. Монгол Улсын Шанхайн хамтын ажиллагааны байгууллага дахь статусын тухайд санал асуулгад оролцогчдын 35 хувь нь “ажиглагч хэвээр байх”, 39 хувь “мэдэхгүй” гэж хариулжээ. **Үүнээс харахад иргэд энэ асуудалд төдийлэн ойлголт муу, хойрго хандах байдал ажиглагдаж байна.**
19. Манай улсад Хятадын нөлөө хамгийн их байна гэж үзэх иргэдийн тоо 9 хувиар өсч 75 хувьд хүрчээ. Харин 10 хувь нь ОХУ, 7 хувь нь Солонгос гэсэн хариултыг өгсөн байна.
20. Гадаадаас авах зээл тусламжид “тооцоо, судалгаатай хандах” хэрэгтэй гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 66 хувь нь үзжээ. Мөн “аль болох авахгүй байх нь зөв” гэж 31 хувь нь хариулсан байна.
21. Монгол Улсын иргэд олноороо гадаадад гарах нь “үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй” гэж судалгаанд оролцогчдын 38, “Хязгаарлах шаардлагатай” гэж 32, “чөлөөтэй гарах нь зөв” гэж 22 хувь нь үзсэн байна. **Үүнээс үзэхэд иргэдийн 70 хувь нь манай иргэд олноороо гадаадад гарч байгаагийн эсрэг байр суурьтай байна.**
22. Гадаадад буй манай иргэдийн аюулгүй байдалд “ямар ч баталгаа байхгүй” гэж үзэх иргэдийн тоо 2012 оныхоос 31 хувиар өсч 57 хувь болжээ. Мөн “тагнуулын байгууллага анхаарах ёстой” гэж иргэдийн 18, “гадаадад буй ДТГ анхаардаг” гэж 10 хувь нь хариулжээ.
23. ОХУ, Монгол Улсын иргэд харилцан визгүй зорчих асуудлыг “маш зөв” гэж санал асуулгад оролцогчдын 15, “зөв” гэж 41, “буруу” гэж 29 хувь нь үзсэн байна. **Эндээс харахад харилцан визгүй зорчих асуудлыг манай иргэд дэмжсэн хэвээр байна.**

24. БНХАУ-ын иргэд манай улсад визгүй зорчих асуудлыг “визгүй байж хэзээ ч болохгүй” гэж иргэдийн 44, “визтэй зорчдог хэвээр байх нь зөв” гэж 39 хувь нь үзэж байгаа юм. **Эндээс судалгаанд оролцогчдын 83 хувь нь Хятадын иргэд манай улсад визтэй зорчих хэрэгтэй гэсэн байр суурьтай байгаа нь харагдлаа.**
25. Гадаадад ажиллах хүч гаргах нь “зохион байгуулалттай байх ёстой” гэж судалгаанд оролцогч иргэдийн дийлэнх нь буюу 64 хувь нь хариулжээ. Харин “буруу” гэж 24, “зөв” гэж 7 хувь нь үзэж байна.
26. Гаднаас ажиллах хүч авах нь “зохион байгуулалттай байх ёстой” гэж иргэдийн 48, “буруу” гэж 43 хувь нь хариулжээ. **Иргэд энэ асуудалд шүүмжлэлтэй хандаж байгаа ч нэгдмэл байр суурьгүй байгаа нь санал асуулгын дүнгээс харагдаж байна.**

ҮНДЭСНИЙ ТАГНУУЛЫН АКАДЕМИ

ТАГНУУЛ СУДЛАЛЫН ТӨВ

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /1994/**

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш олон улсын харилцаанд ноёрхсон хүйтэн дайн дуусч, бие биенийгээ сөрөн зогссон хоёр туйлт ертөнцийн бүтэц задарч, олон улсын харилцааны шинэ тогтолцоо бүрэлдэх үйл явц бэхжиж байна.

Хэдийгээр дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор, түүний дотор эдийн засаг, технологийн хөгжлийн шаардлагаар ойртож, харилцан уялдаа холбоогоо бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байгаа боловч улс орнуудын шашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж үндсэрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасахгүй байна.

Дэлхийн социалист систем, Зөвлөлт Холбоот Улс задарсан нь түүний холбоотон байсан Монгол Улсын гадаад нөхцөл байдлыг эрс өөрчлөв. Эдүгээ хөрш хоёр оронд гарч буй томоохон өөрчлөлт нь Монгол Улсын гадаад орчинд шууд нөлөөлж байна.

Манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн байгууллын өөрчлөлт, шинэчлэлт улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах аятай боломж бүрдүүлж байна.

Гадаад, дотоод эдгээр хүчин зүйлийг үндэс болгон Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг тодорхойлж байна.

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөө, чөлөөт эдийн засгийг эрхэмлэсэн улс бөгөөд улс төр, газар зүйн хувьд Ази тивд хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, хөгжиж байгаа орон юм. Монгол Улсын гадаад бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд

Монгол Улсын гадаад, дотоод өвөрмөц байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

2. Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн.

3. Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна. Өндөр хөгжилтэй улсуудын бодит сонирхлыг Монголд бий болгох бодлого баримтлахын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ. Гадаад орнууд дахь Монголын сонирхлыг улс төр-эрх зүйн аргаар бататган хамгаална.

4. Монгол Улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахины болон бүс нутгийн улс төрийн байдалтай нягт уялдуулж тэргүүлэх чиглэл, зорилтыг нь тогтоохдоо уян хатан хандаж байна.

5. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байна.

6. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл хүмүүнлэгийн хүрээний гадаад харилцааны бодлого дотроос улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна.

II. МОНГОЛ УЛСЫН ГАДААД УЛС ТӨРИЙН БОДЛОГО

7. Монгол Улсын гадаад улс төрийн бодлого нь тус улсын аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх нэг гол хэрэглүүр бөгөөд түүний үр дүнг юуны өмнө тус улсын аюулгүй

байдал, тусгаар тогтнолын ашиг сонирхол хэрхэн хангагдаж, олон улсын байр суурь хэр бэхжиж, нэр хүнд нь хэрхэн өсч байгаагаар тодорхойлно.

8. Монгол Улс аливаа улстай харилцахдаа бие биеийн бүрэн эрхт байдл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, хүч үл хэрэглэх, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээг удирдлага болгоно.

9. Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо энхийг эрхэмлэж, улс гүрэнтэй сөргөлдөхгүй байхыг аль болохоор чухалчилж, олон тулгуурт бодлого явуулна. Үндэснийхээ ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт бусад улс, түншийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ. Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг шууд хөндөөгүй хөрш хоёр орныхоо маргаанд хөндлөнгөөс үл оролцоно. Цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй, гадаадын цэрэг, зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтална.

10. Монгол Улс олон улсын тавцанд ашиг сонирхлоо хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрээр батлагаажуулна. Олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ.

11. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхий дахины чанартай тулгамдсан асуудлыг шийвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйлсэд боломжийн хэрээр идэвхтэй хувь нэмэр оруулахыг чармайна. Чингэхдээ үндэсний ашиг сонирхол, үнэт зүйлс, тулгуур зарчмуудаа юуны өмнө удирдлага болгоно.

12. Монгол Улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ дараах чиглэлийг баримтална:

1/ ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана;

2/ Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Үүний хамт Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани, Нидерланд, Финланд, Австри, Швед, Швейцари зэрэг оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтална;

3/ Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн-хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарна. Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын аюулгүй байдлын механизм буй болгох үйл явцад идэвхтэй оролцоно. Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д элсэн орохыг зорино. Бүс нутгийн интеграцид орох нөхцөлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ;

4/ Монгол Улсын гадаад бодлогын дөрөвдэх чиглэл нь Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг санхүү-эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал байна;

5/ социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнууд, шинээр тусгаар тогтносон улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тав дахь чиглэл байна. Эдгээр улстай харилцахдаа өмнөх харилцааны нааштай өвийг бататгахыг чухалчлахын хамт харилцаагаа шинэ нөхцөлд

зохицуулан хөгжүүлэх бодит боломжийг харгалзан уян хатан хандана. Тухайлбал Дорнод Европоос Польш, Унгар, Чех улстай, мөн Казахстан, Украин, Беларусь, Киргизстан, Узбекистан улстай харилцаагаа түлхүү хөгжүүлэхэд анхаарна;

6/ хөгжиж байгаа орнуудтай найрсаг харилцаатай байж, нийтлэг зорилтоо шийдвэрлэх үүднээс бодит боломжийн хэмжээнд тэдгээртэй хамтран ажиллах явдал Монгол Улсын гадаад бодлогын зургаа дахь чиглэл байна. Энэ зорилтыг хоёр талын харилцааны хүрээнээс гадна голчлон олон улсын байгууллага, хөдөлгөөний хүрээнд, тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллага, "77"-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэгт хамтран ажиллах замаар хэрэгжүүлнэ.

13. Монгол Улсын гадаад улс төрийн бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож, гадаад улс төрийн бодлого хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

14. Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газарт эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн талаар өндөр мэдлэг боловсролтой боловсон хүчин оролцуулан томилж ажиллуулах зарчим баримтална.

III. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

15. Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны бодлогын үндсэн зорилго нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр тус Улсын эдийн засгийн хэтийн болон цаг үеийн зорилтыг зохистой шийдвэрлэхэд гадаад хүчин зүйлийг оновчтой ашиглах, улмаар улс орны эдийн засгийг бүс нутгийн интеграцид өөрийн гэсэн байр суурьтай болгоход оршино.

16. Гадаад улс орнуудтай эдийн засгийн харилцаа хөгжүүлэх, хамтран ажиллахдаа эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, аль нэг орноос хэт хараат байдалд орохоос сэрэмжлэхийн хамт олон улсын аж ахуйн харилцааны зарчим, хэм хэмжээг баримтлан эрх тэгш, харилцан ашигтай байх, хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, улс төрийн болон бусад даралт шахалтад автахгүй байх нөхцөл бүрдүүлэх бодлого явуулна.

17. Эдийн засаг, гааль, худалдааны тусгай бүс байгуулах, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай үйлдвэр байгуулах, концесс олгох зэрэг хөтөлбөрийг улс төр, эдийн засгийн үр дагаврыг нь нарийн тооцож үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй, эдийн засгийн үр ашигтай байхуйцаар ашиглана.

18. Үндэсний ашиг сонирхолд ихээхэн нөлөө бүхий төслийг хэрэгжүүлэхдээ хамтран ажиллах улс буюу түншийг улс төрийн ашиг сонирхлын үүднээс сонгохыг чухалчилна.

19. Гадаад өрийн асуудлыг улс орны эдийн засгийн аюулгүй байдалд хохиролгүйгээр зохицуулж, зээлийг эгүүлэн төлөх баталгааг нь нарийн тооцож зөв тогтоосны үндсэн дээр авч, үр дүнтэй ашиглана.

20. Монгол Улс эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ дараах үндсэн чиглэл баримтална:

1/ эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг улс орны эдийн засгийн чадавхи, экспортын чиглэлийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх, эдийн засгийн дэд бүтцийг бүрэлдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2/ Монгол Улсын эдийн засгийн түүхий эд зонхилсон чиглэлийг өөрчилж, оновчтой бүтцийг бүрэлдэхүүлэхэд чиглэсэн үндсэн салбаруудыг хөгжүүлэх шаардлагатай уялдуулан эрдсийн болон мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг хамгийн үр ашигтай хэмжээнд хүргэж, дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

3/ одоо байгаа үйлдвэрүүдийг орчин үеийн шилдэг техник, технологиор шинэчлэн тоноглох, хүнс, хөнгөн үйлдвэр, уул уурхай, хими, биотехнологи, шинэ материалын зэрэг экспортын чиглэлтэй аж үйлдвэрийг өөрийн орны түүхий эдэд тулгуурлан хөгжүүлэх чиглэл баримтлах;

4/ экспортын чадавхийг дээшлүүлэхдээ алт, зэс, молибден, уран зэрэг эрдэс түүхий эдийг боловсруулах, бзүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гадаад орнуудтай хамтран ажиллах;

5/ монголын экспортын бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөх;

6/ улс орны түлш-эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам тээврийн таатай нөхцөл бүрдүүлэх;

7/ олон улсын, ялангуяа Зүүн-хойд Азийн зам, тээвэр, мэдээлэл, харилцаа, холбооны сүлжээнд нэгдэж орох;

8/ импортыг орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлтэй дунд, жижиг үйлдвэрийг хөгжүүлэхэд гадаадын зээл тусламж, технологи авах бодлого баримтлах;

9/ монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх, материаллаг баазыг нь бэхжүүлж, үйлчилгээг дэлхийн түвшинд хүргэх;

10/ гадаад худалдааны нэн тааламжтай нөхцөл олох, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авах статусыг тодорхой хугацаанд хадгалах.

IV. ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНОЛОГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

21. Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны гол зорилго нь улс орны эдийн засаг, үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжлийн хөдөлгөгч хүч болохуйц, бүс нутаг, тив, дэлхийд өрсөлдөх чадвартай үндэсний шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн чадавхийг бүрэлдүүлж хөгжүүлэхэд гадаад хүчин зүйлийг бүрэн ашиглах явдал мөн.

22. Улс орны хүн хүчний болон байгалийн нөөц баялаг, нийгмийн онол, сэтгэлгээний түвшин, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн өвөрмөц соёл

иргэншлийн хэв шинжид тохирсон мэдлэг, оюуны сан хөмрөгийг дэлхийн шинжлэх ухаан, техник, технологийн ололтоор баяжуулах зарчмыг мөрдлөг болгоно.

23. Монгол Улс шинжлэх ухаан-технологийн салбарын гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн чиглэл баримтална:

1/ үйлдвэрлэл, үйлчилгээнд дэвшилт арга технологи нэвтрүүлэх. Чингэхдээ оюуны их багтаамжтай технологийг сонгон нэвтрүүлэхийг эрхэмлэх. Эрдэс түүхий эд, мал, ургамлын гаралтай түүхий эд, сэргээгдэх эрчим хүчний зэрэг технологийг нэвтрүүлэхэд түлхүү анхаарах;

2/ шинжлэх ухаан-технологийн үндэсний мэдээллийн сүлжээг олон улсын мэдээллийн сүлжээнд холбох;

3/ оюуны өмч, шинжлэх ухаан-техникийн салбарт хоёр болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

V. СОЁЛ, ХҮМҮҮНЛЭГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

24. Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны гол зорилго нь монгол туургатны соёл иргэншлийг хамгаалах, соёлын өвөрмөц өв уламжлалыг арвижуулж, дэлхийн соёлын нийтлэг ололтоор баяжуулах, түүх соёлын үнэт зүйлсээ сэргээх, хальж гарсан зүйлсийг сурвалжлан олох, шинэ нөхцөлд ажиллах чадвартай үндэсний боловсон хүчин бэлтгэх зэрэгт соёлын хамтын ажиллагааг чиглүүлэх, улс орноо гадаадад таниулах, Монгол Улсыг сонирхогч, талархагчдын эгнээг өргөтгөх, бусад орон дахь Монгол судлалыг хөхүүлэн дэмжих, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэхэд оршино.

25. Соёл, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахдаа төрийн болон ардын дипломатын аргыг хослуулах, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг баримтална.

26. Монгол Улс хүмүүнлэгийн салбарын гадаад харилцааг хэрэгжүүлэхдээ дараах чиглэл баримтална:

1/ гадаад орнуудтай эрх зүйн өргөн хамтын ажиллагаа хөгжүүлж, гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхол, аюулгүй байдлыг хамгаалах;

2/ хилийн чанадад орших монгол үндэстнүүдтэй харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд бие биеийгээ харилцан дэмжих, тэдний зүгээс Монгол Улсын хөгжил, дэвшилд үзүүлэх дэмжлэг туслалцааг авах;

3/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдэлд хор хөнөөл бүхий харгис урсгал, бүлгийн нөлөөллөөс урьдчилан сээрэмжлэх арга хэмжээ авч байх;

4/ зах зээлийн эдийн засаг, улс төр, эрх зүй, менежмент, маркетинг болон тус улсын шинжлэх ухаан-техникийн дэвшлийн тэргүүлэх чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад оюутан сургах, мэргэжлийн удирдах ажилтан, мэргэжилтэн бэлтгэхийг урьтал болгох, чингэхдээ олон улсын тусгай болон хөгжингүй орны төрөлжсөн сан, улсын ба хувийн их, дээд сургууль, байгууллагын зардлаар оюутан сургах, боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалуулах, нарийн мэргэшлийн ажилчин бэлтгэх, гадаадаас өндөр мэргэжлийн багш, эрдэмтдийг урьж ажиллуулах зэрэг боломжийг ашиглах;

5/ гадаад орны ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтын шилдэг арга технологи, зохион байгуулалтыг судлан тус улсын онцлогтой уян хатан хослуулан авч хэрэглэх;

6/ Монголын түүх, соёлын дурсгалт болон байгалийн өв, үнэт зүйлсийг нөхөн сэргээх, хамгаалах, улс түмний хүртээл болгох талаар түүх, шашин, соёлын нийтлэг өв бүхий Азийн орнууд, сонирхогч бусад орон, ЮНЕСКО, олон улсын холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах;

7/ боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллага, сангуудтай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн

байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтоон хөгжүүлэх, эрдэмтэн, багш, уран бүтээлч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, тамирчид, жуулчинд солилцох явдлыг дэмжих, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд үр ашигтай оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохиох;

8/ улс орны экологийн аюулгүй байдлыг хангах, экологийн тэнцвэрийг хадгалах, байгаль орчныг хамгаалах гадаад тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /2011/

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна.

Нөгөөтэйгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болов.

Монгол Улс ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, зах зээлийн эдийн засаг бүхий улс болж хөгжихийн хамт гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлж, гадаадад ажиллаж, сурч байгаа иргэдийн тоо үлэмж нэмэгдэв.

Монгол Улс нөөц баялгаа ашиглан эдийн засгийн чадавхийг өсгөх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх эрчимтэй хөгжлийн замд орж байна.

Дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын гадаад бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тус улсын гадаад, дотоод нөхцөл байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.
2. Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн.
3. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.
4. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна.
5. Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгална. Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, төрийн захиргааны төв болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцааг уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.
6. Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно.
7. Дэлхий, бүс нутагт нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд

орохоос сэрэмжилнэ.

8. Олон улсын харилцааны хөгжил, дэлхийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогын чиглэл, зорилтыг уян хатан тогтооно.

9. Монгол Улсын гадаад бодлого нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого, гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн харилцан уялдаа бүхий үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Улс төрийн гадаад харилцааны бодлого тодорхойлогч шинжтэй байна.

ХОЁР.УЛС ТӨРИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

10. Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцаа хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшинг дээшлүүлэх, олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

11. Монгол Улсад гадны цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх чиг шугам баримтална.

12. Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

13. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг чармайна. Тухайлбал:

- ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй оролцох;
- цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах, олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, НҮБ-ын болон олон улсын бусад энхийг дэмжих, сахиулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох;

- уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг багасгах, байгаль орчныг доройтлоос хамгаалах, гоц халдварт өвчний тархалтаас сэргийлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтыг дэмжин оролцох.

14. Монгол Улс улс төрийн гадаад харилцааны бодлого хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийг баримтална:

14.1. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах;

14.2. АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

14.3. Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох;

14.4. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах;

14.5. Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, "77"-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах.

15. Улс төрийн гадаад харилцааны бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож, гадаад бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулна.

16. Хөгжлийн эрэлт хэрэгцээ, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн гадаад бодлогын судалгаа, шинжилгээ, гадаад харилцааны мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл, сургалтын тогтолцоо бүрдүүлнэ.

17. Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газарт дипломат алба, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологийн талаар өндөр мэдлэг, боловсролтой, мэргэшсэн ажилтанг оролцуулан томилж, сэлгэн ажиллуулах бодлого баримтална.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

18. Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн.

19. Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ.

20. Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ.

21. Эдийн засгийн гадаад харилцааны бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.
Үүнд:

21.1. эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөхийг дэмжих;

21.2. уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх, түүнчлэн мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.3. түлш, эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх;

21.4. олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.5. монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, үйлчилгээг нь олон улсын түвшинд хүргэх, олон улсын сүлжээнд хамрагдах, соёлын бүтээгдэхүүнийг гадаадад борлуулахад дэмжлэг үзүүлэх;

21.6. гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэх;

21.7. бизнесийн таатай орчин бүрдүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний аж ахуйн нэгж гадаадад хөрөнгө оруулах, дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэх;

21.8. "Ногоон", "Цэнхэр" эдийн засгийг хөгжүүлэх, уул уурхайн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад дэмжлэг үзүүлэх;

21.9. экологийн аюулгүй байдлыг хангах, тэнцвэрийг хадгалах, байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх чиглэлээр хоёр талын болон олон талын хүрээнд хамтын ажиллагаа хөгжүүлэх, гадаад улс, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламж авах талаар идэвхтэй ажиллах;

21.10. далайд гарцгүй хөгжиж байгаа улсуудын эрх ашгийг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын бусад байгууллагын хүрээнд хамгаалах ажилд ахиц гаргах, их далайн нөөцөөс ашиглах боломжийг эрэлхийлэх.

ДӨРӨВ.

ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНОЛОГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

22. Орчин үеийн шинжлэх ухаан-технологийн үндэсний чадавхийг сайжруулах,

эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахад дөхөм үзүүлэх нь шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн.

23. Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

23.1. эрдэс болон хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулах, дэвшилтэт арга технологийг сонгон нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

23.2. эдийн засаг, нийгмийн салбарт инновац нэвтрүүлэх, цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглах чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тус тус дэмжлэг үзүүлэх;

23.3. мэдээллийн технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт, орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухаан-технологийн үндэсний мэдээллийн сүлжээг өргөтгөн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

23.4. эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлээр туршилт, сорилт явуулах бааз суурийг бэхжүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэхэд гадаадын тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэхийг эрмэлзэх;

23.5. олон улсад Монгол судлал өргөжин хөгжихийг дэмжиж, гадаадад Монгол судлалын төв байгуулахад туслалцаа үзүүлэх;

23.6. шинжлэх ухаан-технологи, оюуны өмчийн салбарт хоёр талын болон олон талын үндсэн дээр хамтын ажиллагаа хөгжүүлэх.

ТАВ. СОЁЛ, ХҮМҮҮНЛЭГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

24. Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын зорилго нь үндэсний соёл иргэншил, өвөрмөц өв уламжлалаа дэлхийн соёлын нийтлэг ололттой хослуулан хөгжүүлэх, түүх, соёлын үнэт зүйлээ хамгаалах, сэргээх, түүхэн шалтгаанаар гадаадад гарсан эд өлгийн зүйлийг сурвалжлан олоход чиглэсэн хамтын ажиллагаа хөгжүүлэх, нийгэм, хүмүүнлэгийн салбарын шууд харилцаанд тус дөхөм үзүүлэх явдал мөн.

25. Соёл, хүмүүнлэгийн салбарын гадаад бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

25.1. Түүх, соёлын дурсгалт болон үнэт зүйл, байгалийн өвийг хамгаалах, сэргээх

талаар гадаад улс, ЮНЕСКО, олон улсын холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж, дэлхийн соёлын болон байгалийн өв сангийн бүртгэлд өөрийн биет, биет бус өвийг хамруулахыг зорих;

25.2. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад ойртуулан сайжруулах, энэ талаар ахиц дэвшилд хүрсэн улсуудын туршлагыг судалж хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх;

25.3. Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

25.4. Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

25.5. Бусад улс дахь монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

ЗУРГАА. ГАДААДАД БАЙГАА ИРГЭДИЙНХЭЭ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГО

26. Гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бодлогын зорилго нь хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалахад оршино.

27. Гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

27.1. Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний хүрээнд хамгаалах;

27.2. Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн суугаа болон хавсран суугаа улсад амьдарч, ажиллаж, суралцаж байгаа

иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

27.3. иргэд гадаадад зорчих эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ тэд эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх;

27.4. гадаадад гэрээгээр ажиллаж байгаа иргэдийнхээ нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тухайн улстай хамтран ажиллах;

27.5. гадаадад байгаа иргэн гэнэтийн осол, халдлага, аюул, албадлагад өртөх, хүнд өвчин тусах, нас барах зэрэг тохиолдолд Монгол Улсаас тухайн улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар бололцоотой туслалцаа, дэмжлэг шуурхай үзүүлэх;

27.6. гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг ноцтой гэмт хэрэгт өртөхөөс сэрэмжлүүлэх, ийм төрлийн хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах чиглэлээр тухайн улсын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

27.7. гадаадад байгаа иргэддээ тэдний хууль ёсны эрх, эрх чөлөө, үүрэг, хариуцлагын талаархи болон шаардлагатай бусад мэдээлэл, зөвлөлгөө өгч байх;

27.8. гадаадад буй иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

ДОЛОО. ГАДААД СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ БОДЛОГО

28. Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино.

29. Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

29.1. Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын

ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих;

29.2. монголын түүх, байгаль, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан сурталчилгааны ном, товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэн бусад улс түмэнд түгээх, сурталчлах;

29.3. хоёр талын харилцааны хүрээнд гадаадад Монгол Улсыг сурталчилсан өдрүүд зохион байгуулах, үзэсгэлэн, яармаг гаргах, кино, урлагийн тоглолт үзүүлэх, уулзалт, ярилцлага зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

29.4. гадаад сурталчилгааг сайжруулахын тулд бусад улс, олон улсын байгууллагын нэр хүндтэй хүмүүс, улс төр, нийгэм, соёлын зүтгэлтэн, сэтгүүлч болон хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

29.5. Монгол Улсын талаар гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээ, мэдээллийг судалж байх;

29.6. Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны талаар олон нийт, хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг бодит мэдээллээр хангах, тэдний хүч бололцоог бусад улстай харилцаа, хамтын ажиллагаа хэвийн хөгжүүлэхэд чиглүүлэх;

29.7. гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлэхэд ардын болон соёлын дипломатын арга хэлбэрийг хэрэглэх;

29.8. энх тайван, найрамдлын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих.

